

АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛ ОЛГОХ ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙГ 2025 ОНЫ
ХИЧЭЭЛИЙН ЖИЛД **УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ЭМЧ** МЭРГЭЖЛЭЭР
ТӨГСӨГЧДИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТЫН
ЖИШИГ СОРИЛ - I

Сорилын зөв хариулт

1-E, 2-B, 3-B, 4-A, 5-A, 6-B, 7-A, 8-D, 9-B, 10-E, 11-A, 12-D, 13-C, 14-C, 15-E, 16-B, 17-C, 18-A, 19-E, 20-D, 21-C, 22-E, 23-A, 24-E, 25-D, 26-C, 27-E, 28-E, 29-C, 30-C, 31-B, 32-D, 33-D, 34-B, 35-A, 36-B, 37-C, 38-B, 39-C, 40-A, 41-A, 42-D, 43-E, 44-B, 45-B, 46-B, 47-B, 48-D, 49-B, 50-C, 51-A, 52-A, 53-B, 54-D, 55-A, 56-E, 57-D, 58-A, 59-D, 60-C, 61-C, 62-B, 63-A, 64-B, 65-A, 66-B, 67-C, 68-A, 69-D, 70-C, 71-A, 72-E, 73-B, 74-A, 75-D, 76-C, 77-C, 78-C, 79-C, 80-B, 81-B, 82-D, 83-B, 84-C, 85-A, 86-A, 87-B, 88-C, 89-B, 90-B, 91-D, 92-C, 93-C, 94-B, 95-D, 96-C, 97-D, 98-D, 99-B, 100-B, 101-A, 102-E, 103-A, 104-B, 105-D, 106-A, 107-C, 108-B, 109-D, 110-A, 111-D, 112-A, 113-D, 114-D, 115-B, 116-E, 117-E, 118-A, 119-A, 120-A, 121-C, 122-C, 123-A, 124-C, 125-D, 126-C, 127-B, 128-D, 129-D, 130-A, 131-A, 132-B, 133-D, 134-D, 135-D, 136-B, 137-B, 138-C, 139-B, 140-A, 141-C, 142-C, 143-C, 144-C, 145-E, 146-D, 147-A, 148-B, 149-A, 150-A, 151-A, 152-E, 153-A, 154-D, 155-C, 156-D, 157-E, 158-C, 159-A, 160-C, 161-B, 162-B, 163-B, 164-C, 165-B, 166-D, 167-C, 168-A, 169-D, 170-B, 171-A, 172-C, 173-A, 174-A, 175-A, 176-C, 177-D, 178-E, 179-D, 180-B, 181-A, 182-A, 183-A, 184-B, 185-C, 186-B, 187-E, 188-C, 189-C, 190-A, 191-B, 192-C, 193-E, 194-A, 195-D, 196-C, 197-B, 198-D, 199-B, 200-D, 201-B, 202-B, 203-C, 204-B, 205-C, 206-D, 207-E, 208-B, 209-B, 210-B, 211-A, 212-D, 213-B, 214-C, 215-B, 216-B, 217-C, 218-B, 219-C, 220-A, 221-A, 222-E, 223-C, 224-A, 225-B, 226-B, 227-A, 228-B, 229-D, 230-E, 231-B, 232-D, 233-B, 234-D, 235-E, 236-C, 237-A, 238-A, 239-A, 240-C, 241-D, 242-B, 243-B, 244-A, 245-B, 246-C, 247-C, 248-B, 249-D, 250-B, 251-B, 252-B, 253-C, 254-C, 255-D, 256-B, 257-C, 258-C, 259-C, 260-A, 261-B, 262-E, 263-A, 264-D, 265-A, 266-E, 267-C, 268-C, 269-B, 270-C, 271-B, 272-C, 273-C, 274-B, 275-A, 276-B, 277-A, 278-A, 279-C, 280-D, 281-A, 282-A, 283-D, 284-B, 285-A, 286-E, 287-B, 288-D, 289-D, 290-A, 291-C, 292-C, 293-B, 294-B, 295-A, 296-E, 297-D, 298-B, 299-D, 300-E, 301-E, 302-D, 303-D, 304-E, 305-D, 306-C, 307-B, 308-A, 309-C, 310-B, 311-A, 312-A, 313-D, 314-A, 315-B, 316-C, 317-B, 318-C, 319-B, 320-D, 321-D, 322-E, 323-C, 324-D, 325-D, 326-A, 327-B, 328-D, 329-D, 330-E, 331-D, 332-C, 333-E, 334-B, 335-C, 336-D, 337-A, 338-B, 339-E, 340-B, 341-B, 342-A, 343-A, 344-A, 345-D, 346-B, 347-C, 348-C, 349-E, 350-E, 351-D, 352-D, 353-B, 354-E, 355-E, 356-C, 357-D, 358-C, 359-A, 360-D, 361-A, 362-D, 363-D, 364-B, 365-B, 366-A, 367-E, 368-C, 369-D, 370-D, 371-A, 372-C, 373-D, 374-E, 375-C, 376-B, 377-C, 378-D, 379-D, 380-D, 381-B, 382-B, 383-C, 384-D, 385-D, 386-A, 387-A, 388-A, 389-D, 390-B, 391-A, 392-E, 393-D, 394-C, 395-C, 396-C, 397-A, 398-B, 399-D, 400-B, 401-E, 402-B, 403-C, 404-C, 405-E, 406-C, 407-A, 408-C, 409-B, 410-B, 411-C, 412-A, 413-D, 414-C, 415-D, 416-B, 417-D, 418-C, 419-E, 420-B, 421-D, 422-A, 423-B, 424-C, 425-C, 426-B, 427-A, 428-A, 429-D, 430-B, 431-C, 432-B, 433-C, 434-A, 435-A, 436-B, 437-A, 438-C, 439-E, 440-E, 441-E, 442-D, 443-C, 444-C, 445-E, 446-E, 447-C, 448-B, 449-A, 450-B, 451-E, 452-B, 453-B, 454-B, 455-B, 456-A, 457-C, 458-C, 459-A, 460-A, 461-C, 462-B, 463-C, 464-B, 465-E, 466-B, 467-B, 468-A, 469-B, 470-E, 471-B, 472-A, 473-A, 474-B, 475-C, 476-A, 477-A, 478-B, 479-C, 480-A, 481-A, 482-D, 483-B, 484-D, 485-C, 486-D, 487-D, 488-C, 489-D, 490-A, 491-A, 492-E, 493-C, 494-A, 495-C, 496-E, 497-E, 498-C, 499-D, 500-E, 501-D, 502-D, 503-C, 504-A, 505-B, 506-D, 507-D, 508-C, 509-A, 510-A, 511-A, 512-A, 513-A, 514-A, 515-B, 516-D, 517-E, 518-A, 519-D, 520-A, 521-E, 522-D, 523-A, 524-D, 525-D, 526-C, 527-D, 528-A, 529-D, 530-D, 531-D, 532-D, 533-D, 534-A, 535-A, 536-D, 537-C, 538-C, 539-A, 540-E, 541-B, 542-D, 543-D, 544-E, 545-C, 546-C, 547-A, 548-E, 549-C, 550-B, 551-A, 552-A, 553-A, 554-C, 555-A, 556-C, 557-A, 558-A, 559-A, 560-A, 561-A, 562-C, 563-A, 564-E, 565-C, 566-A, 567-E, 568-C, 569-C, 570-B, 571-E, 572-C, 573-B, 574-D, 575-B, 576-E, 577-B, 578-C, 579-C, 580-A, 581-C, 582-A, 583-D, 584-C, 585-D, 586-E, 587-B, 588-C, 589-C, 590-C, 591-E, 592-B, 593-C, 594-A, 595-D, 596-C, 597-D, 598-A, 599-D, 600-B, 601-C, 602-A, 603-C, 604-D, 605-D, 606-A,

607-E, 608-D, 609-B, 610-C, 611-C, 612-B, 613-B, 614-A, 615-B, 616-D, 617-C, 618-B, 619-C, 620-A, 621-A,

Сорил хариулах заавар:

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, Е гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)
 - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (А.)
 - 1 ба, 3 дугаар хариултууд зөв бол (В.)
 - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (С.)
 - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
 - Бүх хариулт зөв бол (Е.)
3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
 - Зөв, Зөв, Зөв (А.)
 - Зөв, Зөв, Буруу (В.)
 - Зөв, Буруу, Буруу (С.)
 - Буруу, Зөв, Буруу (D.)
 - Буруу, Буруу, Буруу (Е.)

::A01::Бөөрний архаг өвчний 3-р үед ТШХ яаж өөрчлөгдөх вэ?

- A. ТШХ бага зэрэг буурсан 60-89 мл/мин
 - B. ТШХ бага зэрэг буурсан 30-60 мл/мин
 - C. ТШХ буурсан 30-59 мл/мин
 - D. ТШХ буурсан 30-49 мл/мин
 - E. ТШХ маш их буурсан 15-29 мл/мин
- { ~A ~B =C ~D ~E }

/1./ Шар усны өвчний шээсний өнгөний онцлог шинжийг тогтооно уу

- A. Тод шар өнгөтэй
- B. Цөөрмийн ус шиг хөхөвтөр өнгөтэй
- C. Цагаан цайвар өнгөтэй
- D. Тод улаан өнгөтэй
- E. Энгэсгийн зайлдас шиг өнгөтэй

/2./ Номлохуйн үндэст зааснаар өвчнийг ёсчлон ялгах гэсэн нь аль болохыг тогтооно уу

- A. өвчин өөр, өөрийнх нь үүсгэх нөхцөлтэй учрах
- B. өвчний шинж тодорхой болсон үе
- C. өвчнийг дотор зуураар нь ялгах
- D. өвчний шинж тэмдэг тодроогүй үе
- E. өвчний хүч

/3./ Шар өвчний судасны лугшилтын онцлог ямар болхыг тогтооно уу

- A. Хөндий хоосон үе үе зогсох
- B. Нарийн эрчимтэй
- C. Живэнгүй дорой
- D. Товойж хуйлрах
- E. Чичирч гүйхэд бэрх

/4./ Хөгшид нялхас тамир тэнхээ сул дорой, дусал цус барагдсан зэрэгт эмчилгээний үр дүн сайтай жүдлэнг сонгоно уу?

- A. Жоншны
- B. Брагшуны
- C. Мөнгөн усны
- D. Тосны

Е. Дагдан үүгийн

/5./ Шингэлт муудах, хэхрэх, ходоод хөших, шим үл авах нь ямар бадгана өвчний үед илрэх шинж болохыг тогтооно уу

- А. Ялзлагч бадгана
- В. Амсуулагч бадгана
- С. Барилдуулагч бадгана
- Д. Хангагч
- Е. Шүтүүлэгч

/6./ Хэл нь хуурай, ширүүн, өнгөргүй богино болох нь зүрхний ямар өвчний үед тохиолдож болохыг тодорхойлно уу?

- А. Зүрхний халуун дэлгэрэх
- В. Зүрхэнд халуун үймэлзэх
- С. Зүрхэнд халуун нуугдах
- Д. Зүрхний хатгалга
- Е. Зүрхний шар ус

/7./ Бодитой хорын өвчний ангилалыг тодорхойлно уу

- А. Үл гүйх хор, гүйх хор
- В. Сүүт уриангуй, хүн хормс, амьтны хор
- С. Галзуу нохой, могой, зөгий, адууны үс
- Д. Бона, чонын хор, ямааны хор
- Е. Шинэ, хуучин хорын өвчин

/8./ Шарын өвчний судасны лугшилтын онцлогийг тогтооно уу

- А. Нарийн түргэн
- В. Бүдүүн чанга
- С. Хуйларсан эрчимтэй
- Д. Нарийн эрчимтэй
- Е. Усан засал

/9./ Гадар шинж нь халуун, мөн чанар нь хүйтэн өвчний шээсний хөөсөнд гарах шинжийг тогтооно уу?

- А. Хөөс их
- В. Хөөс удаан арилах
- С. Хөөс түргэн арилах
- Д. Хөөсгүй
- Е. Хутгавал бага зэрэг хөөсрөх

/10./ Дараах өвчнүүдээс бадганы махбодын хямралаар өвчлөх ёс нь үүсдэг өвчнийг сонгоно уу?

- А. Ходоодны хий
- В. Ходоодонд шар унасан
- С. Ходоодонд цус унасан
- Д. Хор харшсан
- Е. Төмөр хагт бадгана

/11./ Бодитой хорын өвчний ангилалыг тогтооно уу

- А. Үл гүйх хор, гүйх хор
- В. Сүүт уриангуй, хүн хормс, амьтны хор
- С. Галзуу нохой, могой, зөгий, адууны үс
- Д. Бона, чонын хор, ямааны хор
- Е. Шинэ, хуучин халуун өвчин

/12./ Зүрх амин судсанд нөлөөлдөг ямар цайвар хаван байдгийг тогтооно уу

- А. Э лэгний цайвар хаван
- В. Дэлүүний цайвар хаван
- С. Уушгины цайвар хаван
- Д. Хийний цайвар хаван
- Е. Шар усны цайвар хаван

/13./ Бэлхүүснээс доош бүх бие өвдөх, ханиаж найтаахад сүүжний нүхээр хатгуулах шинжээр илэрдэг бөөрний өвчнийг сонгоно уу

- А. бөөрний дарган

- В. сувагт унах
- С. бөөрний хэрх
- Д. доод биед унасан
- Е. бөөрний хий

/14./ “Анагаах ухааны 4 үндэс” зохиолын “Номлохуйн үндэс”-т заасанчлан гал тэгшитгэгч хийн өвчний үе дэх эм уух ёсыг сонгоно уу?.

- А. Идээ эс идсэн цагт
- В. Идээний өмнө
- С. Идээний дунд
- Д. Идээний эцэст
- Е. Идээний завсарт

/15./ Халуун боловсорсны шинжийг олно уу.

- А. Судлын бүдүүн нь нарийн болох
- В. Дээрээ бүдүүн доороо шургаж живэнги болох
- С. Шээсний язмаг нь нилэнхүйдээ болох
- Д. Шээсний өнгө нь цайвар шар болох
- Е. Язмаг нь хэсэглэн бөөгнөрөх

/16./ Эрүүл шээсний өнгө ямар болохыг тогтооно уу

- А. Шар
- В. Цайвар шар
- С. Цайвар
- Д. Бор
- Е. Өтгөн улаан

/17./ Эмэгтэйчүүдийн хий бүрэлдсэн өвчин ямар эрхтэнд нөлөөлхийг сонгоно уу

- А. Гэдэс
- В. Цөс
- С. Бөөр
- Д. Дэлүү
- Е. Элэг

/18./ Хоолой өвдөх, халуурах, ам хатах, үг ярихад дуу гарахгүй болох шинж илэрвэл ямар махбод хямралдсан дуу хаагдах өвчин болохыг тогтооно уу

- А. Шараас
- В. Бадганаас
- С. Хийнээс
- Д. Цуснаас
- Е. Барагдуулагчаас

/19./ Намрын улиралд идэвхжсэн эрхтэний судас хэрхэн лугшихийг тодорхойлно уу

- А. Богширгын дуу мэт нарийн эрчимтэй
- В. Хөхөөний дуу мэт бүдүүн уртлаг
- С. Чүүчлын дуу мэт зөөлөн алгуур
- Д. Хитрүүний дуу мэт охор зөөлөн
- Е. Бүдэнгийн дуу мэт огцом ширүүн

/20./ Эс шингэснээс үүсдэг шинэ архаг өвчнүүдийг тодорхойлно уу?

- А. Ходоод тэлэгдэх
- В. Бэтэг
- С. Цайвар хаван
- Д. Аюулхайн бадгана
- Е. Барагдуулагч их архаг

/21./ Хуучирсан халуунд тохирох эмчилгээг сонгоно уу?

- А. Хонилон 6 өгч цул савын судал ханах
- В. Халуун их бол гавар 9 өгөх
- С. Жонлон 5 хүйтнээр өгөх
- Д. Чацаргана 5- аар цэрийг татах
- Е. Сантал 25- аар хатаах

/22./ Чанга судасны эсрэг ямар судас байдгийг олно уу

- А. Живэнги

- B. Сулхан
- C. Балархай
- D. Алгуур
- E. Хоосон

/23./ Чулууны тунгалаг жонш юуны тэжээл болохыг тогтооно уу

- A. Ясны тэжээл
- B. Бөөрний тэжээл
- C. Өөхний тэжээл
- D. Шимийн тэжээл
- E. Махны тэжээл

/24./ Ходоодонд оршсон борыг эмчлэхдээ аль жор үр дүнтэй болохыг тодорхойлно уу

- A. Мана 4, гиван 9
- B. Индра 4
- C. Дэгд 4
- D. Жуган 8
- E. Мана 4, анар 4 хавсруулан өгнө

/25./ Зүрхний цусан хатгалга өвчний хүндрэл нь аль болохыг тодорхойлно уу

- A. Ам муруйх
- B. Хий цусаар дээш хөөрөх
- C. Солио
- D. Зүрх цусаар дүүрэх
- E. Ухаан алдах

/26./ Уушгины мэнгэр юунаас шалтгаалж үүсдэг болохыг тодорхойлно уу

- A. Уушгины хөндийд шар ус хуралдах
- B. Уушгинд хий цугларах
- C. Уушгинд бадгана салс ихсэх
- D. Уушгинд цус хямрах
- E. Уушгинд халуун дэлгэрэх

/27./ Шар өвчний шээсний хувирах ёсыг тогтооно уу?

- A. Ёроолоосоо хувирна
- B. Захаасаа хувирна
- C. Хувирахгүй
- D. Дээд гүехэн талаасаа хувирна
- E. Голоосоо хувирна

/28./ Цанхайх, хэхрүүлэх, идээ үл шингэх, идсэн дарууд өвдөх, идээнд ховдог болох нь ходоодны ямар өвчний шинж болохыг тогтооно уу

- A. Ходоодны шар унасан
- B. Ходоод тэлэгдсэн
- C. Ходоод сулрах
- D. Ходоодны хий
- E. Ходоодны бадгана

/29./ Гүвдрүү нь шүр олмостой адил бөгөөд маш их халуурч өвдөх, цус элбэг гарах зэрэг шинж нь ямар хэлбэрийн шамбарам өвчний үед илрэхийг сонгоно уу

- A. Хийн шамбарам
- B. Шарын шамбарам
- C. Цусны шамбарам
- D. Бадганы шамбарам
- E. Хурмалын шамбарам

/30./ Элэгний цайвар хаван өвчний үед ямар махбод илүү хямралдсныг тогтооно уу

- A. Цус
- B. Бадган
- C. Шар
- D. Нян хорхой
- E. Шар ус

/31./ Шээс чавдагшрах доод бие хүйт оргих бэлхүүсээр шархирах шинж нь бөөрний ямар өвчний үед илэрдгийг тогтооно уу

- A. Бөөрний халуун
- B. Бөөрний архаг
- C. Бөөрний хий
- D. Бөөрний дарган
- E. Бөөрний бадгана

/32./ Доорх бэлгэ чанаруудаас аль нь галын илчийн сурвалж болох вэ?

- A. хурц
- B. тослог
- C. хөнгөн
- D. халуун
- E. чийрэг

/33./ Нөхцөлийн эрхээр эс боловсорсон үеийн халуун сарнисанд гавар- 25 ыг хэзээ өгөхийг сонгоно уу

- A. Эхлээд өгөх
- B. Зөөлөн туулга өгсний дараа өгөх
- C. Бие зовиурлахаа зогсвол өгөх
- D. Сэрүүнийг хүсэх үед өгөх
- E. Өвчний сүүлд өгөх

/34./ Судас эс бүрдсэний шинжийг юугаар тодорхойлж болхыг тогтооно уу

- A. Судасны лугшилтаар
- B. Эрхтэний цэцгээр
- C. Өвчний шээсээр
- D. Судасны хувиралтаар
- E. Гарах хирээр нь

/35./ Эмэгтэйчүүдийн цус бүрэлдсэн өвчний хүндрэл аль болохыг сонгоно уу

- A. Бэтэг өвчин
- B. Хаван
- C. Цус алдалт
- D. Солио
- E. Мэдрэлийн уяман өвчин

/36./ Халуун өвчний гадар шинжийг хэрхэн тодорхойлхыг тогтооно уу

- A. Туслах хорлохын үүднээс нь
- B. Хөдөлгөх нөхцлийн үүднээс нь
- C. Бэлгэ чанараар нь
- D. Төрөн түгэх нөхцөлөөр нь
- E. Өвдөлтийн хүчээр нь

/37./ Бэтэг эвдрэх үед ямар шинж гарахыг тогтооно уу?

- A. Судас шээсэнд хүйтний шинж илрэх
- B. Ам хатах, дуршил буурах
- C. Зөөлөрч өвдөлт багасах, судас шээсэнд халууны шинж илрэх
- D. Толгой өвдөх, бөөлжих
- E. Цусаар суулгах, ам гашуурах

/38./ Зуны улиралд үйл ажиллгаа нь идэвхжсэн эрхтэний судас хэрхэн лугшихыг тодорхойлно уу

- A. Богширгын дуу мэт нарийн эрчимтэй
- B. Хөхөөний дуу мэт бүдүүн уртлаг
- C. Чүүчлын дуу мэт зөөлөн алгуур
- D. Хитрүүний дуу мэт охор зөөлөн
- E. Бүдэнгийн дуу мэт огцом ширүүн

/39./ Эс шингэсэн хөших өвчний эмчилгээг зөв сонгоно уу?

- A. Дотор шагайны лугших судсыг төөнөх
- B. Задийн тосон эм өгөх
- C. Мана 4 өгөх
- D. Норов 7
- E. Зөөлөн шимтийг өгөх

/40./ Эрүүл эм судасны лугшилтыг халууны ямар судастай эндүүрч болхыг тогтооно уу

- A. Эрчимтэй нарийн судас
- B. Эрчимтэй хуйларсан судас
- C. Эрчимтэй дэлгэрэнгүй судас
- D. Эрчимтэй түргэн судас
- E. Эрчимтэй хатуу судас

/41./ Ясны хэрх өвчний үед ямар гэм илүү давамгайлах вэ?

- A. Хий
- B. Нян
- C. Хижиг
- D. Хор
- E. Хорхой

/42./ Толгой дүйрэх, нүд бүрэлзэх, чих бөглөрөх, найтаах, нус цэр элбэгших, зулай хүндрэх нь ямар бадган өвчний үед илэрдэг болохыг тогтооно уу?

- A. Ялзлагч бадган
- B. Амсуулагч бадган
- C. Барилдуулагч бадган
- D. Хангагч
- E. Шүтүүлэгч

/43./ Бөөрний өвчний шээсний язмагын онцлог шинжийг тогтооно уу

- A. Үс бутарсан адил нарийн
- B. Хөвөн мэт зузаан
- C. Хялгас мэт нарийн жижиг
- D. Язмаг нь үүл адил
- E. Элс шиг ёроолдоо тунана

/44./ Идээ идсэний сүүлээр элгэн дээр өвддөг халуун исгэлэн усаар бөөлждөг элэгний ямар өвчин байдгийг сонгоно уу

- A. Элэг дэлгэрэх
- B. Элэг доройтох
- C. Хор харших
- D. Элэг унах
- E. Элэгний хар хэрх

/45./ Зүрх будангуйрах, зүрх долгиох өвчинд ямар адил шинж байдгийг тогтооно уу

- A. Өтгөн хатах
- B. Мартамхай болох
- C. Нойр ихдэх
- D. Зүрхний өвдөлт
- E. Суулгах

/46./ Гадагш сарнисан усан хавангийн ангиалд багатах хаван аль болохыг тодорхойлно уу

- A. Элэг, дэлүүнээс цувирсан усан хаван
- B. Ус, цус сарнисан усан хаван
- C. Бөөрнөөс цувирсан усан хаван
- D. Гэдэс нэвчирсэн усан хаван
- E. Бэтгээс цувирсан усан хаван

/47./ Ходоод шар усаар дүүрч бие хүндрэн тамир хүч буурах нь ямар өвчний шинж болохыг тодорхойлно уу

- A. Шингээгч шарын өвчин
- B. Өнгө урвуулагч шар
- C. Бүтээгч шар
- D. Үзүүлэгч шар
- E. Өнгө тодруулагч шар

/48./ Завсрын 72 хоногт идэвхжсэн эрхтэний судас хэрхэн лугшихийг тодохойлно уу

- A. Богширгын дуу мэт нарийн эрчимтэй
- B. Хөхөөний дуу мэт бүдүүн уртлаг
- C. Чүүчлын дуу мэт зөөлөн алгуур
- D. Хитрүүний дуу мэт охор зөөлөн
- E. Бүдэнгийн дуу мэт огцом ширүүн

/49./ Бөөрний өвчний халуун хүч бага үед ямар аргаар эмчилдгийг тогтооно уу.

- A. Эм, идээ,явдал, засал дөрвийг нэгтгэх
- B. Эм, идээ,явдал, засал дөрвөөр ээлжлэх
- C. Эм, заслаар засах
- D. Заслаар засах
- E. Эмээр эмчлэх

/50./ Эс шингэсэн ходоодны бадган өвчнөөс үе мөчинд шунасан ямар өвчин үүсдгийг тогтооно уу

- A. Аюулхайн бадган
- B. Галын илч буурсан бадган
- C. Цагаан хэрх бадган
- D. Хоолой хаагдах бадган
- E. Шингэн хатаагч бадган

/51./ Махны хорын өвчний шинж тэмдгийг тогтооно уу?

- A. Хоолой хаагдах нүд юм үзэхгүй болох
- B. Өтгөний мөр хаагдах
- C. Толгой өвдөх
- D. Бөөлжис цутгах
- E. Цусаар шээх

/52./ Цусан сарнилтын усан хаван өвчний үүсэх ёсыг тогтооно уу

- A. Эс шингэсэн тунгалаг элгийг дамжихдаа тунгалаг болж чадаагүй
- B. Эс шингэснээр ходоодонд бадган салс цугларсан
- C. Уруу арилгагч хийн мөр хаагдаснаас шээс тунгалгийн гүйх сүвэнд орсон
- D. Шээс тунгалгийн мөрт алддагдсан
- E. Цус цалгисан

/53./ Элэгний хар өрц өвчний хүндрэл нь ямар эрхтэнд нөлөөлхийг сонгоно уу

- A. Бүлх шөрмөсөнд
- B. Зүрх амин судсанд
- C. Дэлүү
- D. Ходоод
- E. Гэдэс

/54./ Дэлгэрсэн халууны ерөнхий шинжийг олно уу

- A. Эхэндээ даарч бие нь сулрах
- B. Олон бөөлжих
- C. Хөлс бага үнэргүй
- D. Шүдэнд хаг тогтох
- E. Уруул царай хумс нь хөхрөх

/55./ Хүйтнээр булингартахад ямар шинж илрэхийг тогтооно уу

- A. Ходоод цанхайх шингээх хүч муу байх
- B. Судал нарийн эрчимтэй
- C. Шээс улаан шар, тунгалаг
- D. Нүд улайх
- E. Цагаан нүд хөхөлбөр

/56./ Өвлийн улирлын эхний 72 хоногт ямар эрхтэний судас дэлгэрэхийг тогтооно уу

- A. Зүрх
- B. Уушги
- C. Дэлүү
- D. Элэг
- E. Бөөр

/57./ Доорх шинж тэмдгүүдээс хий махбод арвидсан, өвчний бэлгэ чанарт гарах өөрчлөлтийг тогтооно үү?

- A. Судас хөндий хоосон, сэтгэл санаа тогтворгүй, дэмийрэх
- B. Санаа алдах, толгой эргэх, чих шуугих, эхүүн амт амтагдах
- C. Хэсэж хатгуулах, яс хугарах, арьс мах салах шиг, үе мөч хүлэгдсэн, занчигдсан мэт болох
- D. Бие хатингартан харлах, дулаанд таатай, бие чичрэх, хэвлий хөөх

- Е. Шар үс зарайж , жихүүцэх, эвшээн чичэрч суниахад дуртай болох
- /58./ Ходоодны өвчнүүдээс үргэлжлэн тасралтгүй өвдөх шинж тэмдгээр илэрдэг ямар өвчин байдгийг тогтооно уу
- А. Ходоод суларсан
 - В. Ходоод тэлэгдсэн
 - С. Ходоод доройтсон
 - Д. Ходоодны хий
 - Е. Ходоодны бадгана
- /59./ Тогтох хэлбэрийн бор өвчин нуугдах үед илрэх шинж тэмдэгийг тогтооно уу?
- А. Их ундаасах
 - В. Хэвлийгээр өвдөх
 - С. Амьсгал давхцах
 - Д. Үе үе цанх мэт өвдөх
 - Е. Судас бүдүүн эрчимтэй
- /60./ Эс боловсорсон халууныг анагаах цагийг тогтооно уу
- А. Халууныг хүсэх цагт
 - В. Хэлний үзүүр дээш матийсан үед
 - С. Даарахаа болих цагт
 - Д. Шөнөдөө нойр их өвдөлт бага үед
 - Е. Ам цангах шинж гарах үед
- /61./ Давсагны өвчний гол шалтгааныг сонгоно уу
- А. Цус
 - В. Шар
 - С. Бадган
 - Д. Шар ус
 - Е. Нян
- /62./ Тэнсэх танг олно уу?
- А. Сэндэн 9
 - В. Хонины боривны ганц тан
 - С. Гурван үрийг бурамтай өгөх
 - Д. Гурван үр дээр жүр үр нэмж өгөх
 - Е. Манагчинбуу
- /63./ Тунгалаг эс шингэсэн өвчний үед ямар шинж илрэхийг тогтооно уу
- А. Дур хаагдах, дотор алжаах,мах хатингартах, зүрх хавиргаар өвдөх
 - В. Гашуун исгэлэн усаар гулгих, гэдэс дүүрэх
 - С. Хоолны шингээлт муудах, шар зүйлээр суулгах
 - Д. Дотор хөөх, халуун хүйтэнд тэсэшгүй өвдөх
 - Е. Толгой эргэх, чичирч амьсгаадах,үе мөч хөших
- /64./ Жирэмсний судсыг өвчний ямар судастай эндүүрч болхыг тодохойлно уу
- А. Хуйларсан эрчимтэй судас
 - В. Хуйларсан чанга судас
 - С. Хуйларсан дэлгэрэнгүй судас
 - Д. Хуйларсан түргэн судас
 - Е. Хуйларсан хатуу судас
- /65./ Хүйтэн чанартай усан хаван өвчний үед илрэх шинж тэмдгийг тогтооно уу?
- А. Бүх бие хавагнах
 - В. Хэвлий томорч, судас нь гүрвийх
 - С. Үе мөч хатингартах
 - Д. Ам цангах
 - Е. Шээс нь улайх
- /66./ Хоосорсон халууны эмчилгээний зарчмыг тогтооно уу?
- А. Хөшсөнийг чийгээр дэвтээх
 - В. Хатуу хүчээр дарах
 - С. Сүүлд нь хорын модыг үндсээр нь гаргах
 - Д. Зөөлөн, ширүүн ерөндгөөр сүүлийг арилгах
 - Е. Сүүлд нь дэгдийн найрлага өгөх

/67./ Бор өвчний судасны лугшилтын онцлог ямар болхыг тогтооно уу?

- A. Хөндий хоосон үе үе зогсох
- B. Нарийн эрчимтэй
- C. Ганы судас балархай
- D. Товойж хуйлрах
- E. Чичирч гүйхэд бэрх

/68./ Ямар амттай хоол унд ундаасах өвчнийг үүсгэхийг тогтооно уу

- A. Исгэлэн давслаг
- B. Халуун эхүүн
- C. Амтлаг гашуун
- D. Гашуун амт
- E. Халуун амт

/69./ Идсэний дараа баруун хавирганы нуман доогуур өвдөх, хар шүлс асгарах, дотор муухайрах нь бадган ямар эрхтэнд буусных шинж болохыг тогтооно уу

- A. Дэлүү
- B. Ходоод
- C. Цөс
- D. Элэг
- E. Гэдэс

/70./ Муурын хоолой мэт хоржигнон дуугарах шинжээр илэрдэг уушгины ямар өвчин байдгийг тодорхойлно уу

- A. Уушгины ус алдах
- B. Дагшуур
- C. Уушгины архаг
- D. Мэнгэр
- E. Уушигны халуун

/71./ Тунгалагийн ус сарнисан хүйтэн усан хаван өвчний эмгэг жамыг тодорхойлно уу

- A. Тунгалагийн мөрт хүйтэн шар ус алдагдах
- B. Эс шингэснээр ходоодонд бадгана салс цугларсан
- C. Уруу арилгагч хийн мөр хаагдснаас шээс тунгалагийн гүйх сүвэнд орсон
- D. Шээсийг тунгалагийн мөрт алдсан
- E. Элгэнд цус цалгисан

/72./ Дур амаргүй болох, цээжээр тэлэгдэх, ар өврөөр хатгуулах, дотор халах, исгэлэн усаар гулгих, дур хаагдах нь ямар бадган өвчний үед илрэх шинж болохыг тодорхойлно уу

- A. Ялзлагч
- B. Амсуулагч
- C. Барилдуулагч
- D. Хангагч
- E. Шүтүүлэгч

/73./ Бадган хийг боловсруулах танг олно уу

- A. Дэгд сүм тан
- B. Мана 4 тан
- C. Брайву 9
- D. Сэндэн 9 тан
- E. Гавар 25

/74./ Шар өвчний шээсний өнгөний онцлог шинжийг тогтооно ууц

- A. Тод шар өнгөтэй
- B. Цөөрмийн ус шиг хөхөвтөр
- C. Цагаан өнгөтэй
- D. Тод улаан өнгөтэй
- E. Энгэсгийн зайлдас мэт өнгөтэй

/75./ Сэнгэр 15- ийг олгойн ямар өвчинд тохирхийг сонгоно уу

- A. Олгойн бадгана
- B. Олгойн хий
- C. Олгойн хорхой
- D. Олгойн халуун

Е. Олгойн бор

/76./ Гал сацуу хийн гүйх мөр хаагдснаас дотор хөөж дүүрэх, байнга зовиурлах, хэхэрч чадахгүй болох нь ямар өвчний эс шингэсэн өвчний шинж болохыг тогтооно уу

- А. Эс шингэснээр хэхрэх
- В. Эс шингэснээр хөших
- С. Эс шингэсэн бадгана салс
- Д. Эс шингэсэн хор мэт
- Е. Тунгалаг эс шингэсэн

/77./ Эрүүл эр судасны лугшилтыг халууны ямар судастай эндүүрч болхыг тогтооно уу

- А. Эрчимтэй судас
- В. Нарийн судас
- С. Дэлгэрэнгүй судас
- Д. Эрчимтэй нарийн судас
- Е. Хуйларсан судас

/78./ Цайвар хаван өвчний үед хэрэглэх идээ ундааг тодорхойлно уу

- А. Загасны мах
- В. Ямааны мах
- С. Тутрага
- Д. Гахайн мах
- Е. Шинэ бурам

/79./ Тэнсэх эмчилгээ хийхэд хэл нь нойтон, амьсгал тэгш, ундаасах нь бага, нойр ихсэх зэрэг шинж гарвал ямар өвчин болохыг сонгоно уу

- А. Зөөлнөөр хоосрох халуун өвчин
- В. Хоосорсон халуун өвчин
- С. Хайлж царцах боомтын өвчин
- Д. Уушиг зүрхний хоосон өвчин
- Е. Хийн хижиг өвчин

/80./ Ундаасах өвчний үед ямар махбод хямрахыг тогтооно уу

- А. Бадгана, хий
- В. Хий шартай хавсрах
- С. Дээш гүйгч хий шартай хавсрах
- Д. Түгмэл гүйгч хий бадганатай хавсрах
- Е. Цус шар хавсрах

/81./ Ундаасах нь бага, хэл хүйт оргих, уруул өвдөх, дуу сөөх, идээнд үл дурлах нь ямар өвчний үед илрэх шинж болохыг тогтооно уу?

- А. Ялзлагч бадгана
- В. Амсуулагч бадгана
- С. Барилдуулагч бадгана
- Д. Хангагч бадгана
- Е. Шүтүүлэгч бадгана

/82./ Дагшиж ханиах нь ямар махбод хямралдсанаас үүсч болохыг тогтооно уу

- А. Цус
- В. Шар
- С. Шар ус
- Д. Хий
- Е. Бадгана

/83./ Шар хураагдсаны шинжийг тодорхойлно уу

- А. Нүд,шээс шарлах, ам гашуу оргих
- В. Нүд, шээс , нүүрний өнгө урьдахаас цайх
- С. Нүд, шээс , нүүр цайвар
- Д. Нүд, шээс , царай харлах

/84./ Хавагнах, шарлах, хар хүрэн өнгөтэй зүйлээр бөөлждөг элэгний ямар өвчин байдгийг сонгоно уу

- А. Элэг дэлгэрэх
- В. Элэг бүдүүрэх
- С. Хор харших

- D. Элэг унах
- E. Элэгний хар хэрх

/85./ Судасны дээр хавдах чимчигнэж өвдөх, судас өнгөө алдах шинжээр илрэх брай өвчнийг олно уу.

- A. Махны брай
- B. Уушгины брай
- C. Зүрхний брай
- D. Судасны брай
- E. Дотор брай

/86./ Уушгины цайвар хавангийн онцлог шинжийг тогтооно уу

- A. Олон ханиана хөөстэй цустай цэр гарна
- B. Дотор хөөж уруул цайна
- C. Бие загатнаж нууцаар хавагнана
- D. Нүд бие ,шээс шарлана
- E. Хаван амрхан ихсэж багасна

/87./ Элэгний ам цалгивал аль аль эрхтэнд нөлөөлхийг тогтооно уу

- A. Цөс
- B. Уушиг
- C. Гэдэс
- D. Дэлүү
- E. Зүрх

/88./ “Анагаах ухааны 4 үндэс” зохиолын “Язгуурын үндэс”-т “...өөрийн бие, хэл, сэтгэл гурвын гэмгүй, шударгатгаж (бие, хэл, сэтгэлийнхээ гэмийг арилгаад шулуун шударга оршигч гэсний утга юм) бусдын гэмийн тэгш бусыг тэгшитгэн үйлдэх” гэсэн нь алинд хамааралтай болохыг тогтооно уу

- A. эмчийн тангараг
- B. үзүүлэгчийн зарлиг
- C. аршийн ёс
- D. энэрэхүйн сэтгэл
- E. цаглашгүй дөрөв

/89./ Уушгинд халуун дэлгэрвэл ямар шинж илрэхийг сонгоно уу

- A. Санаа алдах
- B. Цэр ногоон шар өнгөтэй гарах
- C. Өрцөөр хатгаж өвдөх
- D. Хэл нь голоороо хагарах
- E. Идээнд дургүй болох

/90./ Хий өвчний шээсний өнгөний онцлог шинжийг тогтооно уу

- A. Шар
- B. Цөөрмийн ус шиг хөхөвтөр
- C. Цагаан
- D. Улаан
- E. Энгэсгийн зайлдас шиг

/91./ Эмэгтэйчүүдийн өвчний үед хар өнгөтэй зүйл доошоо гарах ууц нуруугаар тасралтгүй өвдөх, шээс чавдагших, доод бие хүндрэх шинжээр илэрдэг ямар өвчин байдгийг тогтооно уу

- A. Савны усан бэтэг
- B. Цусан бэтэг
- C. Махан бэтэг
- D. Булчирхайн бэтэг
- E. Судсан бэтэг

/92./ Цагаан хэрх өвчний үед илрэх шинж тэмдгийг олно уу.

- A. Үений өвдөлт хүчтэй
- B. Үе улайж хавдах
- C. Судас дорой чичрэх
- D. Өндөр халуурах
- E. Шээс уур үнэр их

- /93./ Цусны өвчнийг орноор нь юу гэж ангилдгийг тодорхойлно уу
- A. Арьсанд тархах маханд дэлгэрэх
 - B. Ясанд шунах, цулд буух
 - C. Цээжинд дэлгэрэх, завсарт орших, бөгсөнд унах
 - D. Саванд унах
 - E. Үесэнд сарних
- /94./ Бөөр доргиод дээд биед сарних нь ямар махбодын бэлгэ чанартай холбоотой болохыг тогтооно уу
- A. Хийн хөлбөрөнгүй
 - B. Шарын хөнгөн
 - C. Бадганы хүнд
 - D. Хийн нарийн
 - E. Шарын хурц
- /95./ Элгэнд оршсон борыг эмчлэхдээ ямар махбодыг гол болгож баримтлахыг тодорхойлно уу
- A. Бадгана
 - B. Шар
 - C. Хий
 - D. Цус
 - E. Шар ус
- /96./ Бөөрний нуугдсан халууны шинжийг тогтооно уу?
- A. Шүдний өнгө буурах
 - B. Хамраас цус гоожих
 - C. Шээсний уур арилах нь удаан, язмаг нь хэсэглэж бөөгнөх
 - D. Шээс чавдагшрах
 - E. Шээсний өнгө улаан тунгалаг болох
- /97./ Бам өвчний хэлэнд гарах өөрчлөлтийг сонгоно уу
- A. Улаан хуурай ширүүн
 - B. Шар өнгөртэй
 - C. Зузаан цайвар өнгөртэй
 - D. Эрээн хар алаг, өнгөртэй болох
 - E. Шүдний ором гарах
- /98./ Хаврын улирлын эхний 72 хоногт үйл ажиллагаа нь идэвхжсэн эрхтэний судас хэрхэн лугшихийг тогтооно уу
- A. Хитрүүний дуу мэт охор зөөлөн
 - B. Хөхөөний дуу мэт бүдүүн уртлаг
 - C. Чүүчлын дуу мэт зөөлөн алгуур
 - D. Богширгын дуу мэт нарийн эрчимтэй
 - E. Бүдэнгийн дуу мэт огцом ширүүн
- /99./ “Анагаах ухааны 4 үндэс” зохиолын “Номлохуйн үндэс”-т заасанчлан бадган өвчний үе дэх эм уух ёсыг сонгоно уу?.
- A. Идээний өмнө
 - B. Идээ эс идсэн цагт
 - C. Идээний дунд
 - D. Идээний эцэст
 - E. Идээний завсарт
- /100./ Шар өвчний шээсний хөөсний онцлог шинжийг тогтооно уу
- A. Хөх өнгөтэй, хөөс нь том хэмжээтэй дуугарч хагарна
 - B. Шар өнгөтэй жижиг хөөстэй, түргэн арилна
 - C. Шүлс шиг хөөстэй, наалдамхай
 - D. Улаан хөөстэй түргэн арилна
 - E. Хөөс нь солонгорно
- /101./ Даль - 7 –г нь дэлүүний ямар өвчнийг анагаах жор болохыг сонгоно уу.
- A. Дэлүүний хүйтэн
 - B. Дэлүүний халуун
 - C. Дэлүүний суулгах

- D. Цусаар хөөх
 - E. Дэлүүний хий
- /102./ Бэтгийг эвдэхэд ямар бүлэг эмийг сонговол үр дүнтэй болохыг тодорхойлно уу
- A. Агар, жац
 - B. Түлсэн давс, шингүн
 - C. Мана, сороол, готалва
 - D. Жонш, жилж
 - E. Тунсаа, жонш
- /103./ Шингэлт муудах, хэхрэх, ходоод хөших, шим үл авах нь ямар бадганы хямралын үед илэрч болохыг тогтооно уу
- A. Ялзлагч бадган
 - B. Амсуулагч бадган
 - C. Барилдуулагч бадган
 - D. Хангагч бадган
 - E. Шүтүүлэгч бадган
- /104./ Эм судасны лугшилтийн онцлогийг тогтооно уу
- A. Нарийн эрчимтэй
 - B. Нарийн түргэн
 - C. Нарийн дэлгэрэнгүй
 - D. Нарийн чанга
 - E. Нарийн дорой
- /105./ Шижинтэх өвчний шалтгааныг тогтооно уу
- A. Хий, шар
 - B. Хий, бадгана
 - C. Бадгана, хий
 - D. Цус, шар, бадгана, хий
 - E. Хий
- /106./ Хавагнах шинж дагалддаг дэлүүний ямар өвчин байдгийг сонгоно уу
- A. Дэлүүний бадган
 - B. Дэлүүний хий
 - C. Дэлүүний суулгах
 - D. Дэлүүний халуун
 - E. Дэлүү цусаар хөөх
- /107./ Цус, шарын хувь дийлэнхи эс боловсорсон халуунд ямар тан өгөхийг сонгоно уу
- A. Мана 4
 - B. Дева 5
 - C. Лидэр 3 дээр 3 үрийн тан нэмж өгөх
 - D. Буцалгаж хөргөсөн ус
 - E. Сармисагны үнс 7
- /108./ Цус хямарсан дан халуун өвчин аль нь болохыг тогтооно уу
- A. Зөөлөн хямрах
 - B. Хямран дэлгэрэх
 - C. Халуун хижиг
 - D. Хор харших
 - E. Хурмал хижиг
- /109./ Бор нуугдвал ямар шинж илрэхийг тогтооно уу
- A. Хатгуулж өвдөх
 - B. Шээс улайх
 - C. Судас нарийн түргэн
 - D. Судас живэнгүй, шээс ногоовтор, бие хүндрэх
 - E. Хавагнах, зүрх дэлсэх
- /110./ Огшрон хэхрэх, баас хатах, дотор халах, халуун усаар гулгих, өрцөөр өвдөх, сүүлдээ мугво өвчин болж хүндэрдэг нь ямар эс шингэсэн өвчин болохыг тогтооно уу.
- A. Эс шингэснээр хэхрэх
 - B. Эс шингэснээр хөших
 - C. Эс шингэсэн бадгана салс

- D. Эс шингэсэн хор мэт
E. Тунгалаг эс шингэсэн
- /111./ Халуун чанартай усан хаван үүсэх өвчин зүйн хувиралтыг тогтооно уу?
A. Гэдэснээс нэвчирч үүсэх хаван
B. Шээс цугларч үүсэх хаван
C. Тунгалгийн ус сарниж үүсэх
D. Цус сарниж үүсэх
E. Ходоодноос нэвчирч үүсэх
- /112./ Ямар амт чадалтай идээг хэтрүүлэн хэрэглэвэл хий өвчин үүсч болохыг тогтооно уу
A. Гашуун, хөнгөн, ширүүн
B. Халуун, исгэлэн, давслаг
C. Гашуун, амтлаг, хүнд, сэрүүн, тослог
D. Халуун эхүүн тослог
E. Исгэлэн, амтлаг, хүнд, сэрүүн
- /113./ Судас барихад цон, ган, чаг дээр ямар хэмжээтэй дархыг сурвалжид хэрхэн заасныг тогтооно уу
A. Маханд тултал дарна
B. Хурууны дороос судасны лугшилт илэртэл сайн дарах
C. Өвчтөний биеийн байдалд тохируулан дарна
D. 3, 6, 9 -н арвайн хэмжээгээр дарах
E. Ясанд тултал дарна
- /114./ Брай өвчин үсэрхийлэхээс сэргийлж аль найрлагыг сонгохыг тогтооно уу
A. Гүргэм, баавгайн цөс, жонш өгөх
B. Баавгайн цөс, 2 төрлийн үнс, балчирганы өтийг бурамтай үрэлдэж өгөх
C. Гиван, домьти, өвсөн гүргэмийг тарагтай үрэлдэж өгөх
D. Жуган, гүргэм, домьти, тунсааг чихэртэй үрэлдэж өгөх
E. Гурван үр өгөх
- /115./ Дэлүүний цайвар хавангийн онцлог шинжийг тогтооно уу
A. Олон ханиана хөөстэй цустай цэр гарна
B. Дотор хөөж уруул цайна
C. Бие загатнаж нууцаар хавагнана
D. Нүд бие, шээс шарлана
E. Хаван амархан ихсэж багасна
- /116./ Ходоод элэг хавсарч өвдөх ба эхлээд ходоод элэг өвдөж дараа нь өөр газарт өвдөөд анхны газартаа өвдөхгүй бол ямар хэлбэрийн бор өвчин вэ?
A. Дэлгэрэх хэлбэрийн бор өвчин
B. Тогтох хэлбэрийн бор өвчин
C. Хуйлрах хэлбэрийн бор өвчин
D. Нэвчих хэлбэрийн бор өвчин
E. Сарних хэлбэрийн бор өвчин
- /117./ Эс боловсорсон халууны эмчлэх зарчмыг тогтооно уу
A. Бадарсан халууны омгийг дарах
B. Шимтээр анагаах
C. Толгойн бүрхүүлийг хуулах
D. Шар усыг өөрийн оронд нь хатаах
E. Замд нь оруулж засах
- /118./ Ясанд шунасан халуунд ямар эмчилгээ хийхийг сонгоно уу
A. Халуун гурил болон гүнжидийн шаараар жинтавих
B. Идээлбэл шарх анагаах ёсоор эмчлэх
C. Жиршүн 6 өгөх
D. Мод 8 танг чихэртэй усаар даруулан өгөх
E. Хавдсан хэсгийг ус давстай цайгаар шавших
- /119./ Жүрүрийн тан өгч жорган судсыг ханах нь дуу хаагдах өвчний ямар хэлбэрт илүү тохирхыг тогтооно уу
A. Цусаар дуу хаагдах
B. Шараар дуу хаагдах

- С. Бадганаар дуу хаагдах
D. Хийгээр дуу хаагдах
E. Өөхнөөс дуу хаагдах
- /120./ Брай өвчний судас яаж лугшихийг тогтооно уу
A. Нарийн чичэрч лугших
B. Хөндий хоосон лугших
C. Чанга лугших
D. Бүдүүн дүүрэн лугших
E. Живэнгэ дорой лугших
- /121./ Аюулхайн хэсэгт хөөж үе үе суулгах, нүүр цоохор болох нь ямар эрхтэний эмгэг болхыг тогтооно уу
A. Цөс
B. Давсаг
C. Дэлүү
D. Ходоод
E. Самс
- /122./ Махны хэрх өвчний үед илрэх шинжийг олно уу?
A. Өвдөлт маш их, хөдөлж чадахгүй
B. Хөшиж өвдөх, хөдөлгөөн хязгаарлах
C. Мах, яс салах мэт өвдөх
D. Мах тасрах мэт
E. Том үе өвдөх
- /123./ “Анагаах ухааны 4 үндэс” зохиолын “Язгуурын үндэс”-т “Тэр үглэшгүй орд харшийн дунд Биндэрьяа эрдэнийн дэвсгэр дээр үзүүлэгч, ялж төгс нөгчсөн амьдруулан зохиогч, эмийн багш, Биндэрьяан гэрэлт хаан хэмээх суусан болой. Үзүүлэгч нь тэнгэр, арш, гадаад, дотоодын 4 зүйлийн нөхдөөр огоот хүрээлэгдсэн” гэсэн байдаг ба аршийн нөхдийг нь тодорхойлно уу.
A. Үргэлж мэдэгчийн хөвгүүн (Жүншэй жи вү)
B. Тэрсүүдийн өвөг Эсэр (Мүдэг жи мэйбо Цанба)
C. Түгмэл орогч (Чавжүг)
D. Жэгү дагво нүрва (төрөлхтөний эзэн түргэн)
E. Ананда (Гүнгаво)
- /124./ Эрүүл шээсний уурын замхралтын онцлогийг тогтооно уу
A. Удаан арилдаг
B. Түргэн арилдаг
C. Удаан түргэн тэнцүүхэн
D. Уур ихтэй байдаг
E. Уур багатай байдаг
- /125./ Бадган дийлэнх гэдэсний ямар өвчин байдгийг тогтооно уу
A. Гэдэс хатгах
B. Гэдэс мушгирах
C. Гэдэсний архаг
D. Гэдэс дүүрэх
E. Гэдэсний халуун
- /126./ Нүд харлах, амнаас унжралдсан салслаг шүлс гоожих, дотор харанхуйлах, зүрх чичирч хүчтэй хатгаж өвдөх нь зүрхний ямар өвчний шинж болохыг тодорхойлно уу
A. Зүрх долгиох
B. Зүрхний шар ус
C. Зүрхний хорхой
D. Зүрхний хатгалга
E. Зүрх будангуйрах
- /127./ Уушги дэлгэрэх өвчний цэрний өнгөний онцлогийг тогтооно уу
A. Цайвар хөх
B. Улаан өнгөтэй
C. Давслаг шар
D. Сэвсгэр хөөстэй

Е. Хөхөлбөр

/128./ Элэгний үхэр бөгтөр өвчний үед гарах шинж аль болохыг тодорхойлно уу

- А. Цээж дүүрч хуурай ханиах
- В. Халуун исгэлэн усаар бөөлжих
- С. Даарсан үед зогисох
- Д. Бие хавагнах
- Е. Цусаар бөөлжих

/129./ Өвчний халуун хүйтний мөн чанарыг ялган оношлоход шээсний шинжилгээнд юуг голлон анхаарах ёстойг олно уу

- А. Үнэр
- В. Уур
- С. Өнгө
- Д. Язмаг
- Е. Хөөс

/130./ Эмэгтэйчүүдийн хий бүрэлдсэн өвчний эмчилгээний зарчмыг сонгоно уу

- А. Шимжүүлэх засал
- В. Төөнүүр
- С. Туулга засал
- Д. Жин засал
- Е. Дэвтээлэг засал

/131./ Гэдэс хоржигнох, гэдэс мушгирах өвчний шалтгаан нэг байж болохыг тогтооно уу

- А. Хий
- В. Бадган
- С. Шар
- Д. Нян
- Е. Хорхой

/132./ Хоёр жилийн өмнө эмэгтэйчүүдийн цус бүрэлдсэн өвчин гэж оношлогдсон. Сүүлийн үед олон удаа ханиалгах, цээжээр хатгуулах, гүрээ хөших, нүүр сэлхрэх, үе мөчөөр хөшиж хавдах зэрэг шинж илэрсэн. Цус бүрэлдсэн өвчин ямар эрхтэнд сарнисан болохыг тогтооно уу

- А. Элгэнд
- В. Уушгинд
- С. Цөсөнд
- Д. Бөөрөнд
- Е. Гэдсэнд

/133./ Бадган өвчний шээсний хувирах ёсыг тогтооно уу?

- А. Ёроолоосоо хувирна
- В. Дундаасаа хувирна
- С. Хувирахгүй
- Д. Дээд гүехэн талаасаа хувирна
- Е. Голоосоо хувирна

/134./ Хэсэг газарт хүйт оргих цайх мэдээгүй мэт санагдах, судасны лугшилт нь хүчгүй гүйхэд бэрхтэй байвал ямар өвчний шинж болохыг тодорхойлно уу?

- А. Цус барагдах
- В. Цус хөөрөх
- С. Цус алдах
- Д. Цус царцах
- Е. Муу цусны өвчин

/135./ Ходоод цанхайх, хэхрэх, идсэн даруйд цанх мэт өвдөх юу эс шингэсэн тэр зүйл илүү хорлож нүүр зовхи, өлмий сэлхрэх нь ямар өвчний болохыг тогтооно уу

- А. Аюулхайн бэтэг
- В. Чулуун бэтэг
- С. Хорхойн бэтэг
- Д. Цөв эс шингэсэн идээний бэтэг
- Е. Борын цусан бэтэг

/136./ Эс шингэсэн өвчинд шар хавсарвал илрэх шинж тэмдгийг олно уу?

- A. Шүлс наалдамхай болох
- B. Их ундаасах, хэхрэх
- C. Бие чичрэх
- D. Идээ ундааны амтыг үл мэдэх
- E. Бөөлжих

/137./ Эмийг халууны хүчинд нь хэрхэн уялдуулж өгөхийг сонгоно уу

- A. Халууны хүч дунд бол гүргэм 8
- B. Халууны хүч их бол гавар 9
- C. Халууны хүч бага бол гиван 8
- D. Ямар ч үед зандан 8
- E. Ямар ч үед банздоо 12

/138./ Шанбарам өвчний үед ямар хий хямрахыг тогтооно уу

- A. Дээш гүйгч хий
- B. Гал сацуу хий
- C. Уруу арилгагч хий
- D. Амь баригч хий
- E. Түгмэл гүйгч хий

/139./ Цайвар хаван өвчин үүсэх ёсыг тогтооно уу

- A. Муу цус биед хийгээр тархаах
- B. Шар усыг биед хийгээр тархаах
- C. Эс шингэсэн тунгалаг муу цус, шар ус биед тархах
- D. Биед бадган салс хуримтлагдснаас
- E. Цөс биед тархах

/140./ Цус зогсоох үйлдэлтэй гол найрлагыг сонгоно уу

- A. Гиван 13
- B. Зандан 9
- C. Марво 3
- D. Жуган 8
- E. Хонилон

/141./ Бүрхүүл хуулагдсаны дараа ямар эм өгхийг тогтооно уу

- A. Агар 15
- B. Жуган 25
- C. Манагсэлжор
- D. Зову 8
- E. Зову 25

/142./ Зүрхний гэмээр хоолонд дургүй болох үед сэтгэл санаа тогтворгүй болох зүрх орчмоор хатгуулах амьсгал давхцах зэрэг шинж илэрдэг. Энэ шинж нь ямар махбодийн хямрал болохыг сонгоно уу

- A. Шар
- B. Бадгана
- C. Хий
- D. Цус
- E. Хий, шар

/143./ Халууны хүч туйлын их үед өгөх тан эмийг сонгоно уу?

- A. Хүч ихтэй бол дэгд нэмж өгөх
- B. Хүч багатай бол хонилон нэмж өгөх
- C. Хүч ихтэйд гавар -3 өгөх
- D. Хүч дунд бол гиван 8
- E. Хүч бага бол гавар нэмж өгөх

/144./ Төмөр хагт бадган өвчний шинжийг тогтооно уу

- A. Хар шүлс асгарах
- B. Дусал цувирах
- C. Турж эцэх
- D. Шим үл авах
- E. Суваг хаван болох

/145./ Гэмийн, орны үүднээс ангилсан ангилалд багтах өвчнийг сонгоно уу?.

- A. сэтгэлд орших өвчин
- B. дунд биед орших өвчин
- C. дээд биед орших өвчин
- D. хоолойд орших өвчин
- E. таван эрхтэнд орших

/146./ Ходоодны бадган өвчин архагшиж тогтсоноос ходоод, өвчүү, уушгинд бадган дэлгэрч бадганы уур мөгөөрсөн хоолой залгиурт тогтвол ямар өвчин болж хүндрэхийг тогтооно уу

- A. Аюулхайн бадган
- B. Галын илч буурсан бадган
- C. Цагаан хэрх бадган
- D. Хоолой хаагдах бадган
- E. Шингэн хатаагч бадган

/147./ Зогсох өвчний өвчин зүйн хувиралтыг тогтооно уу?

- A. Дээш гүйгч хийн сүв хаагдах
- B. Гал сацуу хийн гүйх сүв хаагдах
- C. Мэдрэхүйн сүв хаагдах
- D. Бадгана салс арвидаж, уруу арилгагч хийн гүйдэл хаагдах
- E. Амь баригч хийн гүйдэл хаагдах

/148./ Уушгины архаг өвчнөөр өвчилж байсан. Одоо нэлээд удаан хугацаагаар цустай цэр гарч өглөөгүүр хий ханиалгах шинж илрэх боллоо. Та уушгины ямар өвчин болохыг тогтооно уу?

- A. Уушигны архаг
- B. Уушигны брай
- C. Уушигны сурьяа
- D. Уушигны өгөр
- E. Уушигны ус алдах

/149./ Эрүү түүш сулрах язгуурын хий өвчний үед гарах шинжийг олно уу?

- A. Шүд зуурах, эрүү унжих
- B. Хуйхны өнгө харлах
- C. Шилбэ хөших
- D. Хавирга сүврэгээр хатгах
- E. Хэсч хатгах

/150./ Шинэхэн үе шатанд байгаа эс шингэсэн өвчний судасны лугшилт аль болхыг тогтооно уу

- A. Бүдүүн чанга лугших
- B. Хүч бага хөвч нарийн байх
- C. Нарийн живэнги доороо чанга лугших
- D. Цон дээр сулхан лугших
- E. Доороо сул лугших

/151./ Судас нь эрчимтэй, ороолдон өчүүхэн чичэрч лугшина. Энэ нь ямар сааны үед илрэхийг тогтооно уу

- A. Гал саа
- B. Усан саа
- C. Цагаан судасны өвчин
- D. Хийн саа
- E. Шороон саа

/152./ Цус дийлэнх шээс хаагдах өвчний үед судсанд гарах шинжийг олно уу?

- A. Судас алгуур дорой
- B. Хатуу
- C. Нарийн түргэн
- D. Дэлгэрэнгүй
- E. Хуйларсан

/153./ Элэгний хар хэрх өвчний үед илрэх шинж тэмдгийг олно уу?

- A. Ууц нуруугаар хүчтэй өвдөх
- B. Аюулхайн баруун хэсэгт өвдөх
- C. Аюулхайн үзүүрт өвдөх

- D. Цээжээр хатгуулах
E. Ходоод цанхайх
- /154./ Төв судасны эрхтэнийг оронд нь ургуулах судас хаана байрладгийг тогтооно уу
A. Бэлгэст
B. Зүрхэнд
C. Хүйсэнд
D. Тархинд
E. Үе мөчинд
- /155./ Бадган өвчний үед нүдэнд гарах онцлог шинжийг тогтооно уу?
A. Харц тогтворгүй, уураглаг давхарга хөх өнгөтэй, толбогүй
B. Харц ширүүн, дотор буланд өөхөн унжлагатай, шар өнгөтэй
C. Зовхи сэлхэрсэн, уураглаг бүрхүүл цайвар
D. Хүүхэн харааны дээд хэсэгт судас өргөссөн
E. Хүүхэн харааны доод хэсэгт толбо суусан
- /156./ Хорын өвчний үед маш нууц шинжийг илрүүлэхэд юуг ашиглахыг тогтооно уу
A. Ар үр, бөхөнгийн эвэр, цагаан зандан
B. Үхрийн эвэр, туулайн сахал, ар үр
C. Загас гахайн мах, ар үр
D. Зарааны үс, мөнгө, архи
E. Манчин, загасны мах, архи
- /157./ Эс шингэсэн өвчнийг үүсгэж болох үл зохих идээ нь аль болохыг тодорхойлно уу
A. Мах, цай
B. Айраг, мах
C. Өндөг, загасны мах
D. Боловсроогүй үр жимс, цай
E. Түүхий ногоо, түүхий сүү, загасны мах
- /158./ Дэлүүний өвчний үед ямар махбодыг барьж зас гэж хойд үндэст заасан байдгийг тогтооно уу
A. Хий
B. Шар
C. Бадгана
D. Цус
E. Шар ус
- /159./ Дэлүүнд бор сарнисан үед өгөх найрлагыг сонгоно уу
A. Лиш, алтанцэцгийн үр, задь
B. Гүргэм, жуган, задь
C. Аагар, зандан, нин шош
D. Чихэр өвс, сороол, мана
E. Даль, хонилон, дэгд
- /160./ Эс шингэсэнд бадган хавсарвал ямар эмчилгээ сонгохыг тогтооно уу
A. Төөнө
B. Бүлээн жин ба зөөлөн шимт
C. Бөөлжүүлэг
D. Туулга
E. Хануур
- /161./ Хийн гэмээр зүрх хатгуулах өвчний үед илрэх шинж тэмдгийг тодорхойлно уу
A. Хэл хатах
B. Хэл хуурай ширүүн болох, нүдний судас гүрвийх
C. Хараа муудах
D. Нүд бүлтийх
E. Хамар хатах
- /162./ Бадганы хайлж царцах шинжийг тогтооно уу?
A. Бага зэрэг хавагнах
B. Үсний угаар сэнгэнэх
C. Хоолны дуршил сайн байх
D. Судас живэнгэ, дорой, түргэн байх

- Е. Судас нарийн эрчимтэй лугших
- /163./ Хорын өвчний үед үе мөч хөшиж атирах нь ямар эрхтэн системд нөлөөлсөний шинж болохыг сонгоно уу
- А. Зүрх
 - В. Үе гишүүн
 - С. Бүлх
 - Д. Шөрмөс
 - Е. Арьс хөрс
- /164./ Эс шингэсэн өвчний шалтгааныг тодорхойлно уу
- А. Шарын хурц халуу бэлгэ чанар арвидах
 - В. Хийн хөнгөн хөлбөрөнгүй бэлгэ чанар арвидах
 - С. Бадганы хүнд сэрүүн бэлгэ чанар арвидах
 - Д. Ходоодны галын гурван хүч хямралдах
 - Е. Бадганы мохдог, тослог бэлгэ чанар арвидах
- /165./ Хийн өвчний үед судас хөндий хоосон лугших, шээс нь ус шиг, тунгалаг, хөрсний сүүлээр улам шингэрэх шинж гарах нь хий махбодын бэлгэ чанар хэрхэн өөрчлөгдсөн болохыг тодорхойлно уу.
- А. Хий махбод аригдсан
 - В. Хий махбод хямарсан
 - С. Хий махбод хорогдсон
 - Д. Хий махбод бусад тэгш оршсон
 - Е. Хий махбод хурсан
- /166./ Булингартсан халууны эмчилгээний зарчмыг тогтооно уу?
- А. Эхлээд зөрөлдөөнийг эвлүүлэх мэт
 - В. Түргэн ханаж , халууныг уурыг гаргах
 - С. Дунд үед нь ерөндгийн хүчинд тохируулах
 - Д. Шар усыг хатаасны дараа хануур, туулга хэрэглэх
 - Е. Эхлээд хэвлийн туулга хэрэглэх
- /167./ Халууны хоосонд хийх эмчилгээг тогтооно уу
- А. Нян халууны шинж байвал агар 15 өгөх
 - В. Жонлон 5 хүйтнээр үргэлжлүүлж өгөх
 - С. Хөлс гаргасаны дараа агар 10 өгөх
 - Д. Халууны сүүлийг гавар 3 аар гаргах
 - Е. Халууны сүүлийг арилгах эрхэм 25 өгөх
- /168./ Гавар - 25 жорын дээр гурван зүйлийн эвэр нэмсэн найрлага нь уушигны ямар өвчинд сайн үр дүнтэй байдгийг сонгоно уу
- А. өгөрийн эхэн үед
 - В. Уушги дэлгэрэх
 - С. Уушгины архаг
 - Д. Уушгины мэнгэр
 - Е. Уушгины халуун
- /169./ Бадган өвчнийг эмчлэх явдал мөрийн нөхцлийг тодорхойлно уу
- А. Өдөр унтуулах
 - В. Хуучирсан сайн архи бага багаар уулгах
 - С. Хөнгөн ширүүн идээг өгөх
 - Д. Хуурай газар илүүхэн хөдөлгөж хөлөргөх
 - Е. Жамц давстай ус уулгаж бөөлжүүлэх
- /170./ Хийн өвчний үед судас нь хөндий хоосон, шээс нь ус шиг тунгалаг хөрсний сүүлээр улам шингэрнэ.Хий махбодын бэлгэ чанарын хувирлыг тодорхойлно уу.
- А. Хий махбод аригдсан
 - В. Хий махбод хямарсан
 - С. Хий махбод хорогдсон
 - Д. Хий махбод бусад махбодтой хавсарсан
 - Е. Хий махбод хурсан
- /171./ Гурван гэмийн язгуурын ангилалд багтах өвчнийг тодорхойлно уу.
- А. гэдийх дарган

- В. бүтээгч шарын өвчин
- С. ялзлагч бадганы өвчин
- Д. амь баригч хийн өвчин
- Е. 3 гэм арьсанд тархах

/172./ Өвчтөн хүнд юм өргөснөөс болж сүүж гуяны дотор талын булчин мах руу дамжиж бадайрч өвдөх боллоо гэсэн зовиур хэлнэ. Та гадар цагаан судлын ямар салаа гэмтсэн болохыг тогтооно уу

- А. Раднаа судлын салаа
- В. Зажид судлын салаа
- С. Гуурст судлын салаа
- Д. Хурмалын салаа
- Е. Эрдэнэ судлын салаа

/173./ Шамбарам өвчний үед өтгөн хатах, цайвар салстай эсвэл цусаар суулгах, гүвдрүү нь харлах, ундаасах, бие хөлрөх зэрэг шинж тэмдэг илэрч байгаа үед хямарсан махбодыг тодорхойлно уу?

- А. Хий, цус, шар ус
- В. Шар, нян
- С. Цус, бадгана
- Д. Шар ус, хий
- Е. Хорхой, нян

/174./ Уушгины цайвар хаван өвчний үед ямар махбод илүү хямралдахыг тогтооно уу

- А. Цус
- В. Бадган
- С. Шар
- Д. Шар ус
- Е. Нян хорхой

/175./ Махны хорын өвчний судасны лугшилтын онцлог ямар болхыг тогтооно уу

- А. Нарийн түргэн балархай живэнги
- В. Ширүүн долгисож солилцон лугшина
- С. Нарийн түргэн хөлбөрөнгүй
- Д. Хатуу эрчимтэй
- Е. Хоосон түргэн

/176./ “Анагаах ухааны 4 үндэс” зохиолын “Язгуурын үндэс” дэх зөвхөн “үнэхээр туулсан” гэсэн үгийн утгыг хэрхэн тайлбарладаг вэ?. Хариуг сонгоно уу?.

А. амьтан бүгдийн бие, хэл, сэтгэл гурвын эмч бөгөөд сэтгэлийн амгаланг өгөгч гэсэн утгатай юм

В. сэрэн дэлгэрэх буюу мунхгийн нойрноос сэрсэн, мэдэгдэхүүн бүхэнд оюун дэлгэрч тэвчил онолын эцэст хүрсэн гэсэн утгатай юм

С. тэвчигдэхүүнээс салсан бодийн номыг дотроо багтаасан гэсэн утгатай юм

Д. түүний дүрст биеийн онцлогоор сэтгэлчлэнгийн зэндмэнэ эрдэнэ буюу тунгалаг тодорхой болно. хөх, цагаан, шар 3 зүйл байдаг гэсэн утгатай юм.

Е. энэ номыг номлосон орон хот

/177./ Боловсроход бэрхтэй халууны эмчилгээг сонгоно уу

- А. Зөөлөн туулга
- В. Хий дийлэнх бол гурван шимт ясны тан өгөх
- С. Бадган дийлэнх бол дэгдийн ширгээсэн тан өгөх
- Д. Гавар 25- ыг архиар даруулж өгөх
- Е. Бадгана дийлэнхи бол лидэрийн тан өгөх

/178./ Хүйтнээр суулгах өвчний судас яаж лугшихыг тогтооно уу

- А. Бүдүүн чанга лугших
- В. Хүч бага хөвч нарийн лугших
- С. Нарийн живэнгүй ёроолдоо чанга лугших
- Д. Цон дээр сулхан лугших
- Е. Доороо сул лугших

/179./ Загатнах доод бие хүйт оргиж, ууц нуруугаар чилж өвдөх, доошоо цагаан юм гарах нь умайн өвчин ямар махбодын хямралаас болж үүссэн болохыг тогтооно уу

- A. Хийнээс
- B. Цуснаас
- C. Шараас
- D. Бадганаас
- E. Хурмалаас

/180./ Амь баригч хий хямархад ямар шинж илрэхийг тодорхойлно уу

- A. Ам муруйж эрхтэний мэдэрхүй буурах, хэлгийрэх, чулчрах, тамир багасах
- B. Амьсгаа авахад хүчлэх, залгиж чадахгүй, зүрх түгших, толгой эргэх
- C. Зүрх мушиграх мэт санагдах, айх, үг олшрох, манарах
- D. Баас, шээс хоригдох, үес өвдөх, доголох
- E. Шингэхэд бэрх, идээнд үл дурлах, бөөлжих, ходоод хүйт оргих

/181./ Бэтгийн судасны лугшилтын онцлогийг тодорхойлно уу

- A. Сул балархай
- B. Бүдүүн ган нь балархай
- C. Живэнгэ алгуур дорой
- D. Хөндий хоосон
- E. Нарийн

/182./ Саармаг судасны лугшилтийн онцлогийг тогтооно уу

- A. Уртлаг зөөлөн эелдэг
- B. Уртлаг зөөлөн алгуур
- C. Уртлаг зөөлөн дорой
- D. Уртлаг зөөлөн живэнгүй
- E. Уртлаг эелдэг зөөлөн сулхан

/183./ Олгойн хүйтнээр хөөх өвчний үед илрэх шинж тэмдгийг тогтооно уу?

- A. Хөөстэй цайвар зүйлээр суулгах
- B. Идээний хольцтой зүйлээр суулгах
- C. Нүүр царай борлох
- D. Халуурах
- E. Нурууны голоор хөшиж өвдөх

/184./ Хуучирсан халуун өвчин үүсэх ёсыг тогтооно уу

- A. Шарын халуун тамирт шунаснаас үүсэх өвчин
- B. Тамир бүхэнд халуун сарнисан өвчин
- C. Идээ явдлын буруудлаар цус, шар хямаар өвчин
- D. Хий, цус хямарсан өвчин
- E. Цус, шар хямарсан өвчин

/185./ Бөөрний ус алдах өвчний үед жүр үрийг ямар зарчим дээр үндэслэн өгөхийг тогтооно уу

- A. Усны амыг боох
- B. Шар усыг хатаах
- C. Цус ялгах
- D. Цусны халууныг арилгах
- E. Усыг ялгах

/186./ Хоолонд дургүй болох өвчний үед эхүүн амттай эмт усыг хэрэглэх тухай заасан байдаг. Үүнийг дотрын өвчний тайлбар зохиолд юу гэж дэлгэрүүлсэн болохыг сонгоно уу

- A. Ар үрийн шүүс
- B. Ар үр, бар үрийн шүүс
- C. Жүр үрийн шүүс
- D. Өмхий давсны шүүс
- E. Анарын шүүс

/187./ Дээш нэвчсэн борд үр дүнтэй эмчилгээг сонгоно уу

- A. Хүчтэй туулга
- B. Цус нэвчрэхийг зогсоож илч сэлбэх
- C. Цус шарны халууныг арилгах найралт өгөх
- D. Мүгвог хурааж ханах
- E. Биеийн таимрыг хамгаалж байгаад өвчний цусыг бөөлжүүлэх ба цусны мөр эс тасарч

тамир муудвал бөөлжүүлгийг зогсоох

/188./ Дагшуур хүрснээс олон ханиалгадаг байсан. Сүүлийн үед ам заваарах, биеийн тамир суларч, турж эцэх, зүрх дэлсэх, амьсгаа давчдах, хавагнах, дотор муухайрч бөөлжис цутгах шинж илрэх болсон. Ямар өвчин болохыг тогтооно уу

- A. Уушгины архаг
- B. Уушгины хаван
- C. Барагдуулагч их архаг
- D. Суръяа
- E. Уушгины брай

/189./ Царай борлож хамраас цус гоожих, юу ч идсэн хорлодог элэгний өвчнийг тодорхойлно уу?

- A. Элэг хатуурах
- B. Элэг томрох
- C. Элэгний оньс гэмтэх
- D. Элэгний хаван
- E. Элэгний цусны буруудал

/190./ Хорын өвчний маш хүндэрсэн шинжийг тогтооно уу?

- A. Биеэр хар гүвдрүү гарах
- B. Шээс хаагдах
- C. Амьсгал цухалдах
- D. Зүрхний цохилт удаашрах
- E. Бүх бие хавагнах

/191./ Уруул өнгөө алдаж цайх нь ямар өвчний шинж болхыг тогтооно уу

- A. Хий өвчин
- B. Цайвар хаван
- C. Дэлүү цусаар хөөх
- D. Дэлүүний суулгах
- E. Дэлүүний халуун

/192./ Дэлүүний суулгах өвчний шинжийг олно уу?

- A. Шар өнгөтэй зүйлээр суулгана
- B. Хөөсөөр суулгана
- C. Эс шингэснээр суулгана
- D. Өөх тосоор суулгана
- E. Эс шингээгүй зүйлээр суулгана

/193./ Хорын өвчний судас нь ямар өвчний судастай адил лугшихыг тогтооно уу

- A. Цусны өвчин
- B. Нян өвчин
- C. Шар усны өвчин
- D. Мэдрлийн өвчин
- E. Уяман өвчин

/194./ Шар усны өвчний үед ямар онцлог шинж илэрдгийг тогтооно уу

- A. Загатнаж гүвдрүү гарах
- B. Гар хөл хүйт оргих
- C. Дээш хөөрөх
- D. Хамраас цус гоожих
- E. Зүрхээр өвдөх

/195./ Хижгийн халууны судасны лугшилтын онцлог ямар болхыг тогтооно уу

- A. Балархай бөгөөд чичирч таталдана
- B. Бүдүүн дэлгэрэнгүй товойж хуйлрана
- C. Нарийн чанга эрчимтэй
- D. Нарийн түргэн
- E. Огцом лугших

/196./ "Анагаах ухааны 4 үндэс" зохиолд заасанчлан "Уур, мунхаг, тачаангуй зэрэг сэтгэлийн гурван хорын шалтгаан-муу сэтгэл болон түүнээс болсон өвчин бүхнийг уг, үндэснээс нь арилгах чадвартай эмч" гэсэн тодорхойлолт эмчийн ямар бүлэгт хамааралтай вэ?.

- A. дээд эмч
- B. эгэл жирийн эмч

- С. тэнцэшгүй эмч
- D. ялгавартай эмч
- Е. адгийн эмч

/197./ Боловсрох чөлөөгүй халууны эмчилгээг сонгоно уу

- A. Эрдэнэ 7 өгөх
- B. Шарын цагт нь гавар 3 өгөх
- C. Гурван шимт ясны тан өгөх
- D. Бадгана хийн цагт нь анар 4 өгөх
- E. 4 гаргалт өгөх

/198./ Хүйтнээр бөөлжих өвчний судас хэрхэн яаж лугшихыг тогтооно уу

- A. Бүдүүн чанга лугших
- B. Хүч бага хөвч нарийн лугших
- C. Нарийн живэнги ёроолдоо чанга лугших
- D. Цон дээр сулхан лугших
- E. Доороо сул лугших

/199./ Сарын хир үргэлжлэн цувирч их хэмжээтэй гарах нь ямар махбодоос шалтгаалсан болохыг тогтооно уу

- A. Хийнээс
- B. Цуснаас
- C. Шараас
- D. Бадганаас
- E. Хурмалаас

/200./ Эмэгтэйчүүдийн цус бүрэлдсэн өвчний шинжийг олно уу?

- A. Сэлхэрч хөөх
- B. Суулгах
- C. Нүд бүрэлзэх, сэтгэл хямрах
- D. Гэдэсний доод хэсгээр халуун оргиж өрцөөр хатгуулах, бэлхүүс давсагнаас доогуур шархирч өвдөх
- E. Яс шархирч, зулай руу хүйт оргих

/201./ Цул савын ёроолд үүсэх бэтгийг ямар бэтэг гэж үздгийг тогтооно уу

- A. Хорхойн
- B. Дотор
- C. Гадар
- D. Судлын
- E. Завсрын

/202./ Эмчийн баруун гарын ядам хуруунд өвчтөний ямар цул сав эрхтэний судасны лугшилт мэдрэгдхийг тодохойлно уу

- A. Элэг, цөс
- B. Бөөр, самс
- C. Зүрх, гэдэс
- D. Уушги, олгой
- E. Бөөр, давсаг

/203./ Ходоод доройтсон өвчний үед илрэх шинж тэмдгийг тогтооно уу?

- A. Тасралтгүй өвдөнө
- B. Хоолны дур хаагдана
- C. Шимтэй идээ шингэхгүй
- D. Залгиур өвдөнө
- E. Шар ногоон зүйлээр бөөлжинө

/204./ Бүрхүүл хуулагдсаны шинжийг тогтооно уу?

- A. Арьс хуурайших
- B. Чичрүүдэс хүрэхээ болих
- C. Хэл өнгөртөх
- D. Хөлрөх нь зогсох
- E. Өдөр нойр хүрэх

/205./ Хий шар бадган хямарч биеийн тунгалаг гүйх сүв хаагдаж галын илч буурах эмгэг жамаар үүсдэг уушигны ямар өвчин байдгийг тогтооно уу

- A. Их архаг
- B. Цайвар хаван
- C. Барагдуулагч их архаг
- D. Суръяа
- E. Брай

/206./ Олгойн хийн гэмээр зогисох үед илрэх шинж тэмдгийг тогтооно уу

- A. Шингээлт муудах
- B. Ам заваарах
- C. Ганы судал сул лугших
- D. Хэвлий дүүрч хоржигнох
- E. Ам хатах

/207./ Шимийн найралтыг мугво өвчний ямар хэлбэрт үр дүнтэй болохыг тодорхойлно уу

- A. Дэлгэрч нэвчсэн хэлбэр
- B. Сарних хэлбэрийн мугво
- C. Цус шарын халуун давуу цагт
- D. Хуйлрах хэлбэр
- E. Тогтох хэлбэрийн мугво

/208./ Тасралтгүй ханиалгаснаас нүүр нүд минчийж улайх, амьсгал боогдох, цэр гарвал бага зэрэг тайвшрах шинж гардаг уушигны ямар өвчин байдгийг тогтооно уу.

- A. Уушигны дагшуур
- B. Огшрон ханиах
- C. Уушиг дэлгэрэх
- D. Их архаг
- E. Хаван

/209./ Хар зурхайн онол ёсоор ямар цул сав эрхтэнүүд эх-хүүгийн (эх@хүү) харьцаанд оршдогийг тодорхойлно уу

- A. Зүрх гэдэс @ элэг цэс
- B. Дэлүү ходоод @ уушиг олгой
- C. Бөөр давсаг @ зүрх гэдэс
- D. Уушиг олгой @ элэг цэс
- E. элэг цэс @ бөөр давсаг

/210./ Хүчжүүлэх заслыг хэрэглэхэдхийхэд өмнөх бэлтгэл нь юу болохыг тогтооно уу

- A. Тосон засал угаалга, нируха
- B. Таван рашаанд орох, туулга
- C. Бөөлжүүлэг, зөөлөн шимт
- D. Судсан туулга
- E. Жин төөнүүр, угаалга

/211./ Хэл голоороо хагарсан харласан байвал ямар өвчний шинж болхыг тогтооно уу

- A. Зүрх
- B. Уушиг
- C. Дэлүү
- D. Бөөр
- E. Элэг

/212./ Өтлөгсдийг тэнхрүүлэхэд 5 тунгалгийг хэрэглэх тухай сурвалж зохиолд заасан байдаг.Түүний нэг болсон модны тунгалаг бурам юуны тэжээл болохыг тогтооно уу

- A. Ясны тэжээл
- B. Махны тэжээл
- C. Өнгөний тэжээл
- D. Шимийн тэжээл
- E. Хүчний тэжээл

/213./ Дараах хоруудын аль нь хүйтэн чанартай хорд багтахыг тогтооно уу

- A. Махны хор
- B. Чулууны хор
- C. Өвсөөр найруулсан хор
- D. Шимийн найрлага
- E. Бодитой хор

/214./ Өвчтнийг үзэхэд дуу нь өндөр нам болно. Хоолойд өргөс орсон юм шиг санагдаж байна хэмээн зовиурлана. Үзэхэд халуунтай байсан ямар дуу хаагдах өвчний шинж болохыг тогтооно уу

- A. Шараар дуу хаагдах
- B. Бадганаар дуу хаагдах
- C. Хийгээр дуу хаагдах
- D. Цусаар дуу хаагдах
- E. Барагдуулагчаас болох

/215./ Хямарсан халууны судасны лугшилтын онцлог ямар болхыг тогтооно уу?

- A. Балархай бөгөөд чичирч таталдана
- B. Бүдүүн дэлгэрэнгүй товойж хуйлрана
- C. Нарийн чанга эрчимтэй
- D. Нарийн түргэн
- E. Огцом лугших

/216./ “Анагаах ухааны 4 үндэс” зохиолын “Язгуурын үндэс” дэх “ялж төгс нөхцсөн” гэснээс зөвхөн “ялж” гэсэн үгийн утгыг хэрхэн тайлбарладаг вэ?. Хариуг сонгоно уу?.

A. эрх баялаг, сайхан дүрс, цог төгөлдөр, алдар, билэг (билгүүн), хичээнгүй зэрэг 6 (сайн) хотол чуулган төгссөн гэсэн утгатай юм

B. 4 шулмыг (тэнгэрийн хөвгүүн шулам, нисванисын шулам, үхлийн эзний шулам, цогцын шулам зэрэг дөрөв) эсвэл нисванисын үйл, төрлийн үйл, нисванисын түйтгэр, мэдэгдэхүүний түйтгэр зэрэг дөрвийг буюу үл зохилдох бүгдийг дарсан

C. мэдэгдэхүүнүүдийн мөн чанар, ёсыг ямар мэт болгоон залардаг гэсэн утгатай юм

D. гаслан, зовлонгийн хязгаараас салсан буюу эсвэл 6 сайн нь Асарт (6 зүйл амьтны нэг) байдаг ч бурханд байх нь 6 баримадын эцэст хүрсний тэмдэг мөнөөр ертөнцөөс хэтэрсэн гэсэн утгатай

E. танин барилтаар хурсан түйтгэр, муу авьяас сэлтийн дайсныг дарсан гэсэн утгатай юм

/217./ Эс боловсорсон халууныг засах ерөнхий зарчмыг тогтооно уу

- A. Шууд нядлах
- B. Туулгах
- C. Боловсруулах
- D. Эхлээд лидэр,гандигарын тан өгөх
- E. Дунд үед нь халуун нурам руу ус цацах мэт засах

/218./ Хуучирсан үе шатанд байгаа эс шингэсэн өвчний судас хэрхэн яаж лугшихыг тогтооно уу?

- A. Бүдүүн чанга лугших
- B. Хүч бага хөвч нарийн байх
- C. Нарийн живэнгүй ёроолдоо чанга лугших
- D. Цон дээр сулхан лугших
- E. Доороо сул лугших

/219./ Сарын хирийн мөчлөг алдагдаж хар өнгөтэй эвгүй үнэртэй зүйл гарах, хэвлийн доод хэсгээр базалж өвдөх, халуурах шинж бүхий умайн өвчин нь ямар махбодын хямралаас үүссэн болохыг тогтооно уу

- A. Хийнээс
- B. Цуснаас
- C. Шараас
- D. Бадганаас
- E. Хурмалаас

/220./ Өвчний суурь болох шар хэмжээнээсээ хэтэрвэл ямар өвчнийг үүсгэийг тодорхойлно уу

- A. Халуун өвчин
- B. Сарних шар
- C. Цөс цалгисан өвчин
- D. Цөсний ам алдарсан шар өвчин
- E. Бэтэг өвчин

/221./ Цөв эс шингэсэн идээний бэтэг ямар эрхтэнд үүсдэг болохыг тогтооно уу

- A. Ходоод

- B. Гэдэс
- C. Элэг
- D. Цөс
- E. Дэлүү

/222./ Эмчийн баруун гарын дунд хуруунд өвчтөний ямар цул сав эрхтэний судасны лугшилт мэдрэгдэхийг тодорхойлно уу

- A. Элэг,цөс
- B. Бөөр,давсаг
- C. Зүрх,гэдэс
- D. Уушги,олгой
- E. Дэлүү, ходоод

/223./ Элэгний хий өвчний үед илрэх онцлог шинж тэмдгийг тогтооно уу?

- A. Халуун усаар бөөлжих
- B. Толгой эргэх
- C. Нулимс гойжих
- D. Нүд улайх
- E. Үс, хөмсөг загатнах

/224./ Нуугдсан халуун өвчний эмчилгээний зарчмыг тогтооно уу?

- A. Эхэнд нь бүлээн шимтийг шүтүүлэх
- B. Сүүлд нь галын нурмыг усаар унтраах
- C. Дунд үед нь төөнөөр бүлээтгэх
- D. Шар ус хатаах эмийг илүү хэрэглэх
- E. Боловсруулах

/225./ Бөөр бэлхүүс нь янгинаж тахим нь татах шинжээр илэрдэг элэгний ямар өвчин байдгийг тогтооно уу

- A. Үхэр бөгтөр
- B. Элэг дэлгэрэх
- C. Гол хөших
- D. Элэгний хар хэрх
- E. Элэгний хий

/226./ Зогисох өвчний үед ямар хий хямрахыг тогтооно уу

- A. Амь баригч хий
- B. Дээш гүйгч хий
- C. Түгмэл гүйгч хий
- D. Гал тэгшитгэгч хий
- E. Уруу арилгагч хий

/227./ Шингэсэн оронд бор дэлгэрвэл ямар шинж илрэхийг тодорхойлно уу

- A. Харавтар өнгөтэй цусаар суулгана
- B. Утааны шүүс мэт зүйлээр бөөлжинө
- C. Энгэсгийн зайдас мэт зүйлээр бөөлжинө
- D. Шар өнгөтэй зүйлээр суулгана
- E. гэдэс мушгирч эс шингэсэн зүйлээр суулгана

/228./ Ханиалгана, улбар шар цэр гарна, халуурна, цээжээр хатгана, амьсгаа давхцана гэсэн зовиуртай эмчид хандсан. Уушгины ямар өвчин болохыг та тогтооно уу.

- A. Хижиг
- B. Хатгалга
- C. Уушиг дэлгэрэх
- D. Уушигны буглаа
- E. Уушгинд халуун бүрхэх

/229./ Биеийн ахуйн ёсны ангиллын зөв хариултыг сонгоно уу?

- A. Барилдах судасны, бэрх оньсны, тогтох судасны, хар судлын
- B. Гүйцэд хэмжээний, барилдах судасны, гүйх сүвийн, ясны
- C. Гүйх сүвийн, бэрх оньсны, амь насны, ясны
- D. Гүйцэд хэмжээний, барилдах судасны, бэрх оньсны, гүйх сүвийн
- E. Оньсны, цагаан судасны, тогтох судасны, барилдах судасны

/230./ Хуучирсан халууны нядлах танг тогтооно уу

- A. Норов 7
- B. Лидэр 7
- C. Гавар 3
- D. Хонилон 5
- E. Танчин 10

/231./ Нүүр цэлхгэр цайвар өнгөтэй, склер цагаан, хүүхэн харааны гадна доод буланд толбо үүссэн нь ямар махбодын бэлгэ чанар аривдсан болохыг тогтооно уу

- A. Хий
- B. Бадган
- C. Цус
- D. Шар
- E. Шар ус

/232./ Олгой хүйтнээр дүүрэх өвчний гол шинжийг олно уу?

- A. Ам хатах
- B. Бөөр бэлхүүсээр тасрах мэт өвдөх
- C. Өтгөн хатах
- D. Цайвар өнгөтэй зүйл эсвэл идээний өнгөөр суулгана
- E. Өвдөлтгүй суулгана

/233./ Дүржид ямар хэлбэрийн хорын бүлэгт хамаарахыг тогтооно уу

- A. Ямаан зангуу
- B. Шимийн найрлага
- C. Бодитой хорын найрлага
- D. Өвсөн найрлага
- E. Чулуун найрлага

/234./ Эс шингэсэн өвчнийг ерөнхийд нь тунгалаг эс шингэсэн, цөв эс шингэсэн гэж юуг нь баримтлан ангилдаг болохыг тогтооно уу

- A. Язгуурыг
- B. Орныг
- C. Өвчилсөн цаййг
- D. Мөн чанарыг
- E. Нөхрийг нь баримтлан ангилах

/235./ Шар усны өвчний судасны лугшилтын онцлог ямар болхыг тогтооно уу

- A. Хөндий хоосон үе үе зогсох
- B. Нарийн эрчимтэй
- C. Живэнгүй дорой
- D. Товойж хуйлрах
- E. Чичирч гүйхэд бэрх

/236./ Уламжлалт зохиолуудад тархины хэлбэрийг (шинжийг) толгойн хэлбэр, биеийн өвөрмөц чанартай уялдуулан «... толгойн хэлбэрийн орой нь өндөр, махан тархитай хэмээх нь махны төдий агшуун байх бөгөөд өчүүхэн хагарагч гэм нь бага...» гэсэн байдаг нь ямар өвөрмөц чанартанд илүүтэй тохиолдохыг сонгоно уу.

- A. Шарын өвөрмөц чанартан
- B. Бадганы өвөрмөц чанартан
- C. Хийн өвөрмөц чанартан
- D. Хий, шар хавсарсан өвөрмөц чанартан
- E. Бадган, шар хавсарсан өвөрмөц чанартан

/237./ Халууны хоосны үед ямар шинж илрэхийг сонгоно уу

- A. Судас нь дээрээ түргэн доороо хоосон
- B. Нүд шарлах
- C. Хамрын нүх сарталзаж, ам их цангах
- D. Гадар халуун их
- E. Хоосноор огих

/238./ Тархи доргисон үед судасны лугшилт аль болохыг тогтооно уу

- A. Ядам хурууны доор судас чичрэх
- B. Долоовор хурууны дор судас хатуу лугших
- C. Дунд хурууны дор судас илүү эрчимтэй

- D. Дунд хурууны дор судас даралт тэсвэрлэхгүй
E. Долоовор хурууны судас чичрэх
- /239./ Усан сааны үүсэх шалтгааныг тодорхойлно уу?
A. Хий бадганы урвалтаар цагаан судас гэмтэх
B. Шарын урвалтаар цагаан судас гэмтэх
C. Мэдрэхүйн сүв хаагдснаас үүсэх
D. Шар усны гэмээс болох
E. Элэгний шар хөөх
- /240./ Бадган өвчний үед илрэх магадтай шинж аль болохыг тодорхойлно уу
A. Хэхрүүлэх
B. Суулгах
C. Бие хүндэрч, залхуурах
D. Ам гашуу оргих
E. Толгой өвдөх
- /241./ Эс шингэсэнд шар хавсарвал ямар эмчилгээг сонгохыг тогтооно уу
A. Төөнө
B. Бүлээн жин ба зөөлөн шимт
C. Бөөлжүүлэг
D. Туулга
E. Хануур
- /242./ Өвчтөний судас барихад урьдчилан хийх бэлтгэл юу байдгийг тогтооно уу?
A. Хоол их идэх
B. Бие хэл сэтгэлийн үйлийг хэвийн байлгах
C. Халуун ногоо харьцангуй их хэрэглэх
D. Жимс ногоо сайн идэх
E. Ходоод угаах
- /243./ Уушги дэлгэрэх өвчний үед илрэх шинж тэмдгийг тогтооно уу
A. Нүд шарлах
B. Нүд улайх, хэл борлох
C. Хараа муудах
D. Улбар шар цэр гарах
E. Идээтэй цэр гарах
- /244./ Бөөрөнд булингартсан халуун буусан үеийн эмчилгээг сонгоно уу
A. Эхлээд брагшун 9 өгч ханана
B. Брагшун, башига, наймаалж, ар үр, шар мод өгөх
C. 11 – р үеийг төөнөх
D. Бөөрний ар үр 10 өгөх
E. Марав 3 өгөх
- /245./ Элэгний хүйтэн өвчний үед илрэх шинжийг тодорхойлно уу?
A. Ходоод элэгээр хавсарч өвдөх
B. Олон эвшээж нулимс гоожих
C. Зулай хүнд оргих
D. Гадар халуун их
E. Хамраас цус гоожих
- /246./ Ундаасах өвчний үед ямар ундаа тохиромжтой болохыг тогтооно уу
A. Сүү
B. Чихэртэй ус
C. Хурын усыг балтай найруулах
D. Таргийг балтай найруулах
E. Бурамтай ус
- /247./ Бор өвчний өвдөлтийн онцлог шинжийг тогтооно уу
A. Халуун цагт хүйтэн заслаар намжина
B. Бөөлжүүлвэл намжина
C. Өд үгүй өвдөж засалгүй намжина
D. Хөлрөөд даарсны дараа өвдөнө
E. Цадах дулаацах зэрэгт өвдөнө

/248./ Уушиг дэлгэрэх өвчний цэрний онцлог шинжийг тодорхойлно уу

- A. Цайвар хөх
- B. Улаан өнгөтэй
- C. Давслаг шар
- D. Сэвсгэр хөөстэй
- E. Хөхөлбөр

/249./ Бие тогтох үндсэн 3 судасны дунд биед орших судаснаас ямар судас үүсдгийг тогтооно уу?

- A. . Бадганы судас
- B. Хийн судас
- C. Хурмалын судас
- D. Амин судас
- E. Усан судас

/250./ Халуун өвчнийг засах гол зарчмыг тогтооно уу.

- A. Настай нь уялдуулж засах
- B. Шарыг дарж цусыг шингэлэх
- C. Халуун өвчний тухайн цагийг үндэслэх
- D. Махбодыг тэгштгэх
- E. Оронтой нь уялдуулан засах

/251./ Шарын өвчний үед нүдэнд гарах онцлог шинжийг тогтооно уу?

- A. Харц тогтворгүй, уураглаг давхарга хөх өнгөтэй,толбогүй
- B. Харц ширүүн, өөхөн унжлагатай,шар өнгөтэй
- C. Зовхи сэлхэрсэн,уураглаг бүрхүүл цайвар
- D. Хүүхэн харааны дээд хэсэгт судас өргөссөн
- E. Хүүхэн харааны доод хэсэгт толбо суусан

/252./ Гэдэс халууны гэмээр суулгах үед өгөх жорыг сонгоно уу

- A. Гагол-4
- B. Сэнгэр-15
- C. Сожид
- D. Баатар-7
- E. Шижид-6

/253./ Хорын өвчний үед нүд өвдөх өрцөөр хатгуулах шараар бөөлжих зулай хүндрэх шүлсээ гоожуулах шинж илрэх нь ямар эрхтэний системд нөлөөлсний шинж болохыг тогтооно уу

- A. Яс, үес
- B. Уушиг
- C. Элэг
- D. Дэлүү
- E. Бөөр

/254./ Эс шингэсэн өвчнөөр ямар өвөрмөц чанарын хүмүүс ихэвчлэн өвдөх магадлалтай болохыг тогтооно уу

- A. Шарын өвөрмөц чанартан
- B. Идэр залуу хүмүүс
- C. Хүйтэн, хийн өвөрмөц чанартан
- D. Цусны өвчнөөр өвчилсөн хүмүүс
- E. Хурмал чанартай хүмүүс

/255./ Бадган өвчний судасны лугшилтын онцлог ямар болохыг тогтооно уу

- A. Хөндий хоосон үе үе зогсох
- B. Нарийн эрчимтэй
- C. Живэнгүй дорой
- D. Товойж хуйлрах
- E. Чичирч гүйхэд бэрх

/256./ Бахуу (ашиг), булчирхай гарах, хэт мярайлах (таргалах) нь ямар эмгэгийн шинж вэ?

- A. бадган арвидах
- B. мах арвидах
- C. өөх арвидах

- D. шар хасагдах
- E. чөмөг хасагдах

/257./ Халууны хоосон яаж үүсхийг сонгоно уу

- A. Гол судсанд халуун бууснаас үүснэ
- B. Халуун барагдаж хий арвидсанаас
- C. Халууны сүүлийг хийгээр үлээснээс
- D. Хий дийлэнх эс боловсорсон халуунд хануур туулга эс хэрэглэснээс
- E. Намрын цагт үүснэ

/258./ Дэлгэрсэн халуун хоосорсон халууны судсыг ямар шинжээр эндүүрч болхыг тогтооно уу

- A. Эн бүдүүн
- B. Эн нарийн
- C. Лугшилтын тоо
- D. Судасны хүч
- E. Даралт тэсвэрлэх чанар

/259./ Хүйтэн чанартай цагаан судасны өвчний үед илрэх шинж тэмдгийг тодорхойлно уу?

- A. Шээс тунгалаг хөөс жижиг
- B. Биеийн илч арвидах
- C. Судас нарийн түргэн
- D. Шээс нь үнэр уур их
- E. Судас алгуур зөөлөн эрчимтэй

/260./ Хэл алаг болох, цусаар суулгах, хэвлийн хөөх, цанхайх, зүүн хөл хавдах нь ямар эрхтэнд шар буусны шинж болохыг тодорхойлно уу

- A. Дэлүү
- B. Элэг
- C. бөөр
- D. Ходоод
- E. Зүрх

/261./ Эс шингэсэн өвчинтэй хий хавсарвал ямар эмчилгээ тохирхыг сонгоно уу

- A. Төөнө
- B. Бүлээн жин ба зөөлөн шимт
- C. Бөөлжүүлэг
- D. Туулга
- E. Хануур

/262./ Элэгний сувагт унах өвчний үед ямар засал үр дүнтэй болохыг тогтооно уу

- A. Бөөлжүүлэг засал
- B. Туулга засал
- C. Рүтүн
- D. Судсан туулга хийх
- E. Лонза, жиншүг ханах

/263./ Зүрхний халуун дэлгэрэх өвчний үед илрэх шинж тэмдгийг тогтооно уу?

- A. Нүд улайх, зүрх мушгирах мэт болох
- B. Зүрхийг хутгаар хэрчиж буй мэт санагдах
- C. Зүрхийг хөрөөдөх мэт өвдөх
- D. Хэл хуурай богино болох
- E. Халуурах

/264./ Халуун булингартсанд тохирх эмчилгээг сонгоно уу

- A. Эхэнд нь бөөрөлзгөнө 3 тан өгнө
- B. Дараа нь чацаргана 5 өгч цэрийг татах
- C. Дунд нь сэндэн 9 өгч шар усыг хатаана
- D. Сүүлд нь гавар 25 өгч сүүлийг хураах
- E. Үр дүн муутай бол 3 үрийн үргэлжийн туулга өгнө

/265./ Элэг дэлгэрэх өвчний шлтгаан аль болохыг тогтооно уу

- A. Шар
- B. Бадгана
- C. Хий

- D. Цус
- E. Хорхой

/266./ Бөөрний гэмээр ундаасах өвчний үед ямар махбодын хямрал давамгайлхыг тогтооно уу

- A. Хий
- B. Шар
- C. Бадгана
- D. Шар ус
- E. Хий шар

/267./ Хүч багасах, үг цөөрөх, бие амаргүй болох, дурьтгал үл тодорч, бадган арвидсан шинж илэрсэн үеийн хий махбодын бэлгэ чанарыг тодорхойлно уу?

- A. Хий махбод аривдсан
- B. Хий махбод хямарсан
- C. Хий махбод хорогдсон
- D. Хий махбод бусад махбодтой хавсарсан
- E. Хий махбод хурсан

/268./ Уушгины мэнгэр юунаас шалтгаалж үүсдгийг тодорхойлно уу

- A. Шар ус хуралдах
- B. Хий цугларах
- C. Бадгана салс ихсэх
- D. Цус хямрах
- E. Халуун дэлгэрэх

/269./ Хий шар хавсарсан бэлгэсийн завсар нэвчрэх өвчний шинжийг олно уу?

- A. Цус их гарах
- B. Гөвдрүү нь амархан боловсрох
- C. Гүвдрүү цайвар
- D. Идээ гоожих
- E. Гүвдрүү ихсэх багасах

/270./ Ерийн халуун өвчний нууц шинжийг тогтооно уу

- A. Шээс нь улаан шар
- B. Идээ шингэх үед өвдөх
- C. Тэнсэх тан өгөх
- D. Цэр нь улаан шар гарах
- E. Үмхийгээр суулгах

/271./ Бадган бор, шар усны өвчний шээс бор өнгөтэй байдаг. Ийм үед ямар шинжээр ялгаж болохыг тогтооно уу

- A. Хөөс
- B. Тунгалаг чанар
- C. Язмаг
- D. Үнэр
- E. Уур

/272./ Гэдсэнд ямар хэлбэрийн бор илүү тохиолдхыг тогтооно уу

- A. Хуйлрах
- B. Нуугдах
- C. Дэлгэрэх
- D. Сарних
- E. Эс нуугдах

/273./ Хатгалга ба шээс хаагдах нь аль найруулгын үед үүсч болохыг тогтооно уу

- A. Махны найруулга
- B. Алаг бамбууны найруулга
- C. Мөнгөн усны найруулга
- D. Эрдэнийн найруулга
- E. Чулууны найруулга

/274./ Усан хаван өвчнийг 5 үндсэн зарчмаар эмчилдэг. Бонагийн жорыг аль зарчмын дагуу сонгохыг тогтооно уу

- A. Сувгийн усыг замд нь оруулах мэтээр анагаах

- B. Хавангийн усыг оронд нь хатаах мэт засах
- C. Туулгаар засах
- D. Нуурын усыг горхилон татах мэт засах
- E. Судасны хавцлыг боож төөнөх

/275./ Хий өвчний судасны лугшилтын онцлог ямар болхыг тогтооно уу

- A. Хөндий хоосон үе үе зогсох
- B. Нарийн эрчимтэй
- C. Живэнгүй дорой
- D. Товойж хуйлрах
- E. Чичирч гүйхэд бэрх

/276./ Өөрийн орон нь хоосрох бөгөөд толгой эргэх, зүрх чичрэх, үений завсар сулрах мэт санагдах нь аль тохиолдолд илрэх вэ?

- A. хий арвидах
- B. бадган хасагдах
- C. цус хорогдох
- D. чөмөг хасагдах
- E. хий хямрах

/277./ Элэгний халуунд ямар эмчилгээ хийхийг тогтооно уу

- A. Башига, балига, гүргэм, дэгд өгч рүтүн ханах
- B. Талх эм 3 үр өгөх
- C. Домти өгөх
- D. Гиван өгөх
- E. 3 улааны тан өгөх

/278./ Цусны болон хийний судсыг ямар шинжээр эндүүрч болхыг тогтооно уу

- A. Эн бүдүүн
- B. Эн нарийн
- C. Лугшилтын тоо
- D. Судасны хүч
- E. Даралт тэсвэрлэх чанар

/279./ Раднаа судас гэмтсэн үед илрэх шинжийг сонгоно уу

- A. Хөл татаж хөших
- B. Сүүж бэлхүүсээр хөшнө
- C. Нүүр ам муруйна
- D. Тал бие бадайрна
- E. Судас эрчимтэй

/280./ Эмчилгээний үр дүнд нүд, шээс, нүүрний өнгө урьдахаас цайж, ундаасах, идээнд дургүй болох шинж нь арилахгүй байвал ямар засал, үйл хийвэл үр дүнтэй болохыг тогтооно уу

- A. Ханах
- B. Бөөлжүүлэх
- C. Жин
- D. Туулгах
- E. Усан засал

/281./ Хүч ихтэй эс шингэсэн өвчин биеийн дээд хэсэгт оршвол ямар засал үр дүнтэй болохыг тогтооно уу

- A. Туулга
- B. Бөөлжүүлэг
- C. Нирухаар татуулах
- D. Хануур
- E. Бүлээн жин

/282./ Уушгины ус алдах өвчний үед цэрэнд гарах шинжийг олно уу.

- A. Махны нитгэл мэт
- B. Цайвар сэвсгэр хөөстэй
- C. Цустай цэр
- D. Хөх салслаг цэр
- E. Цайвар шар өнгийн цэр

/283./ Усан хаван өвчинг дахиулахгүйн тулд, хэрэглэдэг идээ ундаа эмийг сонгоно уу?

- A. Тарваганы мах
- B. Ногооны зүйл
- C. Халуун ногоо
- D. Таван үндэсний тосон эм, илжигний мах
- E. Дэгдийн тосон эм

/284./ Булингартсан халуун бөөрөнд буувал ямар шинж илрэхнийг тогтооно уу

- A. Гэдийж бөхийхөд зовиурлана
- B. Бэлхүүс өвдөж доод бие хүнд оргих
- C. Шээсний сүвээр шархирч өвдөх
- D. Бөөрний судас таталдаж маш хүчтэй өвдөх
- E. Шээсний сүвээр халуу оргих

/285./ Бөөрний ус алдах өвчний шинжийг олно уу?

- A. Цусаар шээх
- B. Өлмий хавдах
- C. Чих дүлийрэх
- D. Шээс чавдагшрах
- E. Шээс задгайрах

/286./ Тулай өвчний үед илэрдэг магадтай шинжийг тогтооно уу?

- A. Том үеэнд хавдар их
- B. Өглөөд үений хөшинги их
- C. Тамирдаж турах
- D. Хоёр талын тавхайн үе үрэвсэх
- E. Нэг талын эрхий хуруу улайж хавдах

/287./ Шар усны өвчнийг үүсгэх шалтгааныг тогтооно уу

- A. Цөс өвчлөх
- B. Эрүүл шар ус
- C. Шар ус аривдах
- D. Шар ус хорогдох
- E. Шар ус , цус

/288./ Доод бие хүйт оргих, бэлхүүсээр шархирч өвдөх шээс чавдагшрах, дусал гоожих, гуяны булчин дагаж өвдөх нь бөөрний ямар өвчний шинж тэмдэг болохыг тогтооно уу.

- A. Бөөр гэмтэж өвчний урхаг биеийн дунд хэсэгт нөлөөлөх
- B. Бөөрний хэрх
- C. Бөөрний дарган
- D. Бөөрний архаг
- E. Бөөрний халуун

/289./ Муу цусны гэм дийлэнх шанбарам өвчний шинжийг олно уу?

- A. Хуурайших
- B. Гүвдрүү нь алаг
- C. Атираа сулрах
- D. Гүвдрүү нь шүр мэт
- E. Хорхой ихсэх

/290./ Ерийн халуун өвчний дотор шинжийг хэрхэн тодорхойлохыг тогтооно уу

- A. Судас нь дэлгэрэнгүй, эрчимтэй
- B. Нэг газар хүчтэй хатгуулна
- C. Исгэлэн гашуун амт амтагдах
- D. Судас нь дорой
- E. Толгой хүчтэй өвдөнө

/291./ Шээсний өнгө улаан, өтгөн булингартай, хувирсны сүүлд өтгөн хэвээр байх нь ямар өвчний шээс болохыг тогтооно уу

- A. Дэлүү
- B. Бадган
- C. Цус
- D. Шар ус
- E. Элэг

/292./ Гэдэс хаагдах өвчин ямар шалтгаантай болохыг тогтооно уу?

- A. Бадган хий
- B. Нян хорхой
- C. Цус шар
- D. Шар ус
- E. Цус

/293./ Бона, чонын хор нь бодитой хорын аль ангилалд багтахыг тогтооно уу

- A. Үл гүйх хор
- B. Гүйх хор
- C. Хүчтэй хор
- D. Урвасан хор
- E. Найруулсан хор

/294./ Хэвлий томорч судсууд гүрвийж тодрон үе мөч нь нарийсч хатингартан , турж эцэх шинж гарах нь ямар эрхтэний усан хаван болохыг тогтооно уу?

- A. Бөөр
- B. Элэг
- C. Уушги
- D. Дэлүү
- E. Зүрх

/295./ Судасны лугшилт махны доогуур шургаж лугшдаг дэлгэрэнгүйн эсрэг ямар судас байдгийг тогтооно уу

- A. Живэнгүй
- B. Сулхан
- C. Балархай
- D. Алгуур
- E. Дорой

/296./ Сэтгэл санаа тогтворгүй болох, толгой эргэх, хэл улайн хуурайших, судас нь хөндий хоосон, шээс ус мэт болох нь ямар тохиолдолд нь илэрхийг тодорхойлно уу

- A. хий арвидах
- B. цус хорогдох
- C. бадган хасагдах
- D. өөх хасагдах
- E. хий хямрах

/297./ Хөлөргөх засал ямар өвчний үед илүү ач холбогдолтой болохыг сонгоно уу

- A. Гэмтсэн халуун өвчин
- B. Ам заваарах гэм
- C. Нян цанх өвчин
- D. Хижиг өвчин
- E. Хямарсан халуун өвчин

/298./ Булингартсан халуун өвчний судасны лугшилтын онцлог ямар болхыг тогтооно уу

- A. Нарийн эрчимтэй
- B. Нарийн гүндээ түргэн
- C. Доороо эрчимтэй
- D. Бүдүүн чанга түргэн
- E. Балархай

/299./ Хэнхдэг цээжний цагаан судасны өвчний үед илрэх шинж тэмдгийг тодорхойлно уу ?

- A. Сэтгэл санаа үймрэх
- B. Дуу чимээнд өвчин нэмэгдэх
- C. Хөл бадайрах
- D. Үе мөч татах
- E. Ухаан алдах

/300./ Биеийн илч ихдэх, мах арьс хөхрөн харлах, нүд шарлах, холын хараа муудах нь ямар өвчний шинж вэ?

- A. Шингээгч шар
- B. Өнгө урвуулагч шар
- C. Бүтээгч шар

- D. Үзүүлэгч шар
- E. Өнгө тодруулагч

/301./ Бадганаас болсон дуу хаагдах өвчний үед ямар засал үр дүнтэй болохыг тодорхойлно уу

- A. Тосон жин тавих
- B. Жүр үрийн тан өгч бугуйн судсыг ханах
- C. Төөнөх
- D. Молор давсыг хамрын эм болгох
- E. Бөөлжүүлэг засал хийж төөнөх

/302./ Хутгаар хэрчих мэт өвдөлт зүрхний ямар өвчний үед илэрдгийг тогтооно уу

- A. Хий хатгалга
- B. Цусан хатгалга
- C. Халуун дэлгэрэх
- D. Халуун үймэлзэх
- E. Шарын хатгалга

/303./ Доорхи шинж тэмдгүүдээс хий мах бодийн нэмэгдсэн үед илэрдэг шинжийг сонгоно уу

- A. Судас хөндий хоосон, сэтгэл санаа тогтворгүй, дэмийрэх
- B. Санаа алдах, толгой эргэх, чих шуугих, эхүүн амт амтагдах
- C. Хэсэж хатгуулах, яс хугарах шиг, арьс мах салах шиг, үе мөч хүлэгдсэн

мэт болох

- D. Бие хатингартан харлах, дулаан орчинд таатай, бие чичрэх, хэвлий хөөх
- E. Шар үс зарайж, жихүүцэх, эвшээн чичирч, суниахад дуртай болох

/304./ Булингартсан халуун уушгинд буувал ямар шинж илрэхийг тогтооно уу

- A. Халуун босож нүд улайх
- B. Сэвсгэр хөх цэртэй ханиах
- C. Амархан тамирдах
- D. Нүд, уруул, хөлний өлмий хавагнах
- E. Дээд зовхи сэлхрэх

/305./ Бөөр доргисон гэм дээд биед сарнивал ямар шинж тэмдэг илрэхийг сонгоно уу

- A. Сүүжний нүхээр хатгуулж өвдөнө
- B. Хөлөө чирэх
- C. Нуруугаар өвдөх
- D. Судас нь эрчимтэй
- E. Цусаар шээх

/306./ Зүүн хавирганы нумаар хатгуулах, эс шингэснээр суулгаж хэвлий хөөж хоржигнон ам заваарах нь ямар эрхтэний суулгалтын шинж болохыг тогтооно уу

- A. Цөсний халуунаар суулгах
- B. Ходоодны халуунаар суулгах
- C. Дэлүүний суулгах
- D. Галын илч буурсан бадгана өвчний суулгалт
- E. Эс шингэсэн өвчний суулгалт

/307./ Суман мод 6 танг цусны өвчний ямар хэлбэрийн үед гол болгон сонгохыг тодорхойлно уу

- A. Цус хөөрөх
- B. Цус царцах
- C. Цус барагдах
- D. Цус гоожих
- E. Цус 3 гэмд хорлогдох

/308./ Улирлын биохэмнэлтэй уялдуулан хавар т од эрхэсийн нөлөөллийн дагуу модон махбод дэлгэрдэг. Энэ үед ямар эрхтэний судасны лугшилт өөрчлөгдөх вэ?

- A. Элэгний судас богширгоны дуу мэт нарийн эрчимтэй лугшина.
- B. Зүрхний судас дэлгэрэх бөгөөд хөхөөний дуу мэт бүдүүн уртлаг лугшина.
- C. Бөөрний судас дэлгэрэх бөгөөд чүүчлын дуу мэт зөөлөн алгуур лугшина
- D. Хитрүүгийн дуу мэт ахар зөөлөн лугшина

- Е. Завсрын 18 хоног шороо махбодтой дэлүүний судас дэлгэрнэ.
- /309./ Бадган өвчний шээсний язмагын онцлог шинж аль болохыг тогтооно уу
- А. Үс бутарсан адил нарийн
 - В. Хөвөн зулсан мэт зузаан
 - С. морины үс мэт
 - Д. Язмаг нь үүл адил
 - Е. Элс шиг ёроолдоо тунана
- /310./ Шинар-6 ходоодны ямар өвчний гол ерөндөг болохыг тогтооно уу
- А. Ходоодны борын улмаас бөөлжих
 - В. Ходоодны шараас болж бөөлжих
 - С. Ходоодны хор харших
 - Д. Ходоодны бадганаас болж бөөлжих
 - Е. Ходоодны хийгээс болж бөөлжих
- /311./ Өвчтөн хоолонд хордоод сүүг давстай найруулж уусны дараа алжааж ядрах, бие хүндрэх, нус шүлс элбэгших, хоолонд дургүй болох шинж илэрчээ. Ямар эмчилгээ хийж болохыг тогтооно уу
- А. Илчийг сэлбэх
 - В. Туулга засал
 - С. Өвчнийг хураах
 - Д. Хүч ихтэй эмээр нядлах
 - Е. Идээ ундаагаар засах
- /312./ Тунгалагийн ус сарнисан хүйтэн усан хавангийн болох ёсыг тогтооно уу
- А. Тунгалагийн мөрт хүйтэн шар ус алдагдах
 - В. Эс шингэснээр ходоодонд бадган салс цугларсан
 - С. Уруу арилгагч хийн мөр хаагдснаас шээс тунгалагийн гүйх сүвэнд орсон
 - Д. Шээсийг тунгалагийн мөрт алдсан
 - Е. Элгэнд цус цалгисан
- /313./ Судасны эн өндөр, даралт тэсвэрлэх чадвар маш сайн лугшилтийн хүч сайн, хөгжмийн чавхдас дээр дарах мэт илэрдэг ямар судас байдгийг тогтооно уу
- А. Хатуу
 - В. Дэлгэрэнгүй
 - С. Хуйларсан
 - Д. Чанга
 - Е. Эрчимтэй
- /314./ Хий өвчнийг хөдөлгөх нөхцөлийг тодорхойлно уу.
- А. гашуун, хөнгөн, ширүүнийг хэтрүүлэх
 - В. гашуун, ширүүн, бүлээнийг хэтрүүлэх
 - С. хөнгөн, хөлбөрөнгүй, тослогийг хэтрүүлэх
 - Д. гашуун, хөнгөн, гошууныг хэтрүүлэх
 - Е. хөлбөрөнгүй, гашуун, бүлээнийг хэтрүүлэх
- /315./ Гэмтсэн , хямарсан халууныг эмчлэхэд ямар танг гол болгох вэ?
- А. Дева 5
 - В. Хонилон 5
 - С. Банздо 12
 - Д. Жуган 8
 - Е. Гавар 3
- /316./ Нуугдсан халуун өвчний судасны лугшилтын онцлог ямар болхыг тогтооно уу
- А. Нарийн эрчимтэй
 - В. Нарийн ёроолдоо түргэн
 - С. Доороо эрчимтэй
 - Д. Бүдүүн чанга түргэн
 - Е. Балархай
- /317./ Нуруу бүсэлхийгээр тасрах мэт өвдөх, ходоод цанхайж хоолны шингээлт муудах, ууц нуруугаа даахгүй болох, хэвлийн доод хэсгээр тасралтгүй өвдөж шээс боогдоно. Ямар бэтэг өвчний шинж болохыг тогтооно уу
- А. Савны усан бэтэг

- В. Цусан бэтэг
- С. Махан бэтэг
- Д. Булчирхайн бэтэг
- Е. Судасны бэтэг

/318./ Зүрх суларч байгаа мэт бодогдох амьсгаа давхцах ундаасах дур амаргүй болох бие чичрэх, уушги зүрх халуу оргих нь ямар өвчний шинж болохыг тогтооно уу

- А. Шингээгч шар
- В. Өнгө урвуулагч шар
- С. Бүтээгч шар
- Д. Үзүүлэгч
- Е. Өнгө тодруулагч

/319./ Дотор чичэрч нойр багасах, зүрх чичэрч байн байн эвшээх нь зүрхний ямар өвчний шинж болохыг тодорхойлно уу?

- А. Зүрхний долгиол
- В. Зүрхний шар ус
- С. Зүрхний хийгээр хатгах
- Д. Зүрхний хатгалга
- Е. Зүрхний будангуйрал

/320./ Ерөндөг – 7 жорыг аль өвчинд тохирхыг сонгоно уу?

- А. Шар бадгана өвчин
- В. Аюулхайн бадган өвчин
- С. Барилдуулагч бадганы гэмд
- Д. Бор бадгана өвчин
- Е. Галын илч буурсан бадган өвчинд

/321./ Өвчний суурь болох шар хэмжээнээсээ хэтэрвэл цаашид ямар өвчин болж хүндрэхийг тогтооно уу

- А. Сарних шар
- В. Бие шарлах шар
- С. Цөсний шар
- Д. Халуун өвчин
- Е. Цаяннагво

/322./ Мах хатах, үе сэлхрэх, тамхи татах, шүд хумсны өнгө буурах нь булингартсан халуун хаана буусны шинж болхыг тогтооно уу

- А. Маханд дэлгэрсэний шинж
- В. Хуучирсан халууны шинж
- С. Булингартсан халууны шинж
- Д. Судалд гүйсний шинж
- Е. Булингартсан халуун ясанд шунасаны шинж

/323./ Бөөрний дарган өвчний үед хийгддэг гол заслыг сонгоно уу

- А. Туулга
- В. Хануур
- С. 5 рашаан дэвтээлэг
- Д. Төөнө
- Е. Хатгуур

/324./ Ходоодны бадгана өвчний бөөлжисний онцлогийг тогтооно уу

- А. Хөөс их байх
- В. Хүрэн бор өнгөтэй байх
- С. Цустай бөөлжих
- Д. Салс ихтэй бөөлжих
- Е. Утааны шүүс шиг зүйлээр бөөлжих

/325./ Цусны өвчнийг эмчилэхэд ямар жорыг гол болгон сонгодог болохыг тодорхойлно уу?

- А. Гүргэм 7
- В. Зандан 3
- С. Дэгд 8
- Д. Хонилон 4
- Е. Жуган 8

/326./ Бөөр гэмтээд дээд биед сарнисан үед эхэлж хийх заслыг сонгоно уу.

- A. Дэвтээлэг
- B. Хануур
- C. Төөнүүр
- D. Соруул
- E. Жин

/327./ Булмнгартсан халууны шинжийг зөв тодорхойлно уу.

- A. Шүд шарлах
- B. Шүд хувхайрч өнгөө алдах
- C. Шүдээ хавирч унтах
- D. Шүдэнд хар толбо тогтох
- E. Шүд сулрах

/328./ Цус шарын хувь дийлэнхи эс боловсорсон халуун өвчин цаашдаа ямар өвчинд шилжиж болохыг тогтооно уу

- A. Хоосорсон
- B. Булингартсан
- C. Хямарсан
- D. Хуучирсан
- E. Хорын халуун

/329./ Уушгиний өвчний шээсний язмагын онцлогийг тогтооно уу

- A. Үс бутарсан адил нарийн
- B. Хөвөн мэт зузаан
- C. Хялгас мэт нарийн жижиг
- D. Язмаг нь үүл адил
- E. Элс шиг ёроолдоо тунана

/330./ Өвчтөн 72 настай сүүлийн үед хоол унд идээд цаддаггүй , хоол унд идээд тэр даруйдаа суулгадаг гэсэн зовиуртай эмчид хандсан. Үзэхэд маш их турж эцсэн, хэвлий цардайж томорсон, тамир тэнхээ муутай байлаа та оношоо тогтооно уу

- A. Аюулхайн бадган
- B. Галын илч буурсан бадган
- C. Цагаан хэрх бадган
- D. Хоолой хаагдах бадган
- E. Шингэн хатаагч бадган

/331./ Хорын өвчний халууны хүч их, өвчтөн тамир сайтай, ходоод гэдэсний үйл ажиллагаа хэвийн бол нядлах найрлагыг тогтооно уу?

- A. Өвсөн найрлага
- B. Шимийн найрлага
- C. Эрдэнийн найрлага
- D. Чулуун найрлага
- E. Бодитой найрлага

/332./ Шээс цугларсан усан хавангийн өвчин болох ёсыг тогтооно уу

- A. Идээний тунгалаг элгийг дамжихдаа боловсролт алдагдсан
- B. Цөсний ам цалгих
- C. Шээс тунгалагийн мөрт алдагдсан
- D. Шээс аажмаар цугларч үүсэх
- E. Цөс сарниж үүсэх

/333./ Судасны эн нарийн дарахад зогсохгүй эрчилсэн утас шиг хүчтэй лугшдаг нь ямар судас болхыг тогтооно уу

- A. Хатуу
- B. Дэлгэрэнгүй
- C. Хуйларсан
- D. Түргэн
- E. Эрчимтэй

/334./ Хуйлрах хэлбэрийн бор өвчин цувирвал ямар шинж тэмдэг илрэхийг тодорхойлно уу

- A. Өрц нуруугаар хатгуулж өвдөх
- B. Хэвлийн судаснууд гүрвийх

С. Шээс хөөс ихтэй болох

D. Өтгөн хатах

E. Ам заваарах

/335./ Дэлгэрсэн халуун өвчний ялгах танг сонгоно уу?

A. Дева 5

B. Хонилон 5

C. Дэгд, лидэр, жүр үр, башгын тан

D. Гавар 3

E. Танчин 10

/336./ Дэлгэрсэн халууны судасны лугшилтын онцлог ямар болхыг тогтооно уу

A. Нарийн түргэн балархай живэнги

B. Ширүүн долгигож солилцон лугшина

C. Нарийн түргэн хөлбөрөнгүй

D. Хатуу эрчимтэй

E. Хоосон түргэн

/337./ Шимжүүлэх жүдлэнг ямар насны хүмүүст хэрэглэвэл үр дүнтэй болохыг тогтооно уу

A. Настай хүмүүст

B. Залуу хүмүүст

C. Хүүхдэд

D. Элэгний өвчтэй хүмүүст

E. Бөөрний өвчтэй хүмүүст

/338./ Мүгво олгойд унасан үед ямар өвчний шинж илрэхийг тогтооно уу

A. Шарын

B. Хийний

C. Бадгана

D. Цусны

E. Шар усны

/339./ Мартамхай болох, сэтгэл санаа зовох, залхуурах, нойр ихдэх, дотор чулуу дүүжилсэн мэт санагдах нь ямар өвчний шинж болохыг тогтооно уу

A. Зүрхний халуун дэлгэрэх

B. Зүрхний халуун нуугдах

C. Зүрхний хатгалга

D. Зүрхний долгигол

E. Зүрхний будангуйрал

/340./ Үзүүлэгч шарын өвчний шинжийг олно уу

A. Цавь сугаар загатнах

B. Толгой өвдөх

C. Эцэж турах

D. Өтгөн сэвсгэр, цайвар болох

E. Хамраас цус гарах

/341./ Хуурсан гурилыг шар тосонд багсраад сүүнд чанаж гаа, молор, давсыг хийж найруулбал хий өвчнийг анагаах ямар гаргалт болхыг тогтооно уу

A. Исгэлэн

B. Цагаан

C. Улаан

D. сармисны

E. Тосон

/342./ Халуунаар булингартах үеийн ерөнхий шинж ямар байхыг тогтооно уу

A. Тамир дорой, хөдөлбөл зүрх дэлсэх

B. Нойр их байх

C. Зүрхээр хатгах

D. Хэл, буйл улайх

E. Ханиах нь олон

/343./ Бөөрний сувагт унах өвчний үед илрэх шинж тэмдгийг тодорхойлно уу?

A. Өвдөг өлмий хавдах

B. Цусаар шээх

- C. Бэлхүүсээр муруйх
- D. Сүүжний нүхээр эвэршээх
- E. Хөлөө чирэх

/344./ Аахар шаахар өвчний бүлэгт загасны цөс, баавгайн цөс, мэлхийн цөсийг найруулж түрхэх тухай заасн байдаг. Үүнийг ямар өвчний үед хэрэглэхийг тогтооно уу

- A. Галд түлэгдсэн шарх
- B. Хоолойд өргөс орох
- C. Хөх хавдах
- D. Чихэнд хорхой орох
- E. Загасны ясанд хахах

/345./ Цусны өвчнийг язгуураар нь яаж ангилдгийг тогтооно уу

- A. Цус 3 гэмд хорлогдох
- B. Цусны гэмээр арьсанд тууралт гарах
- C. Цус гоожих өвчин
- D. Цус хөөрөх, царцах, барагдах
- E. хий цус бүрэлдсэн

/346./ Бөөрний ямар өвчний үед судсан туулга чухал байдаг вэ?

- A. Бөөрний халуун
- B. Бөөрний хэрх
- C. Бөөр гэмтэх
- D. Бөөрний ус алдах өвчин
- E. Бөөрний хий

/347./ “Номлохуйн үндэс”-т эмийг өгөхдөө “цаггүй үргэлжлэх” (дүймэд зэгүр) гэсэн зарчмыг баримтал гэжээ. Энэ зарчмыг ямар өвчнийг анагаахад баримтлах ёстой болхыг тогтооно уу.

- A. бадган өвчин
- B. түгмэл гүйгч хийнээс болсон өвчин
- C. Амьсгал амаргүй болох ба ханиах зэрэг өвчин
- D. Дур булгих зэрэг зарим өвчин
- E. уруу арилгагч хийг анагаах

/348./ Боловсрох чөлөөгүй халууны шинжийг тогтооно уу

- A. Хүйтнийг хүсэх
- B. Амьсгал давчдах, өвдөлт хүчтэй
- C. Эвшээж, чичирч, нүдний харц дээшээ болох
- D. Гар хөл, хүндэрч шимширч өвдөх
- E. Хамраас цус гарах

/349./ Хорын өвчний шээсний хөөсний онцлог шинжийг тогтооно уу

- A. Хөх өнгөтэй, хөөс нь том хэмжээтэй дуугарч хагарна
- B. Шар өнгөтэй хөөс нь жижиг, түргэн арилна
- C. Шүлс шиг хөөстэй, наалдамхай
- D. Улаан хөөстэй түргэн арилна
- E. Хөөс нь солонгорно

/350./ Увдисын үндэсний 90 - р бүлэгт өтлөгсдийг тэнхрүүлэх тухай номлосон байдаг. Түүний тус эрдмийг юу гэж заасан болохыг тогтооно уу

- A. Хордлого тайлах, өвчнийг анагаах, дур хүслийг бий болгох
- B. Нянг нядлах, хурсныг арилгах, тамиржуулах, идээнд дуртай болгох
- C. Хөлөргөх, шээлгэх, амьсгал уужруулах, сэтгэл санаа тайвшруулах
- D. Цөв хирийн ялгаралтыг сайжруулах, ундаасахыг багасгах,суулгалтыг зогсоох, халуун бууруулах

- E. Урт наслуулах, залуужуулах, өнгө хүчийг нэмэгдүүлэх,оюун ухааныг хурц болгох

/351./ Хорын өвчний хурсан шинжийг сонгоно уу

- A. Бие хөнгөрөх
- B. Хоолны дур арвидах
- C. Бие халуурах
- D. Ходоод халуу оргих, залхуурах
- E. Ам цангах

/352./ Суваг хавангийн ерөнхий шинжийг олно уу

- A. Түргэн хугацаанд хавагнана
- B. Хаван өлмийнөөс эхэлнэ
- C. Хэвлий томорно
- D. Хэвтсэн тал руу хаван шилжинэ
- E. Нимгэн газраар хавагнах

/353./ Эмчийн зүүн гарын дунд хуруунд эрэгтэйн ямар эрхтэний эмгэг илрэхийг тогтооно уу

- A. Зүрх гэдэс
- B. Элэг цөс
- C. Бөөр давсаг
- D. Уушги олгой
- E. Дэлүү ходоод

/354./ Нэвчрэх хэлбэрийн бор мөн чанар барагдах үе шатанд илрэх шинж тэмдгийг тодорхойлно уу?

- A. Шээс улайх
- B. Бие харлах
- C. Бөөлжих
- D. Дур хаагдах
- E. Олон эвшээх

/355./ Бөөрний гэмтсэн халууны шинжийг сонгоно уу

- A. Явж суусны дараа бөөрөөр хатгаж өвдөх
- B. Шээс чавдагшрах
- C. Өглөө босоход зовхи сэлхрэх
- D. Шээсний уур арилах нь удаан, язмаг нь хэсэглэн хуйлрах
- E. Шээс нь улаан язмагтай

/356./ Эс боловсорсон халуун өвчний судасны лугшилтын онцлог ямар болхыг тогтооно уу

- A. Нарийн түргэн балархай живэнги
- B. Ширүүн долгисож солилцон лугшина
- C. Нарийн түргэн хөлбөрөнгүй
- D. Хатуу эрчимтэй
- E. Хоосон түргэн

/357./ Бам өвчний үед шээсэнд гарах онцлог шинжийг тогтооно уу

- A. Тунгалаг ус шиг
- B. Өтгөн шар өнгөтэй
- C. Цайвар өнгөтэй
- D. Энгэсгийн зайлдас шиг өнгөтэй , муухай үнэртэй өтгөн
- E. Муухай үнэртэй, уур үнэр их

/358./ Бор ходоодонд оршвол ямар өвчний шинж үзүүлхийг тогтооно уу

- A. Шарын
- B. Хийний
- C. Бадгана
- D. Цусны
- E. Шар усны

/359./ Сэтгэл санаа уймрах, нүд улайх, цээжээр хатгуулах, зүрх мушиграх мэт өвдөх, хамар ам хатах, өвчүү ба ар нуруунд гал тавьсан мэт халуу оргиж өвдөх нь зүрхний ямар өвчний шинж болохыг тогтооно уу

- A. Зүрхний халуун дэлгэрэх
- B. Зүрхний халуун нуугдах
- C. Зүрхний хатгалга
- D. Зүрхний долгисол
- E. Зүрхний будангуйрал

/360./ Хаван өвчнийг 5 үндсэн зарчмаар эмчилдэг. Бонагийн жорыг аль зарчмын дагуу өгөх ёстойг тогтооно уу

- A. Судасны хавцлыг боох
- B. Нуурын усыг горхилон татах
- C. Сувгийн усыг замд нь оруулах

- D. Хавангийн усыг оронд нь хатаах
E. Туулгаар засахад өгнө
- /361./ Дээш гүйгч хийн гүйдэл хямралдсан үед ямар шинж илрэхийг тогтооно уу
A. Ам муруйж эрхтэний мэдэрхүй буурах, хэлгийрэх, чулчрах, тамир багасах
B. Амьсгаа авахад хүчлэх, залгиж чадахгүй, зүрх түгших, толгой эргэх
C. Зүрх мушиграх мэт санагдах, айх, үг олшрох, манарах
D. Баас, шээс хоригдох, үес өвдөх, доголох
E. Шингэхэд бэрх, идээнд үл дурлах, бөөлжих, ходоод хүйт оргих
- /362./ Хуучирсан халуун судсанд гүйсэн бол ямар эмчилгээ хийхийг тогтооно уу
A. Хэвлийн туулга өгөх
B. Судлыг дагуулан төөнөх
C. Хуучирсан халуун гүйсэн судлыг шууд ханах
D. Зандан 11 өгч аль дэлгэрсэн судлыг ханах
E. Оюу – 8 өгөх
- /363./ Дэлүүний цусаар хөөх өвчний шинжийг олно уу
A. Уруулд өнгөр тогтох
B. Шингээлт муудаж хэхрэх
C. Нүүр шарлаад хөөж хоржигнох
D. Нүүр борлох
E. Хатгуулах
- /364./ Судасны хэрх өвчний шинжийг олно уу
A. Яс халуун оргих
B. Махны өнгө харлах
C. Уушиг зүрх дэлсэх
D. Үес гэмтэх
E. Хөшиж өвдөх
- /365./ Цусны өвчнийг үүсгэх идээний нөхцөлийг тогтооно уу
A. Үхрийн сүү, хонины мах
B. Сонгино сармис, архи мэт исгэлэн хурц идээ
C. Гахайн мах, халиуны мха, үрсийн тос
D. Хуурсан будаа, нэгшсэн мах
E. Бүрэлдээгүй тараг, түүхий ногоо
- /366./ Бөөр доргих өвчний үед ямар махбод илүү хямралдахыг тогтооно уу
A. Цус
B. Шар
C. Хий
D. Бадган
E. Хорхой
- /367./ “Анагаах ухааны 4 үндэс” зохиолын “Номлохуйн үндэс”-т заасанчлан дээш гүйгч хий өвчний үе дэх эм уух ёсыг сонгоно уу?
A. Идээ эс идсэн цагт
B. Идээний өмнө
C. Идээний дунд
D. Идээний эцэст
E. Идээний завсарт
- /368./ Өөрөө боловсрох халууны шинжийг олно уу?
A. Идээнд дуртай болох
B. Нүдний судал улайж нулимс гоожих
C. Жихүүцэж даардас хүрэх
D. Махны өнгө хөхрөх
E. Толгой хүчтэй хатгах
- /369./ Цусны өвчний шээсний хөөсний онцлог шинжийг тогтооно уу
A. Хөх өнгөтэй, хөөс нь том хэмжээтэй дуугарч хагарна
B. Шар өнгөтэй хөөс нь жижиг, түргэн арилна
C. Шүлс шиг хөөстэй, наалдамхай
D. Улаан хөөстэй, түргэн арилна

Е. Хөөс нь солонгорно

/370./ Судас чанга, хуйларч лугшаад бие нь халуун оргиж хатгуулж өвдөх нь давсагны ямар өвчний шинж болохыг сонгоно уу

- А. Шээс хаагдах
- В. Халуун шижин
- С. Хийн шижин
- Д. Нян хавсарсан шижин
- Е. Давсагны цанх

/371./ Халуун чанартай хорын өвчнийг анагаахад туслах идээ ундааг тогтооно уу?

- А. Битүү туурайтны мах
- В. Үхрийн шинэ мах
- С. Исгэлэн ногоо
- Д. Гахайн мах
- Е. Хонины мах

/372./ Хүч ихтэй эс шингэсэн өвчин доод биед оршвол ямар эмчилгээ хийхийг тогтооно уу

- А. Туулга
- В. Бөөлжүүлэг
- С. Нирухаар татуулах
- Д. Хануур
- Е. Бүлээн жин

/373./ Судасны хөвчний нум нь өндөр, даралт тэсвэрлэх чанар сайн, бүдүүн энтэй, махны дээр ил гарч лугших нь ямар судас болхыг тогтооно уу

- А. Хатуу
- В. Түргэн
- С. Хуйларсан
- Д. Дэлгэрэнгүй
- Е. Эрчимтэй

/374./ Зүрхний ямар эм ууснаа мэдэхгүй байна гэсээр өвчтөн ирсэн, түүний зүрхний цохилт минутанд 80-аас дээш болсноос гадна ам, хэл бадайрах, дотор муухайрах зэрэг шинжүүд илэрсэн байна. Өвчтөн ямар эм уусан байж болохыг тодорхойлно уу?

- А. 3 үрийн тан
- В. Агар 8
- С. Сорогзон 11
- Д. Мана 4
- Е. Чуна 5

/375./ Халуун дийлэнхи нуугдсан халууны шинжийг тогтооно уу?

- А. Хэл нойтон амт муу мэдрэх
- В. Нүд улайх
- С. Шээсний өнгө улаан, хувирахад бэрх
- Д. Унтсаны хойно бие хөнгөн болох
- Е. Нойргүй болох

/376./ Найруулсан хорын өвчний судасны лугшилтын онцлог ямар болхыг тогтооно уу?

- А. Нарийн түргэн балархай живэнги
- В. Ширүүн долгисож солилцон лугшина
- С. Нарийн түргэн хөлбөрөнгүй
- Д. Хатуу эрчимтэй
- Е. Хоосон түргэн

/377./ Бам өвчний үед ясны чөмгийг гэмтээвэл ямар шинж тэмдэг илрэхийг тогтооно уу

- А. Бүлх шөрмөс татах
- В. Шүд хөдлөх
- С. Хэсэг газар хавдах
- Д. Амьсгал давчдах
- Е. Буйлнаас цус гарах

/378./ Бор элгэнд оршвол ямар өвчний шинж үзүүлж болохыг тогтооно уу

- А. Шарын
- В. Хийний

- C. Бадгана
- D. Цусны
- E. Шар усны

/379./ Зүрхний халуун дэлгэрэх өвчний өвдөлтийн онцлог шинжийг тодорхойлно уу

- A. Маш хүчтэй базалж өвдөнө
- B. Хадаасаар хатгах мэт өвдөнө
- C. Зүрх мушиграх мэт өвдөнө
- D. Цээжин дээр гал тавьсан мэт төөнөж өвдөнө
- E. Хутгаар хэрчиж буй мэт өвдөнө

/380./ Хэхрүүлэх, хоосон огих, базалж өвдөх, хоржигнож суулгах нь ходоодны ямар өвчний шинж болохыг тодорхойлно уу

- A. Ходоодны бадган
- B. Ходоод тэлэгдэх
- C. Ходоод доройтох
- D. Ходоодны хий
- E. Ходоодны шар

/381./ Уушгинд халуун бүрхэгдсэн үед ямар шинж илрэхийг тогтооно уу

- A. Цэр нь утааны шүүс шиг
- B. Цэр гарахгүй хоригдох
- C. Уруул цайх
- D. Цусаар ханиах
- E. Сэвсгэр хөөстэй цэр гарна.

/382./ Гурван үрийн туулгаар туулгаж шагайны судас ханах эмчилгээ тохирдог элэгний ямар өвчин байдгийг сонгоно уу

- A. Ус алдсан
- B. Сувагт унах
- C. Элэгний оньс гэмтэх
- D. Ливганжай
- E. Дүгтав

/383./ Цус дийлэнх байж уушги, зүрхэнд нөлөөлж маханд дэлгэрч биеийн судас хөөж өвдөлт ихтэй байх нь ямар хэрхийн шинж болохыг тогтооно уу

- A. Махны хэрх
- B. Ясны хэрх
- C. Судасны хэрх
- D. Бүлх шөрмөсний хэрх
- E. Бөөрний хэрх

/384./ Бор өвчний цусны мөн чанар барагдсан клиникийн үе шатанд ямар засал үр дүнтэй болохыг тодорхойлно уу

- A. Ханах
- B. Бөөлжүүлэх
- C. Халуун хатгуур
- D. Зөөлөн шимт
- E. Туулга

/385./ Бөөрний ус алдах өвчний гол шинж тэмдэг юу байдгийг тогтооно уу

- A. Өвдөлт
- B. Ууц нуруугаар хөших
- C. Хавагнах
- D. Цусаар шээх
- E. Хамраас цус гоожих

/386./ Халуун, хурц чанартай бөгөөд туранхайг маариажуулан, тарганыг шууруулан чийрэгжүүлэх, бадган, хийг арилгах үйлдэлтэй тосыг сонгоно уу.

- A. гүнжидийн тос
- B. чөмөгний тос
- C. гичийн (юнгарын) тос
- D. өөх
- E. шар тос

- /387./ Дэвтээлэг заслын ямар халуунд хийхийг сонгоно уу
- A. Арьс маханд тархаж дэлгэрсэн халуунд
 - B. Эс боловсорсон халуунд
 - C. Саванд шунасан халууныг арилгахад
 - D. Гадар халууны омгийг дарахад
 - E. Цулын халуун
- /388./ Хийний өвчний шээсний хөөсний онцлог шинжийг тогтооно уу
- A. Хөх өнгөтэй, том хэмжээтэй дуугарч хагарна
 - B. Шар өнгөтэй жижиг, түргэн арилна
 - C. Шүлс шиг хөөстэй, наалдамхай
 - D. Улаан хөөстэй түргэн арилна
 - E. Хөөс нь солонгорно
- /389./ Давсагны дээгүүр шархирч шээсний сүвээр халуун оргиж хатгуулж өвдөх нь ямар өвчний шинж бололхыг тогтооно уу
- A. Шарын шижин
 - B. Шээс хаагдах өвчин
 - C. Цусан шижин
 - D. Нянтай хавсарсан шижин
 - E. Хүйтэн шижин
- /390./ Эс шингэсэнд шар хавсарвал ямар шинж илрэхийг тогтооно уу
- A. Толгой өвдөх, эргэх, дотор чичрэх
 - B. Дотор халуун оргих, үнэртэй зүйлээр суулгах, их ундаасах
 - C. Бие хүндрэх, бөөлжих, амт мэдрэхгүй болох
 - D. Толгой эргэж, чих шуугих
 - E. Бие хүнд, нойр их
- /391./ Саармаг судасны лугшилтыг өвчний ямар судастай эндүүрч болхыг тогтооно уу
- A. Дорой алгуур
 - B. Дорой сул
 - C. Дорой эелдэг
 - D. Дорой живэнгүй
 - E. Дорой сулхан
- /392./ Усан хаван өвчний боловсрох үе шатанд илрэх шинж тэмдэг аль болохыг тогтооно уу
- A. Хэл, буйл цайх
 - B. Хэвлийгээр өвдөх
 - C. Үе мөч хатингартах
 - D. Шингээлт муудах
 - E. Цавинд дарвал хаван мэдэгдэх
- /393./ Судасны хоосонд ямар эмчилгээ хийхийг сонгоно уу
- A. Ходоодны галын илчийг дэмжиж, тунгалаг цөвийн ялгаралтыг сайжруулах
 - B. Жин тавих
 - C. Өвчин хүндэрвэл усан хаванг засах ёсоор засна
 - D. Ороож хөлөргөх дараа нь хийн бэлчирт төөнөх
 - E. Аливаа амьтны яс хийсэн 5 рашаанд оруулах
- /394./ Гэмтсэн халууны судасны лугшилтын онцлог ямар болхыг тогтооно уу?
- A. Балархай бөгөөд чичирч таталдана
 - B. Бүдүүн дэлгэрэнгүй товойж хуйлрана
 - C. Нарийн чанга эрчимтэй
 - D. Нарийн түргэн
 - E. Огцом лугших
- /395./ Ухархай шанаагаар хатгуулах, хөмсөгний хооронд бүлтрэх мэт санагдах, чих шуугих, шүд өвдөх шинж ямар махбод хямарч толгой өвдсөний шинж болохыг тогтооно уу
- A. Бадгана
 - B. Шар
 - C. Хий
 - D. Цус
 - E. Хорхой

/396./ Жоншны үнсэн эм өгсний дараа туулгаж бөөлжүүлэх Анар 4 өгч эмчлэх нь ямар хэлбэрийн бадган өвчин үр дүнтэй болохыг тогтооно уу

- A. Аюулхайн бадган
- B. Хоолой хаагдах бадган
- C. Төмөр хагт бадгана
- D. Галын илч буурсан бадган
- E. Цагаан хэрх

/397./ Шарын бэтгийн үед ямар засал эмчилгээний үр дүнтэй болохыг тодорхойлно уу?

- A. Туулга
- B. Бөөлжүүлэг
- C. Тосон засал
- D. Эмээр эвдэх
- E. Хатгуур

/398./ Цусны өвчнийг үүсгэх идээний нөхцөлийг тогтооно уу

- A. Үхрийн сүү, хонины мах
- B. Сонгино сармис, архи мэт исгэлэн хурц идээ
- C. Гахайн мах, халиуны мах, үрсийн тос,
- D. Хуурсан будаа, нэгшсэн мах
- E. Бүрэлдээгүй тараг, түүхий ногоо

/399./ Хэрх өвчний онцлог шинжийг тогтооно уу

- A. Шээс хаагдах
- B. Амьсгаа давхцах
- C. Улбар шар цэртэй ханиах
- D. Амархан хөлөрч, хөдөлгөөн хийхэд өвдөх, мах үес шархирах
- E. Нүд улайж, цээжээр хатгах

/400./ Хямарсан халууны судасны лугшилтын онцлог шинжийг олно уу:

- A. Хатуу, түргэн
- B. Бүдүүн, чанга, хатуу
- C. Нарийн эрчимтэй
- D. Хатуу хуйлрах
- E. Живэнгүй эрчимтэй

/401./ Гурван үрийн үргэлжилсэн туулга өгч нурууны 9-р үеийг төөнөдөг эмчилгээ таардаг элэгний ямар өвчин байдгийг сонгоно уу?

- A. Элэгний халуун өвчин
- B. Элэг дэлгэрэх өвчин
- C. Элэгний хий
- D. Элэгний оньс гэмтэх
- E. Үхэр бөгтөр

/402./ Гүргэм - 7, Жуган - 8 өгөхийн зэрэгцээ ханах заслыг ямар цанх өвчний үед өгөхийг сонгоно уу

- A. Дэлүүний цанх
- B. Элэгний цанх
- C. Уушгины цанх
- D. Савны цанх
- E. Ходооны цанх

/403./ Шар усны цайвар хавангийн онцлог шинжийг тогтооно уу

- A. Олон ханиана хөөстэй цустай цэр гарна
- B. Дотор хөөж уруул цайна
- C. Бие загатнаж нууцаар хавагнана
- D. Нүд бие ,шээс шарлана
- E. Хаван амархан ихсэж багасна

/404./ Өвдөх нь тодорхой биш байснаар цус боловсруулах үйл ажиллагаа алдагддаг шинжээр илэрдэг элэгний ямар өвчин байдгийг тогтооно уу

- A. Элэгний шар
- B. Элэг доройтох
- C. Элэг бүдүүрэх

- D. Элэг унах
- E. Элэгний чийгт хүйтэн

/405./ Идээ, ундаанд дургүй болох, амьсгал амаргүй болох бөгөөд хамуу, чихига, хулгана яр, цайвар хаван, гал намс, нүдний өвчин, ханиад хижиг болж хүндрэх нь аль хэсэгт хамаархыг тогтооно уу

- A. ундаасахыг хаах
- B. өлсөхийг хаах
- C. хийлэхийг хаах
- D. цэрийг хаах
- E. бөөлжихийг хаах

/406./ Булингартсан халууны сүүлийг хэрхэн таслахыг тогтооно уу

- A. Брайву 3 тан уулгах
- B. Дэгдийн тан өгөх
- C. Сэндэнгийн тосон эм
- D. 3 шимт ясны шөл
- E. Гоньд 3 өгөх

/407./ Хийг ялгах танг тогтооно уу

- A. Лидэрийн ганц тан
- B. Жүр үрийн ганц тан
- C. Анар 3 тан
- D. Хонилон 5
- E. Дэгд 4

/408./ Цөсний бэтгийн өвчин болохыг тогтооно уу

- A. Цөв эс шингэснээс
- B. Бадганы наалдамхай бэлгэ чанар ихсэх
- C. Тунгалаг эс шингэснийг хийгээр бөөгнөрүүлснээс
- D. Гал сацуу хийн үйл ажиллагаа алдагдснаас
- E. Шар ихэссэнээс

/409./ Унаж татаж шүдээ зуурах хөөсөөр бөөлжих харанхуй болсон мэт санагдсан хэмээн ярих шинжээр илрэх ямар адын байдгийг тогтооно уу

- A. Бодь нарын ад
- B. Умартуулагч ад
- C. Солио өвчин
- D. Уяман өвчин
- E. Гариг саа

/410./ Бөөрний ус алдсан өвчний үед ямар засал хийхийг тогтооно уу

- A. Дэвтээлэг
- B. Хануур
- C. Жин
- D. Төөнүүр
- E. Түрхэж илэх засал

/411./ Хүч ихтэй эс шингэсэн өвчин доод биед оршвол ямар эмчилгээ хийхийг сонгоно уу

- A. Туулга
- B. Бөөлжүүлэг
- C. Нирухагаар татуулах
- D. Хануур
- E. Бүлээн жин

/412./ Хуучирсан халуун өвчний судасны лугшилтын онцлог ямар болхыг тогтооно уу

- A. Нарийн эрчимтэй
- B. Нарийн ёроолдоо түргэн
- C. Доороо эрчимтэй
- D. Бүдүүн чанга түргэн
- E. Балархай

/413./ Цагаан судасны өвчнийг үүсгэх шалтгаан нөхцлийг тодорхойлно уу?

- A. Эс дадсан хоол унд
- B. Өтгөн шингэний мөрийг албаар хаах

- C. Тачаал хэтэрсэн
 - D. Мэсээр тасарсан
 - E. Сэрүүн чанартай хоол хэт их идэх
- /414./ Олгойн хий дийлэнхи өвчний үед өгөх жорыг сонгоно уу
- A. Гишүүн 3
 - B. Шижид 6
 - C. Оглүнсэлжид
 - D. Агар 8
 - E. Анар 5
- /415./ Ясны чихига өвчний үед буйланд гарах өөрчлөлтийг сонго?
- A. Буйл цайх
 - B. Буйл улайж хагарах
 - C. Буйл улайж хавдах
 - D. Буйл муухай үнэртэй болох
 - E. Буйл хар хөх болох
- /416./ Шарын өвчний шээсний язмагын онцлог шинж нь аль болхыг тогтооно уу
- A. Үс бутарсан адил нарийн
 - B. Хөвөн мэт зузаан
 - C. Хялгас мэт нарийн жижиг
 - D. Язмаг нь үүл адил
 - E. Элс шиг ёроолдоо тунана
- /417./ Элэгний цайвар хавангийн онцлог шинжийг тогтооно уу
- A. Олон ханиана хөөстэй цустай цэр гарна
 - B. Дотор хөөж уруул цайна
 - C. Бие загатнаж нууцаар хавагнана
 - D. Нүд бие ,шээс шарлана
 - E. Хаван амрхан ихсэж багасна
- /418./ Нүдний судас гүрвийж, хэл ам хуурай ширүүн болох нь зүрхний ямар өвчний шинж болохыг тодорхойлно уу
- A. Зүрхний долгиол
 - B. Зүрхний шар ус
 - C. Зүрх хийгээр хатгах
 - D. Зүрхний хатгалга
 - E. Зүрхний будангуйрал
- /419./ Язгуурын ангилалд багтах шарын өвчнийг тогтооно уу?
- A. Шингээгч шар
 - B. Бүтээгч шар
 - C. Өнгө урвуулагч шар
 - D. Өнгө тодруулагч шар
 - E. Цөсний ам алдрах шар
- /420./ Өвчин хураагдсан үеийн шинжийг сонгоно уу
- A. Хоолонд дурлах
 - B. Хөлрөхөө зогсох, өвдөлт намдах
 - C. Ханиах нь зогсох
 - D. Нойр ихсэх
 - E. Судас нь хуйларч чанга болох
- /421./ Хорын өвчний 3 гэмд нөлөөлсөн үед өгөх хураах найрлагыг сонгоно уу?
- A. Задь
 - B. Гүргэм
 - C. Гишүүнэ
 - D. Мана 4
 - E. Лишь
- /422./ Усан хаван өвчний нөхцөл аль болохыг тогтооно уу
- A. Туулга өгсний дараа идээ явдал буруудсан
 - B. Хануур хэтрэх
 - C. Давслаг амттай хоол ундыг хэтрүүлэх

- D. Биеийн хүчний хүнд ажлын дараа ус их уусан
E. Хоосорсон халууныг ханасан
- /423./ Дэлүүний цайвар хаванд ямар махбод илүү хямралдахыг тогтооно уу
A. Цус
B. Бадган
C. Шар
D. Нян хорхой
E. Шар ус
- /424./ Түгээмэл гүйгч хийн хямралдсан үед ямар шинж илрэхийг тогтооно уу
A. Ам муруйж эрхтэний мэдэрхүй буурах, хэлгийрэх, чулчрах, тамир багасах
B. Амьсгаа авахад хүчлэх, залгиж чадахгүй, зүрх түгших, толгой эргэх
C. Зүрх мушиграх мэт санагдах, айх, үг олшрох, манарах
D. Баас, шээс хоригдох, үес өвдөх, доголох
E. Шингэхэд бэрх, идээнд үл дурлах, бөөлжих, ходоод хүйт оргих
- /425./ Булингартсан халуун өвчний шалтгааныг тогтооно уу
A. Шар дийлэнх өвчин
B. Цус шарын халуун тамирт шунасан өвчин
C. Шар ус дийлэнх өвчин
D. Арилгаж засахад бэрхтэй өвчин
E. Бадган, шар хямарсан өвчин
- /426./ Өвчтнийг үзэхэд хоолой сөөж дуу доор болсон байв. Ямар махбод хямарснаас үүссэн дуу хаагдах өвчин болохыг тогтооно уу
A. Шараас болсон дуу хаагдах
B. Бадганаас болсон дуу хаагдах
C. Хийнээс болсон дуу хаагдах
D. Цуснаас болсон дуу хаагдах
E. Барагдуулагчаас болсон дуу хаагдах
- /427./ Бор сарнисан үеийн шинжийг олно уу?
A. Толгой ухархайгаар өвдөх
B. Аюулхай орчимд цанхайх
C. Турж эцэх
D. Утааны шүүс мэт цэр гарах
E. Нурууны үенд дарвал туслах мэт
- /428./ Хэрх өвчний үед бадган шар усыг арилгах зорилгоор эхний 5- н өдөр ямар эмчилгээ хийхийг тогтооно уу
A. Хэрхийг мөрөөс буцаагч тан
B. Мөнгөн усны талх эмийг өгөх
C. Төөнө засал
D. Шавар эмчилгээ
E. Дэвтээлгэ засал
- /429./ Хар бам өвчний үед илрэх шинж тэмдгийг тодорхойлно уу?
A. Хавдар нь цайвар өнгөтэй
B. Хавдар нь хөх өнгөтэй
C. Нүүр царай нь хөхөрч борлоно
D. Үе мөч хатингартана
E. Бие ядарч сульдана
- /430./ Бадганы ямар бэлгэ чанар нь нарийн нүх сүвээр нэвтрэхэд саад болдгийг сонгоно уу
A. хүнд
B. мохдог
C. батлаг
D. хүйтэн
E. наалдамхай
- /431./ Бадган өвчний шээсний хөөсний онцлог шинжийг тогтооно уу
A. Хөх өнгөтэй, том хэмжээтэй дуугарч хагарна
B. Шар өнгөтэй жижиг, түргэн арилна
C. Шүлс хаясан мэт хөөстэй, наалдамхай

- D. Улаан хөөстэй түргэн арилна
E. Хөөс нь солонгорно
- /432./ Цуснаас болсон дуу хаагдах өвчний үед ямар засал хийхийг тодорхойлно уу
A. Тосон жин тавих
B. Жүр үрийн тан өгч бугуйн судсыг ханах
C. Төөнөх
D. Молор давсыг хамрын эм болгох
E. Бөөлжүүлэг засал хийж төөнөх
- /433./ Бадган өвчний шээсний өнгөний онцлог шинжийг тогтооно уу
A. Тод шар өнгөтэй
B. Цөөрмийн ус шиг хөхөвтөр өнгөтэй
C. Цагаан цайвар өнгөтэй
D. Тод улаан өнгөтэй
E. Энгэсгийн зайлдас мэт өнгөтэй
- /434./ Шээс улайж, цанх хөдлөх мэт өвдөх нь ямар эрхтэний гэмтсэн халуун болхыг олно уу
A. Гэдэс
B. Цөс
C. Давсаг
D. Ходоод
E. Олгой
- /435./ Ам заваарах, ходоод цанхайх, хэхрэх, бөөлжих, нүд нүүр сэлхрэх, юу эс шингэсэн нь илүү хорлох нь ямар өвчний шинж болохыг тогтооно уу
A. Цөв эс шингэсэн
B. Тунгалаг эс шингэсэн
C. Бадган салс , хэхрэх, хөших, хор мэт
D. Хий, шар , бадгантай хавсарсан
E. Хуйлрах, тогтох, цувирах, сарних
- /436./ Цайвар хаван өвчний үед оношлогоонд илрэх өөрчлөлтийг олно уу?
A. Хэл уруул улайх
B. Хумсанд хар толбо суух
C. Судас бүдүүн чанга лугших
D. Судас живэнгүй лугших
E. Хэвлийгээр хаван ихтэй
- /437./ Брай өвчний судас яаж лугшихыг тогтооно уу
A. Нарийн чичэрч лугших
B. Хөндий хоосон лугших
C. Чанга лугших
D. Бүдүүн дүүрэн лугших
E. Живэнгэ дорой лугших
- /438./ Таван үндэсний тосон эмийг ямар эрхтэний жүдлэнд өгөхийг тогтооно уу
A. Уушиг
B. Элэг
C. Бөөр
D. Зүрх
E. Дэлүү
- /439./ “Анагаах ухааны 4 үндэс” зохиолын “Язгуурын үндэс” дэх “шан шан” гэсэн шувууны нэрийг Монгол оточ Лүнриг Дандар хэрхэн тайлбарласан байдаг вэ?
A. нэг зүйл тоть
B. нэрийг орчуулж боломгүй бөгөөд монголын шонхортой төстэй шувуу болой
C. Төвд үг бөгөөд орчуулагдсаныг нь үзсэнгүй
D. богширго шувууны нэг зүйл юм
E. Энэтхэг үг бөгөөд орчуулагдсаныг нь үзсэнгүй
- /440./ Зүрхний ямар өвчинд бөөлжүүлэг засал хийгээд Жамц - 4 ийг удаан хугацаагаар уулгах тухай заасан байдгийг тодорхойлно уу?
A. Зүрх долгиох
B. Зүрхний шар ус

- С. Зүрхний хийгээр хатгах
 - D. Зүрхний цусан хатгалга
 - Е. Зүрх будангуйрах
- /441./ Бэтэг өвчний судасны лугшилтын онцлог аль болхыг тогтооно уу
- A. Бүдүүн чанга лугших
 - B. Хүч бага хөвч нарийн лугших
 - С. Нарийн живэнгүй ёроолдоо чанга лугших
 - D. Цон дээр сулхан лугших
 - Е. Сул балархай лугших
- /442./ Эмэгтэйчүүдийн хий бүрэлдсэн өвчний хүндрэлийг тогтооно уу?
- A. Бэтэг өвчин
 - B. Хаван
 - С. Цус алдалт
 - D. Солио
 - Е. Мэдрэлийн уяман өвчин
- /443./ Ерийн халуун өвчний шалтгааныг тодорхойлно уу?
- A. Хэмжээнээсээ хэтэрсэн халуун шар
 - B. Ерөнхий шар судсанд гүйх
 - С. Дүр эс урвасан шар
 - D. Өнгө урвуулагч шар
 - Е. Өнгө тодорхойлогч шар
- /444./ Дэлүүний цусаар хөөх өвчний онцлог шинжийг тодорхойлно уу
- A. Уруулд өнгөр тогтох
 - B. Шингээлт муудаж хэхрэх
 - С. Нүүр шарлаад хөөж хоржигнох
 - D. Нүүр борлох
 - Е. Хатгуулах
- /445./ Шүд хумсанд хар толбо тогтвол ямар өвчний шинж болхыг олно уу
- A. Бие шарлах
 - B. Элэг бүдүүрэх
 - С. Элэгний бор
 - D. Элэгний цанх
 - Е. Бие харлах шар
- /446./ Цөв эс шингэснээс шалтгаалж үүсэх бэтэг аль болохыг тогтооно уу
- A. Чулуун бэтэг
 - B. Өгөрийн бэтэг
 - С. Цусан бэтэг
 - D. Хорхойн бэтэг
 - Е. Аюулхайн бэтэг
- /447./ Гэдэс хоржигнох өвчний шалтгааныг тодорхойлно уу?
- A. Шар
 - B. Бадгана
 - С. Хий
 - D. Нян хорхой
 - Е. Цус
- /448./ Бие махбод хордож, шүд ,хумс өвдөх үесийн голоор шимшрэн өвдөх зэрэг шинж тэмдгүүд 7 н тамирын боловсролтын аль үе шат алдагдсан болохыг тогтооно уу
- A. Цуснаас мах боловсрох үе
 - B. Яснаас чөмөг боловсрох үе
 - С. Чөмөгнөөс дусал боловсрох үе
 - D. Махнаас өөх боловсрох үе
 - Е. Өөхнөөс яс боловсрох үе
- /449./ Шар усны өвчин болох ёсыг тогтооно уу
- A. Элгэнд тунгалгийн цөс цөв болохдоо архи зэрэгт хорлогдсноос
 - B. Ходоодонд тунгалаг цөв ялгарах үйл ажиллагаа алдагдснаас
 - С. Элгэнд өнгө урвуулагч шарын хүч дутсанаас

D. Хий цусны гүйдэл алдагдсанаас

E. Элгэнд гэмтсэн цус хоцорсноос

/450./ Бүрхүүл хуулах эмийг тогтооно уу?

A. Жуган 25

B. Анар 4

C. Анар 8

D. Гавар 25

E. Ар үр 10

/451./ “Анагаах ухааны 4 үндэс” зохиолд «дунд зэргийн биетэй, туранхай ч бус, тарган ч бус, омог ихтэй, хурц оюунтай, өлсөж ундаасах нь их (хурдан)... » гэсэн байдаг нь ямар өвөрмөц чанартны онцлог шинж болохыг тодорхойлно уу.

A. Хийн өвөрмөц чанартан

B. Бадганы өвөрмөц чанартан

C. Хий, шар хавсарсан өвөрмөц чанартан

D. Бадган, шар хавсарсан өвөрмөц чанартан

E. Шарын өвөрмөц чанартан

/452./ Уушгины халуун бүрхэх өвчний цэрний онцлог шинжийг тодорхойлно уу.

A. Сэвсгэр хөөстэй ховхрохдоо муу

B. Давслаг шар бага

C. Идээтэй

D. Шар ногоон

E. Махны нитгэл шиг

/453./ Бадган өвчин болон хуучирсан цусны өвчний судсыг юугаар нь эндүүрч болхыг тогтооно уу

A. Эн бүдүүн

B. Эн нарийн

C. Лугшилтын тоо

D. Судасны хүч

E. Даралт тэсвэрлэх чанар

/454./ Гал сааны үүсэх шалтгааныг тодорхойлно уу?

A. Хий хямарч цагаан судсыг гэмтээх

B. Цусны халуун цагаан судсанд шунах

C. Хий цусны гүйдэл алдагдах

D. Бадганы урвалтаар хийн гүйдэл алдагдах

E. Хий шар хямрах

/455./ Дараах үесээс найман гишүүнтэд багтах ангилалын өвчний тодорхойлно уу

A. 3 гэмийг анагаах

B. Мэсийн шархыг анагаах

C. Дотор өвчнийг анагаах

D. Халуун өвчнийг анагаах

E. Хэсэг бусаг өвчнийг анагаах

/456./ Хийний өвчний үед нүдэнд гарах онцлог шинжийг тогтооно уу?

A. Харц тогтворгүй, уураглаг давхарга хөх өнгөтэй, толбогүй

B. . Харц ширүүн, дотор буланд өөхөн унжлагатай, шар өнгөтэй

C. Зовхи сэлхэрсэн, уураглаг бүрхүүл цайвар

D. Хүүхэн харааны дээд хэсэгт судас өргөссөн

E. Хүүхэн харааны доод хэсэгт толбо суусан

/457./ Эхлээд бөөлжүүлээд хэвлийд жин тавьж буцалсан ус уулгана. Хүжин эмийг дороос нь тавьж хийг гаргаад үдэш хөлийн уланд бүлээн жин тавих нь эмчилгээ нь ямар хэлбэрийн эс шингэсэн өвчинд таархыг тодорхойлно уу

A. Эс шингэснээр хэхрэх

B. Эс шингэсэн хөших

C. Эс шингэсэн бадгана салс

D. Эс шингэсэн хор мэт өвчин

E. Тунгалаг эс шингэсэн өвчин

/458./ Шээс цугларсан усан хаванд хэрэглэх, хатаах эм найрлагыг сонгоно уу?

- A. Гавлын найрлага
- B. Сэмбрүү 4
- C. Бонагийн найрлага, үнсэн найрлага
- D. Ясны найрлага
- E. Мөнгөн усны найрлага

/459./ Могойн хор эн түрүүнд ямар эрхтэн, тамирыг гэмтээж болохыг тогтооно уу

- A. Элэг
- B. Уушиг
- C. Дэлүү
- D. Зүрх, цус
- E. Мах

/460./ Усан хаван өвчнийг 5 үндсэн зарчмаар эмчилдэг .Анар 4-г аль зарчмын дагуу сонгож өгөхийг тодорхойлно уу

- A. Сувгийн усыг замд нь оруулах мэтээр анагаах
- B. Хавангийн усыг оронд нь хатаах мэт засах
- C. Туулгаар засах
- D. Нуурын усыг горхилон татах мэт засах
- E. Судасны хавцлыг боож төөнөх

/461./ Булингартсан халуун элгэнд буувал ямар шинж илрэхийг тогтооно уу

- A. Хэвлийгээр хатгуулах
- B. Элэгний судал бүдүүн чанга
- C. Нүд уруул шарлаж, дур хаагдан, хэл хөх эрээн болох
- D. Хэл цайвар, зузаан шар өнгөртэй болж, шараар суулгах
- E. Хэл хуурай ширүүн болох

/462./ Биеийн хүч багасах, үг цөөрөх, бие амаргүй болох, дурдал үл тодрох зэрэг шинж нь аль тохиолдолд илэрхийг тогтооно уу

- A. тунгалаг нэмэгдэх
- B. хий хасагдах
- C. шар нэмэгдэх
- D. бадган нэмэгдэх
- E. хий хямрах

/463./ Бор өвчний хүйтэн үе шатанд бөөлжисний онцлог шинжийг сонгоно уу

- A. Усаар
- B. Цусаар
- C. Утааны шүүс мэт өнгөтэй
- D. Энгэсгийн зайлдас мэт
- E. Гашуун исгэлэн усаар

/464./ Бөөр гэмтээд доод биед сарнисан үед эхэлж ямар засал хийхийг сонгоно уу.

- A. Дэвтээлэг
- B. Хануур
- C. Төөнүүр
- D. Жин
- E. Соруул

/465./ Хоосон халуун өвчний судасны лугшилтын онцлог ямар болхыг тогтооно уу

- A. Нарийн түргэн балархай живэнги
- B. Ширүүн долгионож солилцон лугшина
- C. Нарийн түргэн хөлбөрөнгүй
- D. Хатуу эрчимтэй
- E. Хоосон түргэн

/466./ Хүчжүүлэх жүдлэнг ямар насны хүмүүст хэрэглэхийг тогтооно уу

- A. Настай хүмүүст
- B. Залуу хүмүүст
- C. Хүүхдэд
- D. Элэгний өвчтэй хүмүүст
- E. Бөөрний өвчтэй хүмүүст

/467./ Хөврөл тогтоход усан махбод нь ямар үйлдэлтэй болохыг тодорхойлно уу

- A. бүрдэх
- B. хурах
- C. боловсрох
- D. бойжих
- E. бойжих суурь болох

/468./ Хийний өвчний шээсний язмагын онцлогийг тогтооно уу

- A. Үс бутарсан адил нарийн
- B. Хөвөн мэт зузаан
- C. Хялгас мэт нарийн жижиг
- D. Язмаг нь үүл адил
- E. Элс шиг ёроолдоо тунана

/469./ Зүрхний цусан хатгалга өвчний өвдөлтийн онцлог шинжийг тогтооно уу

- A. Маш хүчтэй базалж өвдөнө
- B. Хадаасаар хатгах мэт
- C. Зүрх мушиграх
- D. Цээжин дээр гал тавьсан мэт төөнөрч өвдөх
- E. Хутгаар хэрчиж буй мэт өвдөнө

/470./ Хуучирсан халууны эмчилгээний зарчмыг тогтооно уу?

- A. Цус шарын халууныг арилгах
- B. Махбод тэгшитгэх
- C. Дунд үед нь халуун нурам руу ус цацах мэт зарчмаар эмчлэх
- D. Сүүлд нь зөөлөн ерөндгөөр халууны урхаг гаргах
- E. Тамирт шунасан халууныг эхлээд хураах

/471./ Өвчтөний бие нь хөнгөрөн хөлрөх нь зогсох, сэтгэл амгалан болж биеийн хүч нэмэгдвэл хорын өвчний ямар хувиралт болохыг тогтооно?

- A. Өвчин боловсрох
- B. Өвчин хувирах
- C. Өвчин сарних
- D. Өвчин эдгэх
- E. Өвчин хүндрэх

/472./ Халуун хоосорч хямарвал шээсэнд ямар шинж илрэхийг тогтооно уу

- A. Шээс нь улаан өнгөтэй, хөөс ихтэй
- B. Шээс нь цайвар, язмаг ихтэй
- C. Шээс нь хөх, уур ихтэй
- D. Шээс нь нэлэнхүйдээ булингартай
- E. Шээс нь энгэсгийн зайлдас мэт

/473./ Хоол унд сойж өглөө үдэш жамц давстай ус уулгах эмчилгээ ямар хэлбэрийн эс шингэсэн өвчинд тохирхыг тогтооно уу

- A. Хүч бага эс шингэсэн
- B. Дунд зэргийн хүчтэй эс шингэсэн
- C. Хүч ихтэй эс шингэсэн
- D. Тунгалаг эс шингэсэн
- E. Цөв эс шингэсэн

/474./ Усан хаван өвчин эдгэрэх шинж тэмдэгийг тодорхойлно уу?

- A. Шээс өтгөн бөгөөд улбар шар
- B. Шээс нь хөхөвтөр хэмжээ их
- C. Их ундаасах
- D. Нүд улайх
- E. Амьсгал давхцах

/475./ Хүйтэн цанх өвчний үед илэрдэг шинж тэмдгийг сонгоно уу?

- A. Судас нарийн эрчимтэй
- B. Шар өнгөтэй зүйлээр бөөлжих
- C. Үмхийгээр хэхрүүлэх
- D. Ходоод хэвлийгээр ороож бүсэлж өвдөх
- E. Ам хатах

/476./ Усан сааны үед илрэх шинж тэмдгийг тогтооно уу

- A. Бие илчгүй болно
- B. Ам цангах
- C. Хэлний баруун тал охор
- D. Биеийн баруун тал суларна
- E. Хумс шарлана

/477./ Номлохуйн үндэст заасанчлан уг өвчин нь чухам ямар зүйлийн (ямар язгууртай) өвчин болохыг дотор зуураар нь (доторх ялгаагаар нь) юу гэж ангилдагийг тодорхойлно уу

- A. өвчний зүйл, тоо
- B. өвчний эрхэм (гол)
- C. өвчин хүчтэй болох буюу жэлдү жүрва
- D. өвчний шалтгаан
- E. өвчнийг ёсчлон ялгах

/478./ Үргэлжлэн ханиалгаж, цэр ховхрохдоо муу, өглөө үдэш сэвсгэр хөөстэй багахан цэртэй ханиалгах нь уушигны ямар өвчний шинж болохыг тодорхойлно уу

- A. Цайвар хаван
- B. Дагшиж ханиах
- C. Уушгины халуун
- D. Ус алдах
- E. Огшрон ханиах

/479./ Элэгний гэмтсэн халууны шинжийг тогтооно уу?

- A. Ханиаж чадахгүй болох
- B. Нүд нь бүлтийж санаа алдах
- C. Нүд нь улайж ходоод дүүрэх
- D. Нүд ширгэж арьс хуурайших
- E. Ходоодны цанх мэт өвдөх

/480./ Тунгалаг эс шингэсэн өвчин цаашид цувирах хэлбэрээр архагшвал ямар өвчин болж хүндрэхийг тогтооно уу

- A. Цайвар хаван , усан хаван
- B. Суваг хаван, уяман
- C. Суръяа,тулай,судасны бэтэг
- D. Бам,хор, судасны бэтэг
- E. Мүгво дэлгэрэх, дэлүүний өвчин

/481./ Хүйтэн чанартай язгуурын бэтэг өвчинг тогтооно уу?

- A. Идээний бэтэг
- B. Чулуун бэтэг
- C. Шарын бэтэг
- D. Өгөрийн бэтэг
- E. Цусан бэтэг

/482./ Мөнгөн ус дараах хорын өвчний аль ангилалд багтахыг тогтооно уу

- A. Чулууны хор
- B. Махны хор
- C. Бодьтой хор
- D. Эрдэнийн хор
- E. Өвсөн найруулгын хор

/483./ Гурван төрлийн жүдлэнгийн хэлбэрээс үр залгах жүдлэнг ямар хүнд өгөхийг тогтооно уу

- A. Жирэмсэн эмэгтэйчүүдэд
- B. Хүүхэд гарахгүй хүмүүст
- C. Эмэгтэйчүүдийн өвчин
- D. Бөөрний өвчтэй хүмүүст
- E. Элэгний өвчтэй хүмүүс

/484./ Дунд зэргийн халууныг дарах талх эмийг тогтооно уу?

- 1. Гиван - 10
- 2. Гавар - 7
- 3. Гиван - 9
- 4. Зандан -10

5. Дэгд - 4

/485./ Цагаан хэрхийн үед хэрэглэх эмүүдийг сонгоно уу?

1. Бойгар - 10
2. Бойчун - 15
3. Сэндэн - 4
4. Нару - 3
5. Юна - 4

/486./ Ямар үед хөлөргөх засал хамгийн тохиромжтой болохыг тогооно уу

1. . Өвчний эхэн үед
2. Өвчний сүүлд
3. Өвчний дунд үед
4. Хөлс үнэртэй болсон үед
5. Хөлс гарахгүй үед

/487./ Дээш гүйгч хий өвчний шинжийг олно уу?

1. Ухаан алдах
2. Үе мөч сулрах
3. Юм залгиж чадахгүй болох
4. Хэлгийрэх
5. Бөөлжих

/488./ Хямарсан халууныг засах зарчмыг тогтооно уу?

1. Биеийн тамирыг өөрийн оронд нь оруулж засах
2. Тангаар ялгаж засах
3. Шувуу нисгэх мэтээр засах
4. Эмээр нядлах
5. Махбодыг тэгшитгэх

/489./ Ходоодны брай өвчний шинжийг тодорхойлно уу?

1. Ам гашуун оргиж, толгой хүчтэй өвдөх
2. Нүүр тосорхог болж бие шарлах
3. Уруул хатаж зарим үед цэврүү гарах
4. Үргэлжлэн хэхрэх
5. Цустай суулгах

/490./ Ханахад тохиромжтой халуун өвчин аль болохыг сонгоно уу

1. Гэмтсэн халуун
2. Хямарсан халуун
3. Дэлгэрсэн халуун
4. Хорын халуун
5. Хоосорсон халуун

/491./ Шинэ халууныг нядлах танг олж тогтооно уу?

1. Дэва - 5
2. Хонлин - 5
3. Омбу - 15
4. Дэгд - 4
5. Мана - 4

/492./ Гал сааны үед илрэх шинжийг тогтооно уу?

1. Бие халуун байх
2. Арьсанд улаан ор гарах
3. Баруун тал сулрах
4. Шээс их язмагтай
5. Судас эрчимтэй

/493./ Бадган хий хавсарсан өвчин хүндэрсэн үед илэрч болох судасны лугшилтыг тодорхойлно уу

1. Загас уснаас цойлох мэтээр лугших судас
2. Ятуу идэш идэх мэт лугших судас
3. Хэсэг зогсч, хэсэг татвалзан, хэсэг хоосрон маш дорой лугших судас
4. 4 - 5 лугшсаны дараа хүч нь суларч зогсох дараа нь судасны лугшилт түргэсэх
5. 2 - 3 лугшсаны сүүлээр хүч нь буурч маш алгуур лугших

/494./ Хийгээр сарнисан шар өвчний үед илрэх шинжийг тогтооно уу?

1. Судас нарийн түргэн, хоосон
2. Толгой өвдөх
3. Ам гашуу оргих
4. Усархаг зүйлээр суулгах
5. Хэхрүүлэх

/495./ Шар усны халууны шинжийг тогтооно уу?

1. Нэг оронд хүчтэй хатгах
2. Хавагнах
3. Нүд, шээс хөхрөх
4. Загатнах
5. Идээ шингэхэд бэрх

/496./ Живэнги судасны хамаарлыг тодорхойлно уу

1. Ясанд хүртэл дарж мэдэх
2. Эсрэг судас нь дэлгэрэнгүй судас
3. Суваг хаван өвчинд илэрнэ
4. Усан хаванд илэрнэ
5. Шар ус арвидаж сарнисантай холбоотой үүснэ

/497./ Халуун өвчний үед туулгыг хэзээ өгч болохыг сонгоно уу

1. Халуун өвчин боловсорсон үед
2. Саванд унасан халууны гол засал
3. Засал цөхөрсний бурууг дарахын дээд
4. Тамир сайн хүнд хэрэглэх
5. Цагтаа тохирсон байх

/498./ Зогисолт намдахгүй үед төөнөх бэлчрийг тогтооно уу?

1. Хийн бэлчир
2. Өрцний бэлчир
3. Аюулхайн бэлчир
4. Үнхэлүүрийн хонхор
5. Элэгний бэлчир

/499./ Эмэгтэйчүүдийн хий бүрэлдсэн өвчний гол заслыг сонгоно уу

1. Хануур
2. Туулга
3. Хүйтэн жин
4. Монгол төөнө
5. Ганганы ороолт

/500./ Шээсний язмагаар юуг тогтоож болохыг олно уу

1. Халууныг тогтоох
2. Мөн чанарыг тогтоох
3. Гадар шинжийг тогтоох
4. Эндүүрлийг арилгах
5. Хүйтнийг тогтоох

/501./ Хуучирсан халууны хөшсөнийг чийгээр дэвтээх мэтээр эмчлэх зарчмын дагуу ямар найрлагыг сонгохыг тогтооно уу

1. Танчин - 10
2. Гавар - 25
3. Жуган дэжид
4. Жонлон - 5
5. Танчин - 25

/502./ Их зогисох өвчний гол шинжийг тодорхойлно уу?

1. Хоол идэх үед зогисох
2. Бага зэрэг зогисоод бүлээн юм уухад дарагдах
3. Хааяа хааяа зогисоод аяндаа дарагдах
4. Нүд бүлтийж үг хэлж чадахгүй зогисох
5. Хэхрэх үед ганц нэг зогисно

/503./ Ямар халууныг зохих ёсны эмчилгээ хийгээд уурыг нь гаргах төдий ханах ёстойг тогтооно уу

1. Нуугдсан халуун
2. Хорын халуун судсанд буусан
3. Боловсрох чөлөөгүй халуун
4. Нян хатгалга судсанд буусан
5. Онъсонд буусан халуун

/504./ Хар хэрхийн үед илрэх шинжийг тогтооно уу?

1. Жижиг үеийг гэмтээх
2. Үеэр хавдаж улайх
3. Үений өвдөлт их
4. Үеэр нужигнаж дуугарах
5. Үеэр хүйт оргих

/505./ Дараах халуун өвчнүүдээс алинд нь хөлөргөх засал тохиромжтой болохыг сонгоно уу?

1. Хижгийн халуун
2. Хоосорсон халуун
3. Мах, яс, арьсанд шунасан халуун
4. Дэлгэрсэн халуун
5. Хямарсан халуун

/506./ Галын илч буурсан бадган өвчний хүндрэл аль болохыг тогтооно уу

1. Эс шингэсэн өвчин үүсэх
2. Идээний бэтэг үүсэх
3. Аюулхайн бадган үүсэх
4. Усан хаван үүсэх
5. Цанх өвчин үүсэх

/507./ Салс ихтэй суулгах шинжээр илэрдэг гэдэсний өвчнийг олно уу?

1. Гэдэс хаагдах
2. Гэдэс мушгирах
3. Гэдэс хоржигнох
4. Гэдэс дүүрэх
5. Гэдэсний хатгалга

/508./ Шараас болсон ам цангах өвчний эмчилгээг тодорхойлно уу?

1. Бөөлжүүлнэ
2. Туулгана
3. Биеийг шимжүүлнэ
4. Дүржидийг өгнө
5. Чонын хэл уулгана

/509./ Бадарсан халууны омгийг дарах талх эмийг тогтооно уу?

1. Гавар - 3
2. Гавар - 7
3. Гавар - 9
4. Гавар - 18
5. Гавар - 25

/510./ Хуучирсан халууныг угаас нь гаргах талх эмийг тогтооно уу?

1. . Халууны хүч их бол гавар - 25
2. Халууны хүч дунд зэрэг бол зандан - 8
3. Халууны хүч бага бол гиван - 9
4. Халууны хүч их бол гавар - 3
5. Халууны хүч бага бол гавар - 25

/511./ Чих гөвдрүүтэх өвчний ангиллыг тодорхойлно уу?

1. Гөвдрүүтэх
2. Өгөрлөх
3. Эдгэрэх
4. Буглах
5. Цоорох

/512./ Бор өвчин боловсорсон үеийн шинжийг тогтооно уу

1. Энгэсгийн зайлдас мэт бөөлжих
2. Хий цус хямрах
3. Өлсөх ба жин тавихад туслах
4. Шээс үнэр уур их
5. Гал, наранд өвдөлт ихсэх

/513./ Хийгүй хуучирсан халууны шинжийг тогтооно уу?

1. Судас нарийн эрчимтэй
2. Шээсний өнгө улаан, уур замхрах нь удаан
3. Үе үе хөлрөх
4. Судас живэнги доод орондоо эрчимтэй
5. Ханасан цус нь төмрийн зэв мэт

/514./ Эмэгтэй хүний судсыг баруун гараас эхлэн оношлодог учир нь юу вэ?

1. Зүрхний сэтгэл орох сүв баруун тийш харсан
2. Сэтгэл орох сүв ром судал уруу харсан
3. Сэтгэл орох сүв арга тал уруугаа харсан
4. Сэтгэл орох сүв жонмо уруу харсан
5. Сэтгэл орох сүв билиг тал уруугаа харсан

/515./ Бадгантай хавсарсан халууны шинжийг тогтооно уу?

1. Бие хүнд оргих
2. Шээс шарлах
3. Идээ шингэхэд бэрх
4. Шээс улаан
5. Загатнах

/516./ Эрэгтэй хүнд эм судасны лугшилт илэрвэл:

1. Хөвгүүн олонтой болно
2. Охин олонтой болох
3. Язгуур үндэс тасрах
4. Урт наслах
5. Нас охор байх

/517./ Ямар халууныг ханаж болохгүй болохыг тодорхойлно уу

1. Эс боловсорсон халуун
2. Хижгийн халуун
3. Хоосорсон халуун
4. Хорын халуун
5. Хуучирсан халуун

/518./ Дэлүүнд цус бүрэлдсэн үед илрэх шинжийг тогтооно уу

1. Ходоод хоржигнох
2. Гэдэсний доод хэсгээр хатгуулах
3. Дэлүү орчмоор хатгуулах
4. Нүд улайх
5. Нүүр сэлхрэх

/519./ Давслаг амттай шар өнгийн цэр бага гардаг уушгины ямар өвчин байдгийг тодорхойлно уу

1. Уушгинд халуун дэлгэрэх
2. Дагшуур
3. Мэнгэр
4. Уушиганд халуун бүрхэх
5. Уушгины өгөр өвчин

/520./ Уушгины халуун бүрхэгдэх өвчний үед илрэх шинжийг тогтооно уу?

1. Судас живэнгүй доод орондоо эрчимтэй
2. Шар цэр гарах
3. Цээж дүүрэх
4. Улбар шар цэр гарах
5. Махны нитгэл мэт цэр гарах

/521./ Халуун өвчний үед гарах аймшигтай шинжийг тогтооно уу?

1. Шүд нь шарлаж хаг тогтох
2. Хэл нь хатаж богино болох
3. Хамар хатаж цайвар нус тогтох
4. Чих арагшаа наалдах
5. Нүд нь ширгэх

/522./ Махны брай өвчний шинжийг тодорхойлно уу?

1. Судас бүдүүн дэлгэрэнгүй товойж хуйлрах
2. Судас түргэн эрчимтэй чичирч лугших
3. Судас живэнги эрчимтэй
4. Ам хэл хатаж шээс шарлах
5. Хавдар тогтворгүй шилжинэ

/523./ Эс боловсорсон халууныг засах зарчмыг тогтооно уу?

1. Замд нь оруулж засах
2. Шувуу нисгэх мэтээр
3. Боловсруулж засах
4. Бүрхүүл хуулах ёсоор засах
5. Хураах зарчмаар засах

/524./ Хямарсан халуунд муу цусыг ялгахгүй ханавал ямар хүндрэл гархыг тогтооно уу

1. Өвчний урхаг цулд буух
2. Өвчин сарних
3. Хий босох
4. Өвчний цус үлдэж халууны урхаг гарахгүй болох
5. Халуунаар булингартал

/525./ Хийний гэмээс болсон суулгалтын онцлог аль болохыг тодорхойлно уу

1. Утааны шүүс шиг зүйлээр
2. Салслаг зүйлээр
3. Замаг мэт зүйлээр
4. Хөөсөрхөг зүйлээр
5. Цустай суулгадас

/526./ Хөлөргөх заслыг цээрлэдэг ямар халуун өвчин байдаг болохыг тогтооно уу

1. Дэлгэрсэн халуун
2. Хүч ихтэй эс боловсорсон халуун
3. Хүч багатай эс боловсорсон халуун
4. Тамир дорой өвчтөний халуун
5. Хямарсан халуун

/527./ Дэлгэрсэн халуун өвчний язгуурын ангилал аль болохыг тогтооно уу?

1. Ерөнхий шар судсанд гүйсэн өвчин
2. Сарних хэлбэрийн шар өвчин
3. Цөсний ам цалгих өвчин
4. Өвчний сурвалжит шар хэмжээнээсээ хэтэрсэн
5. Бие харлах шар өвчин

/528./ Бадганаас болсон ам цангах өвчний шинжийг тодорхойлно уу?

1. Идээ шингэхгүй болох
2. Ам заваарах
3. Бөөлжис цутгах
4. Үнэр муу мэдрэх
5. Идээ залгиж чадахгүй болох

/529./ Хатаах танг олж тогтооно уу?

1. 4 шимтийн тан
2. Танчин - 10
3. Гоньд - 3
4. Сэндэн - 9
5. Сэндэн - 3

/530./ Хий хавсарсан халууныг хамтад нь дарах талх эмийг тогтооно уу?

1. Гавар - 25
2. Омбу - 15

3. Зандан - 10

4. Агар - 10

5. Гиван - 10

/531./ Махны хэрх өвчинд ямар махбодын хямрал дийлэнхи байдгийг тодорхойлно уу

1. Цус

2. Хий

3. Шар ус

4. Бадгана

5. Хорхой

/532./ Дотроос хөөх хөлөргөх найрлагыг тогтооно уу

1. Лидэр - 7

2. Норов - 7

3. Мана - 4

4. Жапүр - 8

5. Хонлин - 5

/533./ Хийн өвчний маш хүндэрсэн үеийн шээсний шинжийг тогтооно уу?

1. Шээс нь ээдсэн сүү мэт

2. Шээс нь хурган чихний шүүс мэт

3. Шээс нь бэх ээдсэн мэт

4. Шээс нь ээдсэн зутан мэт

5. Шээс нь энгэсгийн зайлдас мэт

/534./ Элэгний усан хавангийн үүсэх эмгэг жамыг тогтооно уу?

1. Цулаас цувирсан усан хаван

2. Цус сарнисан усан хаван

3. Цөс сарнисан усан хаван

4. Цугларах хэлбэрийн усан хаван

5. Гэдэс нэвчрэх хэлбэрийн усан хаван

/535./ Шарын халууны шинжийг тогтооно уу?

1. Нүд шарлах

2. Шээс шарлах

3. Ам гашуу оргих

4. Хий огих

5. Ам заваарах

/536./ Хуучирсан халуунд ямар туулга тохиромжтойг сонгоно уу

1. Гишүүн - 3

2. Шижид - 6

3. Дэдбон - 10

4. Арүр - 5

5. Дэдбон - 4

/537./ Толгойд хий бүрэлдсэн өвчний үед илрэх шинжийг тогтооно уу

1. Дурьдатгал тодорхой бус

2. Толгой эргэх

3. Хоолны шингээлт муудах

4. Чих дүлийрэх

5. Ууц нуруу өвдөх

/538./ Уушги дэлгэрсэн өвчинд ямар судсыг ханах вэ?

1. Рүтүн

2. Зэчүн

3. Датүр

4. Дүгго

5. Чогсан

/539./ Эс боловсорсон халууны шинжийг тогтооно уу?

1. Жихүүцэх

2. Үдшийн цагаар өвдөх

3. Хамраас нус гоожих

4. Өндөр халуурах

5. Шээс улаан шар өнгөтэй болох

/540./ Хэрх өвчний ерөнхий шинжийг тодорхойлно уу ?

1. Хөдөлгөөнд өвдөлт их дуу алдах
2. Судас нарийн түргэн чичрэх
3. Яс үе сүүжний нүхээр хатгуулах
4. Залхуу хүрч турах
5. Амархан хөлрөх

/541./ Ямар халууныг зохих ёсны эмчилгээ хийсний дараа ханах ёстойг тогтооно уу?

1. Хоосорсон халууныг сэрүүн шимтээр тэжээж ханах
2. Хямарсан халууныг шууд ханах
3. Хуучирсан халууныг хурааж цусыг гамнах мэт ханах
4. Онъсонд буусан халууныг боловсруулж ханах
5. Цулын халууныг боловсруулж ханах

/542./ Хуучирсан халууныг нядлах танг олж тогтооно уу?

1. Мана - 4
2. Дэгд - 4
3. Омбу - 15
4. Танчин - 10
5. Танчин - 25

/543./ Доорхи өвчнүүдээс халуун цанхыг сонгоно уу?

1. Ходоодны хорхойн цанх
2. Олгойн хорхойн цанх
3. Олгойд хий цугларсан цанх
4. Элгэнд цус царцсан цанх
5. Гэдэсний цанх

/544./ Шанбарам өвчний эмийн эмчилгээг сонгоно уу?

1. Шудаг - 4
2. Жиданга - 7
3. Зидарга - 6
4. Шанбарам - 7
5. Мончара - 5

/545./ Халууны өвчний сүүлд хий үүсч хоосорсон халуун өвчнийг үүсгэх магадлал өндөр байдаг. Ийм учраас өвчний бүрхүүлийг хуулах зарчмаар чунга - 5 сонгоно Яагаад гэвэл энэ найрлага нь хий, халууныг хамтад нь дарах эрдэмтэй байдаг.

/546./ Суулгах өвчний үед уруу арилгагч хийн үйл ажиллагаа хямардаг. Яагаад гэвэл энэ нь хангагч бадганы хямралаар сэдээгдэж байгаа юм . Ийм учраас гэдэсний хатгалгыг анагаах зарчмаар эмчлэнэ

/547./ Нуугдсан халуун өвчин бол гаднаа хуурамч хүйтэн шинж бүхий мөн чанар нь халуун өвчин. Энэ өвчнийг тус бүрээр нь 3 ангилж үздэг. Яагаад гэвэл энэ ангилалын хүрээнд хамаарах эрхтэнүүдэд бадган хий голлон гүйнэ.

/548./ Хүйтэн чанартай усан хаван нь элэгний борын бэтгээс үүсдэг .Яагаад гэвэл элэгний өвчнүүд архагшиж удсанаас хүйтэнд шилждэг. Ийм учраас энэ өвчний үед сарнисаныг хурааж зарчмаар жүр үр -6 сонгодог

/549./ Халуун өвчний үед хийгддэг хөлөргөх заслыг дотроос хөөх, гаднаас татах хэмээн хоёр ангилдаг. Дотроос хөөх нэг найрлага нь Лидэр - 7 болно. Яагаад гэвэл энэ найрлагыг тамир дорой хүнийг хөлөргөхөд өгөхөөр заасан байдаг.

/550./ Шар ус нянгаас шалтгаалж халдвар дамжих замаар үүсдэг шинэ хэрх өвчнийг “ Манаглхантав “ сударт лидэр, 3 үр, сэндэн, бугын эврийн тангаар засахыг номлосон байдаг. Учир нь энэ тан бол эс боловсорсон үе шатанд боловсруулах зорилгоор хийх эмчилгээ юм.

/551./ Муу шар усны гэмээс шалтгаалж үүссэн тулай өвчний дэлгэрч байгаа үед өвчин ерөнхийдөө арьс цусанд оршиж байдаг. Учир нь энэ үед хий цусны хямрал илүү ява гддаг.

/552./ Эс боловсорсон халуун өвчний үндсэн шалтгаан бол бадган хий юм. Яагаад гэвэл халууны хүч нь товойж гарч чадаагүй байгаа өвчний цус тамирын цус нь сүү ус нийлэлдсэн мэт байгаа өвчний нуугдмал үе. Ийм учраас дайсныг дарах зарчмаар эмчлэх ёстой.

/553./ Зогисох өвчин нь хэсэг бусаг өвчний ангилалд багтдаг бөгөөд энэ өвчний үед дээш гүйгч хий хямардаг. Яагаад гэвэл дээш гүйгч хий нь хэвийн үед амьсгал авхуулах яриулах үйл үйлдэнэ

/554./ Хуучирсан халуун өвчин бол тамир бүхэнд шунаж удаж архагшсан өвчин. Ийм учраас боловсруулах зарчмын дагуу гагол - 4- ийг хэрэглэнэ . Яагаад гэвэл энэ найрлага нь өвчнийг боловсруулах гол тан юм

/555./ Эс боловсорсон халуун сарнисан үед борвины ясны шөл, гурван үрийн ширгээсэн тан, 6-н сайны талх эмүүдийг өгөхөөр заасан. Яагаад гэвэл нь найрлагууд сэрүүн шимт хосолсон учраас хураах үйлдэлтэй юм.

/556./ Ерөндөг-7 нь бор өвчнийг анагаах үндсэн найрлага. Энэ эм нь борын гурван цагийн хүйтэн шатанд хамгийн тохиромжтой. Яагаад гэвэл энэ үе шатанд үүссэн бэтгийг эвдэх зорилгоор хэрэглэнэ

/557./ Хар тулай өвчний эхний үед цус шар дийлэнх байдаг учраас эмчилгээний эхэнд цагаан гүгэлийг сүүтэй найруулж өгөхөөр заасан байдаг. Яагаад гэвэл энэ найрлага нь өвдөлт намдаах шар ус хатаах үйлдэлтэй.

/558./ Хэрх өвчний эмчилгээнд шар усыг хатаах найрлагууд гол болж хэрэглэгдэнэ. Яагаад гэвэл хэрх өвчин бол шар усны гэмээс шалтгаалж үүсдэг. Өөрөөр хэлбэл өвчний эмгэг жам нь тунгалаг орондоо хэвийн боловсорч чадаагүйтэй холбоотой явагддаг.

/559./ Чацга нь шар өнгөтэй хурц үнэртэй байгаа тул индра - 4, барагшун - 9 жорыг сонгох шаардлагатай. Яагаад гэвэл энэ нь шарын гаралтай суулгалт байгаа бөгөөд өвчний урхагийг гаргах зорилгоор нэмж данрог-5-р туулгавал зохино.

/560./ Хуучирсан халуун өвчин нь архаг явцтай үндэснээс гаргаж засахад бэрхтэй өвчин. Ийм учраас сарнисныг хураах зарчмын хүрээнд эмчилгээг хийнэ. Үүнд жонлон-5г өгч хурсан шинж илэрмэгц танчин -10 аар нядлах нь хорын модыг үндэснээс гаргах мэт эмчилгээ болдог.

/561./ Нуугдсан халуун бол гаднаа хүйтний хуурамч шинж бүхий манагдсан гал мэт өвчин. Ийм учраас юуны түрүүнд бүрхүүл хуулах зарчмаар жугандэжидийг сонгох ёстой Яагаад гэвэл энэ найрлага нуугдсан халуун өвчний арьс ч хэлбэрт тохирдог.

/562./ Хий дийлэнх эс боловсорсон халуунд засал эртэвдэл хий босно. Энэ үед нь борвины ясны шөлөнд гавар нэмж өгөх хэрэгтэй. Яагаад гэвэл энэ найрлага нь хий дийлэнх халууныг боловсруулах үйлдэлтэй байдаг.

/563./ Борын өвчний үед ямар ч шалтгаангүйгээр халуун исгэлэн усаар бөөлжих шинж гардаг. Яагаад гэвэл борын өвчнийг үүсгэхэд олон төрлийн шалтгаан ордог учраас өвчнийг хөдөлгөх нөхцөл тодорхой бус байдаг. Энэ шинжийг борын 3 цагийн навч гэдэг шинжид хамааруулдаг.

/564./ Онолын үндэст хошногны амсраас дотогш 1 хуруу хагаст байх атирааг завсрын атираа гэж заасан. Энд үүссэн шанбарамыг эдгэхэд хялбар хэмээн сурвалжид тэмдэглэсэн байдаг. Ийм учраас Гаранза-6 танг өгөхөд үр дүн сайтай байдаг.

/565./ Хүч ихтэй удаан хугацаагаар зогисох нь хэсэг бусаг зогисох өвчний ангилалд багтдаг. Энэ үед гал тэгшитгэгч хий хямардаг. Ийм учраас гал тэгшитгэгч хийн хямралыг тэгшитгэх зарчмаар хүчтэй туулга хэрэглэнэ

/566./ Хэрх өвчин нь муу шар уснаас шалтгаалж үүсдэг. Ийм учраас эхний 5 хоногт Жонлон - 5 танг өгөхөөр заасан. Энэ найрлага нь бадган шар усны гэмийг арилгах үйлдлийг үзүүлдэг .

/567./ Хуйларсан хэлбэрийн борыг дотор нь нэвчирсэн эс нэвчирсэн гэж ангилдаг. Ийм учраас бүрхүүл хуулах зарчмаар гантиг – 9 сонгож эмчилдэг. Гантиг 9 нь нэвчирсныг зогсоох үйлчилгээтэй юм

/568./ Тулай өвчин удаж хуучирвал өвчин бүлх, яс үест түгэж эхэлдэг. Яагаад гэвэл энэ нь шинэхэн үүссэн муу цусны гэмээс шалтгаалж байгаа хэрэг юм. Ийм учраас энэ үед сэмагийн танг эмчилгээнд хэрэглэх шаардлагатай.

/569./ Дэлгэрсэн халуун өвчин үүсэхэд цагийн нөхцөл голлоно. Ийм учраас бүрхүүл хуулах зарчмаар сэрдог -5 сонгоно . Яагаад гэвэл сэрдог 5 дэлгэрсэн халууныг анагаах анагаах хүйтэн чанартай найрлага юм

/570./ Эс боловсорсон халууныг боловсруулахгүйгээр эмчилбэл нуугдах, хуучрах, дэлгэрэх, хоосрох мэтээр бусад өвчинд шилждэг. Ийм учраас сайн боловсруулбал анагаахад хялбар бөгөөд эдгэх нь ч түргэн байдаг. Үүний тулд зөвхөн Мана-4-г тав хоног өгөх хэрэгтэй юм.

/571./ Булингартсан халууны шалтгааныг бадган гэж үздэг. Ийм учраас хураах зарчмын дагуу түлсэн давсны найрлагыг хэрэглэнэ. Яагаад гэвэл энэ жор нь муу цусыг тамирын цус болгох эрдэмтэй

/572./ Өвчтнийг үзэхэд шээс нь улбар шар өтгөн булингартай, хэл нь цайвар өнгөртэй дээр нь хийн улаан гөвдрүүтэй байлаа. Энэ өвчнийг хэрэгт дөрвөн товчооны үүднээс авч үзвэл гаднаа халууны хуурамч шинж бүхий мөн чанар нь халуун өвчин юм. Ийм учраас бүрхүүл хуулах эмчилгээний зарчмыг сонгоно.

/573./ Самсын гэмтсэн халуун өвчний гол шинжийг тогтооно уу?

- A. Гэдийж бөхийж чадахгүй болох
- B. Хөл унжирч, бадайрч өвдөх
- C. Шээс чавдагширах
- D. Нүд шарлах
- E. Амьсгал авахад бэрх

/574./ Цусны халууны шинжийг олно уу?

- A. Бага зэрэг хавагнах
- B. Ам нь гашуурч, нүд, шээс шарлах
- C. Бие хүндэрч хоол муу шингэх
- D. Нүд шээс улайх
- E. Хэсэж хатгуулах

/575./ Биеийн тамир онцгой бага, үе үе даарах, шар үс босох, учиргүй хөлрөх, үесээр өвдөх нь ямар халууны шинж болохыг тогтооно уу

- A. Хямралдсан халуун
- B. Хуучирсан халуун хийтэй хавсрах
- C. зөөлөн хямрах
- D. Хуучирсан халуун цулд буух
- E. Хуучирсан халуун саванд унасан

/576./ Хийний цайвар хавангийн онцлог шинжийг тогтооно уу

- A. Олон ханиана хөөстэй цустай цэр гарна
- B. Дотор хөөж уруул цайна
- C. Бие загатнаж нууцаар хавагнана
